## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

**2024 оны 11 дүгээр сарын 04** **Улаанбаатар хот**

| № | Зорилт /бодлогын үндэслэл/ | Зорилт | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж | Үр дүнгийн | | 2024 онд шаардлагатай хөрөнгө | | Хариуцах хэлтэс | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Суурь түвшин /2023 он/ | Зорилтот түвшин /2024 он/ | Санхүүжилтийн хэмжээ /сая төгрөг/ | Санхүүжилтийн эх үүсвэр | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | |
| | | | | | | | 145,249.9 | | | | |
| НЭГ. Хүний хөгжлийн бодлого/ Боловсролоор тэргүүлэх Сүхбаатар дүүрэг/ | | | | | | | | | | | |
| 1 (2.1.) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, “ИРГЭН ТӨВТ” үйлчилгээг нэвтрүүлнэ. | | | | | | | | | | | |
| 2.1.1Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийг дүүргийн төсвөөр шинээр барьж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | | | | | |
| 1 | ДЗДҮАХ-1.1.1 | 1.1.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгж байгууллагуудын орчинд ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл, сурталчилгаа хийж ажиллана. | Гэр хорооллын, айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгэнэ. | Ариутгал хийх нүхэн жорлонгийн тоо, Нийтийн эзэмшлийн зам талбайн хэмжээ | Ариутгалыг 14007 өрхийн бохирын цооног, нийтийн эзэмшлийн 357139.3 м2 талбайг 2 удаагийн давтамжтай хийж гүйцэтгэсэн байна. | 9,11-20 дугаар хорооны 14007 өрхийн бохирын цооног, нийтийн эзэмшлийн 357139.3 м2 талбайд 2 удаагийн давтамжтай ариутгалын ажлыг зохион байгуулана. | 700.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Баяндэмбэрэл” ХХК нь 2024 оны 04 дүгээр сарын 05-наас, 04 дугаар сарын 18-г хүртэл Сүхбаатар дүүргийн тус хороодын нутаг дэвсгэрийн шар усны үертэй холбоотойгоор айл, өрхийн жорлон, бохирын цооног хальж урссан нийтийн эзэмшлийн гудамж талбайн 79,321 мкв талбайд хийгдэхээс 79,421 мкв талбай, Бохирдсон хөрстэй хогийн цэг, тохижилтын талбайд 187,990 мкв талбайд хийгдэхээс 188,083 мкв талбай, Үерийн далан, гуу жалганд 106,399 мкв талбайд хийхээс 106,361 мкв талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг Жавелионы 0,06 хувийн уусмал ашиглан зориулалтын мананцар үүсгэгч цистерн автомашинаар 4-6 атм-ийн даралтаар шүршин халдваргүйжүүлсэн. | 100% |
| 2 | | | Дүүргийн нэгдсэн эмнэлгийг ашиглалтад оруулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ. | Хэрэгжилт хувиар | Дүүргийн эмнэлгийн барилгын ажлын явц 70%-тай байна. | Дүүргийн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттай шийдвэрлэнэ. | 5,178.9 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих ажлын нэмэлт санхүүжилт он дамжин хэрэгжих 229.5 сая төг, Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих ажлын нэмэлт ажил он дамжин хэрэгжих 6,486.6 сая төг, Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хүчилтөрөгчийн системийн ажил он дамжин хэрэгжих 1,278.8 сая төг, Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, материаллаг бааз бэхжүүлэх 5,500.0 сая төг, Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын хэсгийг вакум мэс заслын өрөө болгох засварын 2,400.0 сая төгрөг тус тус дүүргийн 2024 оны төсөвт тусган шийдвэрлэж ажилласан. | 100% |
| 3 | ДЗДҮАХ-2.1.1 | 2.1.1 Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийг дүүргийн төсвөөр шинээр барьж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Нэгдсэн эмнэлгийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | Хэрэгжилт хувиар | Дүүргийн төсвийн хөрөнгөөр эмнэлгийн төвлөрсөн ариутгал, амбулатори, лаборатори, дуран, дүрс оношилгооны тоног төхөөрөмж, компьютер тоног төхөөрөмж тавилга худалдан авах нийт 5 тэрбум төгрөгийн төсөвтэй 95 нэр төрлийн 620 ширхэг | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | 7,170.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хүчилтөрөгчийн системийн ажил он дамжин хэрэгжих 1,278.8 сая төг, Дүүргийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, материаллаг бааз бэхжүүлэх 5,500.0 сая төгрөгний 151 нэр төрлийн 3599 ширхэг нэр төрлийн бараа худалдан авсан. | 100% |
| 4 | | | Шинээр баригдаж буй Эрүүл мэндийн төвийн Нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтад хүлээн авч, амбулаторийн үйл ажиллагааг эхлүүлнэ. | Үйл ажиллагаа аар | | Амбулаторийн үйл ажиллагааг эхлүүлнэ. | 4,850.6 | Дүүргийн төсөв | НХХ | -Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр баригдсан 200 орны хүчин чадалтай, 2 блок, 5 давхар, нийт 12,000 м2 талбай бүхий Нэгдсэн эмнэлгийн барилгын А корпус буюу Поликлиникийн үйл ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс эхлүүлж, хүүхэд, дотор, мэдрэл, нүд, чих, хамар хоолой, эхо, мэс засал зэрэг төрөлжсөн мэргэшлийн 7 чиглэлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.<br>2024 онд дүүргийн төсвөөс нийт 10.0 тэрбум төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, компьютер техник хэрэгсэл олгон | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | суурилуулж, эмч, мэргэжилтнүүдэд симуляци сургалт зохион байгуулсан. | |
| 5 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1, НЗДҮАХ-2.1.5, НХТ-1.1.15, 1.1.15, ДЗДҮАХ-2.1.3 | 2.1.3 Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг тооцож, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана. | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 3 талт гэрээний хэрэгжилтэд хяналт тавин, үр дүнг тооцож ажиллана. | Гэрээний гүйцэтгэлийн дундаж | 86% | 88% | | | НХХ | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай А/122 дугаар захирамж гарсантай холбогдуулан 16 Өрхийн эрүүл мэндийн төвтэй 2024 онд хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан.<br>-Дүүргийн Засаг даргын 2024 оны Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээг дүгнэх Үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай А/275 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг гэрээний эхний хагас жилийн гүйцэтгэлийг дүгнэхэд Хангалттай буюу А-15, В-3 үнэлгээтэй байна. Жилийн эцсийн гүйцэтгэлийн 12 дугаар сард дүгнэнэ. | 100% |
| 6 | НХТЖҮЧ-2.10.1 НЗДҮАХ-2.1.3 ДЗДҮАХ-2.1.4 | 2.1.4 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлж, нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, чадавхжуулна. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Эмч, эмнэлгийн мэргэжилтэний тоо | 15 | 50 | 150.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/76 дугаар захирамжаар замын зардлыг санхүүжүүлж, Өрхийн эрүүл мэндийн төвийн 16 эмч 2024 оны 04 дүгээр сарын 01-06-ны өдрүүдэд БНСВУ Ханой хотод зохион байгуулагдсан эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндийн Олон улсын бага хуралд оролцсон.<br>-Дүүргийн Засаг даргын 2024 оны А/167 дугаар захирамжийн дагуу яаралтай тусламжийн чанарыг дээшлүүлэх, эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадварын түвшинг үнэлэх, бэлэн байдлыг сайжруулах “Дуудлага” тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 28, 05 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тэмцээнд 15 Өрхийн эрүүл мэндийн төв оролцож, Тэргүүн байрт 17-р хорооны Увидаст-Од ӨЭМТ, Дэд байрт 3-р хорооны Тэгш мэнд ӨЭМТ, Гутгаар байрт 14-р хорооны Өнөр өрх ӨЭМТ тус тус шалгарч, дүүргийн Засаг даргын Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.<br>-Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Сувилахуйн амьдрал төвтэй хамтран 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эрүүл мэндийн салбарын хөгжилд сувилагчийн оролцоо, мэргэжлийн үнэ цэнэ сэдэвт сургалт зохион байгуулж, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн 74 сувилагч хамрагдлаа.<br>-“Идэвхтэй хяналтын карт бичилт, эмчлэн эрүүлжүүлэлтийг сайжруулах нь” сэдэвт сургалт 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн 48 эмч хамрагдлаа.<br>-Дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Төр хариуцах эмийн цахимжуулалт, томуу, томуу төст өвчний үеийн эмийн хэрэглээний талаар сургалт зохион байгуулж, 26 эмч хамрагдсан.<br>-Эрүүл мэндийн төвийн төлөвлөгөөт 5 сургалтад 192, төлөвлөгөөт бус цагийн үеийн асуудлаар зохион байгуулсан 11 сургалтад 135, 6 удаагийн журнал клубт 130, нийт 22 удаагийн сургалтад 457 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. | 100% |
| 7 | МУХТ-2.1.19, НХТЖҮЧ-2.5.3, НЗДҮАХ-2.1.4, НХТ-7 ДЗДАХ-2.1.5 | 2.1.5 Эрүүл мэндийн төвийг түшиглэн “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг үе шаттай байгуулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Салбар амбулатори 1-ийн барилгын ажлын явцад хяналт тавьж ажиллана. | Барилгын ажлын гүйцэтгэлээр | 85% | 100% | | | НХХ | Сүхбаатар дүүргийн 1-6 дугаар хорооны 34723 иргэдэд үйлчлэх хүчин чадалтай Салбар 1 амбулаторийн барилгыг Улсын төсвийн хөрөнгөөр “Кенжику” ХХК- 2020 оноос эхлэн гүйцэтгэсэн. Коронавируст цар тахал болон барилгын материалын үнэ өссөнтэй холбоотойгоор барилгын ажил 4 жил он дамжин удаашралтай байсан. ЭМЯ-аас барилгын ажлыг эрчимжүүлэн гүйцэтгүүлэхээр нэмэлт гэрээ байгуулж, одоогоор барилгын ажил 90%-ийн явцтай үргэлжилж байна. | 90% |
| 8 | НХТЖҮЧ-2.6.1, 2.8.1 НЗДҮАХ-2.11 ДЗДҮАХ-2.1.6 | 2.1.6 Иргэн бүрийг нас, хүйсийн бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, “ИРГЭН ТӨВТ” эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно. | Иргэд, олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр "Эмч зөвлөж байна" цахим зөвлөмж байршуулна. | Видео зөвлөмж, контентын тоо | | 20 | 15.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/98 дугаар захирамжаар иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл хүргэх, эрүүл мэндийн зөв дадал хэвшил олгоход чиглэсэн “Эмч зөвлөж байна” цахим зөвлөмж, “Pubhealth podcast” цуврал нэвтрүүлэг бэлтгэхэд шаардлагатай 9 нэр төрлийн 14 ширхэг техник хэрэгсэл худалдан авахад 7,300,000 төгрөг шийдвэрлэсэн.<br>Хэвлэл мэдээллийн ergelt.mn, mand.mn сайтуудтай хамтран “Хавдрын тусламж үйлчилгээ”, “Тархины судасны өвчлөл” сэдвээр 2 төрлийн нэвтрүүлэг бэлтгэн, олон нийтийн цахим сүлжээнд байршуулан 2704 удаагийн үзүүлэлтээр 295 хариу үйлдэл хийгдсэн.<br>Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлд 24 удаагийн богино | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хэлбэрийн зөвлөмжийг цахим сүлжээнд байршуулж, 5732 удаагийн үзэлтээр 1573 хариу үйлдэл авлаа. | |
| 9 | | | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтээр | 50% | 90% | 15.0 | Дүүргийн төсөв | НХХ | Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2 удаагийн дэмжлэгт хяналт хийхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 89.1%, хүүхдийн тусламж үйлчилгээ 79.8%-тай үнэлэгдэн, нийт 11 зөвлөмж өгч, хэрэгжүүлсэн.<br>-Эх, барих эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай, тасралтгүй тогтмол үзүүлэх заалтын дагуу тэргүүлж буй 4 Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сурталчлах, туршлага судлах ажлын байрны туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 65 эмч, мэргэжилтэн хамруулсан.<br>-ХӨЦМ-ийн сургагч багш бэлтгэх 5 хоногийн сургалтад Эрүүл мэндийн төвийн 3 эмч хамрагдан, сургагч багш, тандагчаар бэлтгэгдсэн.<br>-ӨЭМТ-үүд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлд 33 удаагийн зурган, 1 удаагийн видео зөвлөмж цахим хуудсандаа байршуулан, 14206 иргэнд мэдээлэл хүргэсэн.<br>-Жирэмсэн эмэгтэйчүүдийг тэмбүүгийн шинжилгээнд 100% хамруулж, эерэг илэрсэн 6 жирэмсэн эх болон хавьтлыг эмчилгээнд 100% хамруулсан. 2024 онд төрөлхийн тэмбүү бүртгэгдээгүй.<br>-Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 10798 эмэгтэйгээс 3737 буюу 34,6%-ийг хамруулсан нь өмнө оны мөн үеэс 12%-иар буурсан үзүүлэлттэй байна.<br>-Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 30593 эмэгтэй хамрагдахаас 24903 буюу 81,4%-ийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 29,5%-иар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Өргөө амаржих газартай хамтран “Эрүүл эмэгтэй-Эрхэмсэг оршихуй” сэдэвт аяны хүрээнд Эрүүл мэндийн төв, Салбар амбулатори түшиглэсэн төрөлжсөн мэргэшлийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, төрөх насны 234 эмэгтэйг 4 төрлийн оношилгоо, шинжилгээнд хамруулсан.<br>-Дүүргийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/551 дүгээр захирамжийн дагуу эх, хүүхдийн үндсэн тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулж, сэргийлж болох эндэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Эх, хүүхдэд ээлтэй Өрхийн эрүүл мэндийн төв шалгаруулах уралдаан зарлан дүгнэлээ. | 100% |
| 1.2 (2.2) Иргэн бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. | | | | | | | | | | | |
| 10 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.5.1 НЗДҮАХ-2.1.7 НХТ-1 ДЗДҮАХ-2.2.1 | 2.2.1 Иргэдийг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд 1 удаа хамруулан эрүүлжүүлнэ. | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, илэрсэн өвчлөлийн хяналтын чанарыг сайжруулна. | Хамрагдалтын хувь | 41% | 50% | | | ЭМТ | “Эрт илрүүлгийн үзлэгт хэрхэн хамрагдах вэ?” сэдэвт видео танилцуулга бэлтгэн, өсвөр үе залуучуудыг үзлэгт идэвхтэй хамрагдахыг уриалж, цахимаар сурталчиллаа. https://www.facebook.com/SBDEMTov/videos/2755671777914854/<br>-Дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сөүл эмнэлэг, Рехамид эмнэлэгтэй хамтран үзлэгт хамрагдвал зохих 142444 иргэнээс 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 84333 буюу 60%-ийг хамруулж, хавдрын 339 сэжигтэй тохиолдол илрүүлэн, дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн.<br>-“Эрүүл зүрх” хөтөлбөрийн хүрээнд зүрхний эмгэг илрүүлэх үзлэгийг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ны өдрийн хооронд 3 өртөөгөөр зохион байгуулж, дүүргийн төрийн 26, хувийн хэвшлийн 25 ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн 3740 сурагчдаас 2838 (76.9%) хүүхэд хамрууллаа. Үзлэгт хамрагдсан хүүхэд бүрд зүрхний цахилгаан бичлэг хийж, төрөлжсөн мэргэшлийн зүрхний эмч зөвлөгөө, дүгнэлт гаргалаа. Үзлэгээр өөрчлөлттэй илэрсэн хүүхдүүдийг 2024 оны 07, 08 дугаар саруудад зүрхний хэт авианы оношилгоонд хамруулж, тусгай мэргэжлийн төвүүдтэй хамтран эмчилгээнд хамруулсан.<br>-Улсын Хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран “ЯВУУЛЫН ЭМНЭЛЭГ”-ийг 2024 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулж, зүрх судас, шүд, хүүхэд, чих, хамар, хоолойн эмчийн үзлэг болон зүрхний цахилгаан бичлэг, хөх, бамбай, хэвлийн ЭХО оношлогоонд 322 иргэн хамрагдсан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | | | Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулна. | Хэрэгжилтийн хувиар | 90% | 100% | 18.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн ЗДТГ-ын даргын 2024 оны А/09 дүгээр тушаалаар 20,0 сая төгрөг шийдвэрлүүлж, байгууллагын ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжих зорилгоор эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн олгов.<br>-Дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран байгууллагын 39 албан хаагчийг сард эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон өдрийн эмчилгээнд хамруулсан.<br>-Сэлбэ Нэгдсэн эмнэлэгтэй хамтран дүүргийн Засаг даргын Тамгын газар, хороодын нийт 132 албан хаагчийн эрүүл мэндийн 10 төрлийн үзлэг, шинжилгээнд хамруулллаа. | 100% |
| 12 | ХТЖҮЧ-2.8.1 НЗДҮАХ-2.1.1.1 ДЗДҮАХ-2.2.2 | 2.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн сургагч багш" бэлтгэнэ. | Сургагч багшийн тоо | | 75 | 5.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Шүд, амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, сургалтын үйл ажиллагаанд зориулж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/166 дугаар захирамжаар 3,550,000 төгрөг шийдвэрлэж, ерөнхий боловсролын 29 дүгээр тусгай сургуульд 5 ширхэг шүдний мулъяж, амны хөндийд ээлтэй хүнсний үзүүлэнгийн иж бүрдэл, 300 ширхэг шүдний сойз хүлээлгэн өгсөн. Тус сургуулийн 9-р ангийн 10 сурагчийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэх 3 удаагийн сургалтад хамруулсан. Ерөнхий боловсролын 2,3,4,29,31,45,58 дугаар сургуулийн сурагчдын дунд эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах нийт 80 үе тэнгийн сургагч багштай болсон. | 100% |
| 13 | | | Ерөнхий боловсролын сургуулийн 1-2 дугаар ангийн сурагчдын дунд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэлт хийнэ. | Эрүүлжүүлэлт хувь | | 30-аас доошгүй хувийг эрүүлжүүлнэ. | 20.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Ерөнхий боловсролын сурагчдыг шүд, амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээнд хамруулах үйл ажиллагаанд дүүргийн Засаг даргын 2024 оны А/165 дугаар захирамжаар 19,659,260 төгрөг шийдвэрлэлээ.<br>-Ерөнхий боловсролын 29, 131 дүгээр сургууль, 216 дугаар цэцэрлэгийн 1135 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, өвчлөлтэй шүдийг эмчлүүлэх, амны хөндийн эрүүл ахуйг сахих зөвлөмж бүхий "Ил захидал"-ыг эцэг эх, асран хамгаалагч нарт хүргүүлсэн.<br>-Өрхийн эрүүл мэндийн төвүүд үйлчлэх хүрээний ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 30552 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, үзлэгийн бүртгэл судалгааг тухайн боловсролын байгууллагад хүлээлгэн өгсөн.<br>-Дүүргийн Боловсролын хэлтсээр дамжуулан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт 2023-2024 оны хичээлийн жилийн зуны амралтаар эцэг, эх асран хамгаалагч нарыг хүүхэд, багачуудаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт бүрэн хамруулах, өвчилсөн шүдийг эмчлүүлэн, эрүүлжүүлж, тэдний дархлааг дэмжин, үр дүнтэй амраах чиглэл өгч ажилласан.<br>-Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Эрүүл шүд арга хэмжээний нийслэлийн төлөвлөгөө батлах тухай" А353 дугаар захирамжийн дагуу 2024-2025 оны хичээлийн жилд төр, хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн 6 настай 4155 хүүхдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар 16 шүдний эмнэлэг, 13 Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гурвалсан гэрээ байгууллаа. | 90% |
| 14 | МУХТ-2.6.1 НХТЖҮЧ-2.6.1, НЗДҮАХ-2.1.2, НХТ-8 ДЗДҮАХ-2.2.3 | 2.2.3 Сүрьеэ өвчний эрт илрүүлгийг явуулын хэлбэрт шилжүүлж, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлнэ. | Амьсгалын замын өвчлөл ТТТӨ-ийг бууруулах арга хэмжээ авах, эрсдэлт бүлгийн хүн амын сүрьеэгийн илрүүлгийг сайжруулж, эмчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын тоо | 3378 | 3700 | 10.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Дүүргийн хэмжээнд томуугаас сэргийлэх дархлаажуулалтад 15350 хүн хамрагдахаас 10221 хүн буюу 66.7%, 429 эмч, эмнэлгийн ажилтан дархлаажуулалтад хамрагдсан.<br>-Дүүргийн Засаг даргын 2024 оны А/549 дүгээр захирамжийг хэрэгжүүлэн, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, идэвхжил дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг сайжруулан ажиллах арга хэмжээний хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч нарт сургалт зохион байгуулав.<br>-Томуугийн дэгдэлт нэмэгдэж буйтай холбогдуулан Сэлбэ Нэгдсэн эмнэлэг дээр 42 ор дэлгэн ажиллуулахаар бэлтгэл хангалаа.<br>-ХӨСҮТ, Солонгосын үндэсний Сүрьеэгийн нийгэмлэг, Монголын Өрхийн ангаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо, Цагдаагийн 1,2 хэлтэс, Боловсролын хэлтэс, Хороо, Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран эрсдэлт бүлгийн 1888 иргэн, цэцэрлэг, сургуулийн 3421 багш, ажилтан буюу нийт 5309 иргэнийг сүрьеэ өвчин илрүүлэх үзлэгт хамруулж, асуумж, ярилцлагад 1950, рентген үзлэгт 1950, үүнээс сүрьеэгийн сэжигтэй 111 иргэнээс цэрний шинжилгээнд 113 иргэн хамруулж, сүрьеэгийн 8 тохиолдол оношилж, 100% эмчилгээнд хамруулав. Сүрьеэгийн халдвар илрүүлэг IGRA шинжилгээнд 65 хүүхэд хамрагдсанаар 14 IGRA эерэг тохиолдол | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | илэрч, 12 хүүхдийг 1 сар, 3 сарын горимоор сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулав. | |
| 15 | НХТЖҮЧ-2.6.1, НЗДҮАХ-2.1.2, НХТ-8 ДЗДҮАХ-2.2.4 | 2.2.4 Сургуулийн ахлах ангийн сурагчид, 18-аас дээш насны залуучуудыг БЗДХ, ХДХВ, 45-аас дээш насны иргэдийг Хепатитийн В, С вирус зэрэг халдварт өвчний эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулж, “ЭРҮҮЛ ГЭР БҮЛ-ЭРҮҮЛ ХҮҮХЭД” хөдөлгөөн өрнүүлнэ. | Зорилтот бүлгийн иргэдийн дунд БЗДХ-ын идэвхтэй илрүүлгийг сайжруулж, эмчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | БЗДХ-ын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын тоо | 2489 | 2700 | 5.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн БЗДХ,ХДХВ,ДОХ кабинетын нийт үзлэг 5617 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 3921, амбулаторийн үзлэг 1174, идэвхтэй хяналт 522 байна. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 55,7%-иар, урьдчилан сэргийлэх үзлэг 55,2%-иар, амбулаторийн үзлэг 46,8%-иар буурч идэвхтэй хяналт 12,4%-иар өссөн.<br>-Тэмбүү 88, загхүйтэн 80, трихомониазын 1 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс тэмбүү 2,4 промиль, загхүйтэн 2,7 промилиор өсч, трихомониаз 0,34 промилиор буурсан байна.<br>-Хөгжим бүжгийн консерватори, Үйлдвэр урлалын коллежийн нийт 219 оюутныг ХДХВ, тэмбүүгийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулсан. Эерэг тохиолдол илрээгүй.<br>-Сайн дурын зөвлөгөө шинжилгээнд 856 хүн хамрагдсанаас тэмбүүгийн 3 тохиолдол илрүүлж 100% эмчилгээнд хамруулсан.<br>-Цэргийн жинхэнэ албаны 2024 оны I ээлжийн татлагаар эрүүл мэндийн шалтгаанаар хасагдсан 271 залуучуудын эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, тэднийг эрүүл мэндийн идэвхтэй хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2024 оны 380 дугаар захирамжийн дагуу залуучуудын БЗДХ, шүдний өвчлөлийг илрүүлэх үзлэг, эмчилгээнд шаардлагатай оношлуур, эмчилгээний материал шийдвэрлэсэн. | 100% |
| 16 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.6.1 НЗДҮАХ-2.1.2, НХТ - 9, ДЗДҮАХ-2.2.5 | 2.2.5 Дархлаажуулалтын хамрагдалтыг сайжруулж, халдварт өвчний тохиолдлыг бууруулна | Дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тандалтыг бэхжүүлнэ. | Хамрагдалтын хувиар | 92% | 95% | | | ЭМТ | Дүүргийн хэмжээнд үндэсний товлолын дархлаажуулалтад заавал хийх үндэсний товлолын дархлаажуулалтад 21039 хүүхэд хамруулахаас 20378 хүүхэд буюу 97%-ийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 1%-иар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаар тушаалын дагуу Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс дархлаажуулалтын тандалтын мэдээг нэгтгэн, дархлаажуулалтын дараах хөнгөн хэлбэрийн урвал хүндрэлийн 3 тохиолдлыг НЭМГ болон ХӨСҮТ-д мэдээлсэн. | 97% |
| 17 | НХТЖҮЧ 2.11.1 НЗДҮАХ-2.1.6.10 ДЗДҮАХ-2.2.6 | 2.2.6 Ажил эрхэлдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдах талаар сурталчилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг эмнэлэг үйлчилгээнд хамруулна. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан эрүүл мэндийн даатгалгүй иргэдийн тоо | | 500 | 10.0 | Дүүргийн төсөв | ЭМТ | Сүрьеэ өвчтэй иргэдийн ойрын хавьтагсад, иргэд, хүнсний талонд хамрагддаг, ам бүл олуулаа, архины хамааралтай, ажил эрхэлдэггүй зэрэг 20 хорооны зорилтот бүлгийн 1774 иргэний судалгааг хороодоос авч нэгтгэв.<br>-Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 1, 2-р хэлтэстэй хамтран орон гэргүй, тэнэмэл, архины хамаарал нийт 65 орчим иргэнийг сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт хамруулж цээжний рентгенд өөрчлөлтэй 7 тохиолдлыг цэрний шинжилгээнд хамруулж, үүнээс сүрьеэгийн халдвартай хэлбэрийн 2 тохиолдол батлагдаж, эмчилгээнд хамрагдсан.<br>-ХӨСҮТ, Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгтэй хамтран сүрьеэгийн илрүүлэг үзлэгт эрсдэлт бүлэг, архины хамааралтай, орон гэргүй, сүрьеэтэй өвчтөний хавьтал иргэд болон их, дээд сургуулийн оюутан, зорилтот бүлгийн нийт 900 иргэн хамруулж, 68 сэжигтэй тохиолдол илрүүлж, 44 тохиолдлыг цэрний шинжилгээгээр тодотгон, сүрьеэгийн 1 тохиолдол батлагдаж, эмчилгээнд хамруулсан. | 100% |
| 18 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1, НЗДҮАХ-2.1.13, ДЗДҮАХ-2.2.7 | 2.2.7 Сүхбаатар сувиллын газрыг “Харвалтын дараах сэргээн засах төв” болгон өргөжүүлж, эмчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Сүхбаатар сувиллын газрыг сэргээн засах дагнасан тусламж үйлчилгээ үзүүлэх эмчилгээний нэр төрөлтэй болгон зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | НЭМГ-т тусгай зөвшөөрөл олгох хүсэлт уламжилсан. | | | | ЭМТ | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Сувиллын газрын үйл ажиллагааг сэргээн засах дагнасан тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалтаар ажиллуулахаар нийслэлийн Эрүүл мэндийн газраас Сэргээн засах төвийн Тусгай зөвшөөрлийн СЗТ-14/22-2/3611 дугаартай гэрчилгээг шинээр авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн магадлан итгэмжлэлийн үнэлгээнд 2024 оны 02 дугаар сард магадлан итгэмжлэлд хамрагдаж, 2025 оны 03 дугаар сарын 19 өдөр хүртэл 1 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн. Сэргээн засах төвийг оношийн 4 бүлэг, эмчилгээний цогц тусламж үйлчилгээ үзүүлэхээр үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ЭМДЕГ-тай гэрээ байгуулж, ах шатанд байна. | 100% |
| 19 | НХТЖҮЧ 2.4 НЗДҮАХ-2.3.4 ДЗДҮАХ-2.2.8 | 2.2.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | 100 | 100 | 9.0 | Дүүргийн төсөв | НХХ | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2024 онд 22 удаа хуралдаж, 460 хүүхэд хамрагдсанаас асаргааг шинээр тогтоолгосон 74 хүүхэд, хугацаа алдсанаас хамаарч дахин тогтоолгосон 12 хүүхэд, асаргааг сунгасан 273 хүүхэд, протез, ортопедийн хэрэгсэл авах 24 хүүхэд, хөгжлийн бэрхшээлийг тогтоолгосон 43 хүүхдэд тодорхойлолт гарган, үйлчилгээнд хамруулан ажилласан.Заалт тохирохгүй болон онош тодруулах, материалын бүрдэл дутуу 19 хүүхдийн материалыг буцааж, онош тохирохгүй 2 хүүхдийн асаргааг цуцалсан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | - Хичээлийн програмыг бие болон сэтгэхүйн онцлогт тохируулах тодорхойлолтыг 4 хүүхдэд, хамран тойрох хүрээний цэцэрлэг, сургуульд орох тодорхойлолтыг 6 хүүхдэд гарган хүргэсэн.<br>- Дүүргийн Засаг даргын 2024 оны А/160 дугаар захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжин 9,000,000 төгрөгөөр сургалтын хэрэглэгдэхүүн, ном, тоглоом, эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага зэргийг олголоо. | |
| 1.3 (2.3) Иргэдийг нийтийн бие тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана. | | | | | | | | | | | |
| 20 | | | Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн тэмцээнд дүүргийн иргэдийг оролцуулна. | Хамрагдсан хүний тоо | 3100 | 3500 | | | НХХ | “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтэд дүүргийн хэлтэс албад, 1-20 хороодын иргэд, СӨББ болон аж ахуй нэгж байгууллагын ажилтан албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн 12-17 насны сурагчдыг https://ubmarathon.hipay.mn/ хаягаар бүртгэл хийн ажилласан. Дүүргээс 3592 гаруй иргэд бүртгүүлснээс 2671 насанд хүрэгчид, 12-17 насны 526 хүүхдүүдийн бүртгэл, төлбөр төлөлтийг баталгаажуулж, энгэрийн тэмдэг олгосон. Мөн дүүргийн Биеийн тамир, спортын хорооны ажилтан албан хаагчид ОБЕГ-ын хажууд байрлаж, гүйгчдэд ус түгээх ажлыг хийж гүйцэтгэсэн. Марафон гүйлтийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гүйлтэд 43 иргэн, 26 хүүхэд нийт 69 иргэн амжилттай оролцсон.<br>-Нийслэлийн Засаг даргын 2024 оны А\1048 дугаар захирамжаар “Автомашингүй өдөр-2024” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдаж, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороо, Эрүүл мэндийн төв болон аж ахуйн нэгж байгууллагууд хамтран Хүүхдийн урлан бүтээх төвийн урд зам талбайд биеийн тамир, спортын уралдаан тэмцээн, хүнс, хоолны худалдаагаар үйлчилж, нийт 195 иргэн үйлчлүүлсэн. Мөн дүүргийн Эрүүл мэндийн төв Д.Сүхбаатарын талбайд асарт байрлан иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 100% |
| 21 | НЗДҮАХ-2.2.1. ДЗДҮАХ-2.3.1 | 2.3.1 Нийтийн биеийн тамир, спортын тэмцээн уралдааныг тогтмолжуулж, иргэдийн бие бялдрын хөгжлийг дэмжиж ажиллана. | ЕБС-ийн сурагчдын дунд Их нүүдэл шатрын тэмцээн зохион байгуулна. | Хамрагдсан хүний тоо | 360 | 480 | 8.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын А/535 захирамжаар өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах “Их нүүдэл-2024” тэмцээнийг 10 сарын 24-ний өдөр зохион байгуулж, ерөнхий боловсролын нийт 21 сургуулийн 1-12 -р ангийн 500 гаруй сурагчид оролцож, шилдгүүдийг тодрууллаа. Багийн нийлбэр дүнгээр I байрт 1-р сургуулийн баг тамирчид, II байрт 31-р сургуулийн баг тамирчид, III байрт 11, 131-р сургуулийн хамтарсан баг тамирчид тус тус шалгарсан. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Их нүүдэл-2024" өсвөрийн шатарчдын тэмцээнд 9 дүүргээс шалгарсан шилдэг 18 баг өрсөлдөж, дүүргийн 1-р сургуулийн баг тамирчид тэргүүн байрт, 31-р сургуулийн баг тамирчид 11-р байрт шалгарлаа. Тус тэмцээнд 5,620,000 төгрөг зарцуулсан. | 100% |
| 22 | | | Дүүргийн Засаг даргын нэрэмжит Спорт наадам-2024 тэмцээн зохион байгуулна. | Хамрагдсан хүний тоо | 1900 | 2000 | 85.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/92 захирамжаар төрийн байгууллагын санхүүчдийн дунд спортын 4 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, нийт 8 багийн 140 гаруй тамирчин оролцлоо. Тус тэмцээнд 27,290,000 төгрөг зарцуулсан.<br>- Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан сагсан бөмбөг 3х3, волейбол, дартс, шатар, ширээний теннис 5 төрөлт тэмцээнд 34 сургуулийн 530 сургалтын менежерүүд оролцлоо. Багийн дүнгээр III байрт Сүхбаатар дүүргийн баг тамирчид шалгарсан.<br>-2024 оны А/410 захирамжаар 52,400,000 төгрөгийг шийдвэрлэн “Багш 2024” тэмцээнийг 09 сарын 29-нөөс 10 сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулж, 26 сургуулийн 51 багийн 700 гаруй багш оролцож, шилдгүүдээ тодруулсан.<br>-Дүүргийн Засаг даргын 2024 оны А/547 захирамжаар 43,075,000 төгрөгийн санхүүжилтээр Засаг даргын нэрэмжит Спорт наадам 2024 спортын 5 төрөлт тэмцээнийг дэргэдэх хэлтэс, албадын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгууллаа. Нийт 4 удаагийн тэмцээнд 2100 гаруй тамирчин оролцож, 137,765,000 төгрөг зарцуулсан. | 90% |
| 23 | | | Спорт өдөрлөг, явган аялал зохион байгуулна. | Хамрагдсан хүний тоо | 2300 | 2400 | 10.0 | Дүүргийн төсөв | НХХ | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилтан албан хаагчдын дунд “Цасны баяр-2024” өвлийн өдөрлөгийг зохион байгуулж, 21 цэцэрлэгийн 300 гаруй албан хаагчид оролцож, 3 төрлийн бүжгийн тэмцээн зохион байгуулсан.<br>-Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан албан хаагчдын дунд “Цасны баяр-2024” өвлийн өдөрлөгийг Хандгайт амралтын | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | баазад зохион байгуулж, 250 гаруй албан хаагчид оролцож, хөгжөөнт буухиа болон олс таталтын тэмцээн зохион байгууллаа.<br>-Алхацгаая гүйцгээе хөдөлгөөнийг 2024 оны 05 сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд өрнүүлэн, "Эрүүл мэнд-Эрч хүч" хаврын аяллыг дүүргийн 1-20-р хорооны 250 гаруй ахмадуудын дунд цэвэр агаарт хөгжөөнт тэмцээн зохион байгууллаа. Тус аяны хүрээнд дүүргийн Засаг даргын А/391 захирамжаар 2024 оны 08 дугаар сарын 17-ний өдөр ЗДТГ-ын 65 ажилтан албан хаагчдын дунд Алхацгаая гүйцгээе үйл ажиллагааг зохион байгуулж, 3 км газарт явган алхуулж, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр цэвэр агаарт хичээллүүлж, 4 багт хуваагдан Волейболын тэмцээнийг зохион байгуулсан.<br>“Иргэдийн спортын XII наадам”-н явган аяллын тэмцээнд 152 иргэд, тамирчид оролцлоо. | |
| 24 | МУХТ-2.2.2.5<br>НХТЖҮЧ-3.5.4<br>НЗДҮАХ-2.2.2<br>ДЗДҮАХ-2.3.2 | 2.3.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжиж ажиллана. | Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг улс, нийслэл, олон улсын тэмцээнүүдэд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | Тоо, чанар | 320 | Хот, улс, олон улсын тэмцээнд оролцогчдын амжилтыг ахиулна. | 80.0 | Дүүргийн төсөв | НХХ | Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо 2024 оны 05 сарын 01-08, 10-12-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Азийн аварга шалгаруулах тэмцээн, Абу Даби Гранд Слам их дуулгын тэмцээнд өсвөрийн Жюү Жицүгийн 4 тамирчин оролцож, Б.Түвшинбаяр, Б.Гүндалай нар Гранд Слам их дуулгын тэмцээнд 7-р байрт, Г.Чинхүслэн Азийн аварга шалгаруулах тэмцээний багийн төрөлд 4-р байрт, Гранд Слам их дуулгын тэмцээнд 5-р байрт, Д.Чингүнжав Азийн аварга шалгаруулах тэмцээний шагналт 5-р байр, Гранд Слам их дуулгын тэмцээнээс хүрэл медаль тус тус хүртсэн. Тус тамирчдын тэмцээний зардалд дүүргийн Засаг даргын 2024 оны А/184, А/185, А/186, А/187 захирамжаар тус бүрд 3 сая, нийт 12 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>-Мөн дүүргийн Засаг даргын захирамжаар Боксчдын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон өсвөрийн шигшээ багийн 3 дасгалжуулагч, 20 сурагчийн тэмцээний зардалд 4,320,000 төгрөг шийдвэрлэсэн.<br>-ЕБС-иудын сурагчдын “100 буудалт даам”-ны аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 20 сургуулийн 150 гаруй сурагчид өрсөлдөж, 1-р байрт 4-р сургууль, 2-р байрт 1-р сургууль, 3-р байрт Дойче Шуле сургууль тус тус шалгарсан. Тус тэмцээний үеэр МУГТ Д.Эрдэнэбилэг насны ангилал бүрд 4,5-р байрт шалгарсан тамирчдад 100 буудалт даамны хөлөг, хүүг бэлэглэсэн.<br>-Цэцэрлэгийн хүүхдүүдийн "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн аварга шалгаруулах тэмцээнд дүүргийн 360 гаруй бяцхан бүжигчид, ЕБС-ийн сурагчдын "Уран хөдөлгөөнт гимнастик"-ийн аварга шалгаруулах тэмцээнд 1100 гаруй сурагчид тус тус оролцож, шилдгүүдээ тодруулллаа.<br>-ЕБС-ийн сурагчдын ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 20 сургуулийн өсвөрийн тамирчид оролцож, I байрт 31-р сургуулийн баг, II байрт 1-р сургуулийн баг, III байрт 3-р сургуулийн баг тус тус шалгарсан. | 100% |
| 25 | | | Багш дасгалжуулагч, баг тамирчдыг хот, улс, олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | Тоо, чанар | 320 | Хот, улс, олон улсын тэмцээнд оролцогчдын амжилтыг ахиулна. | 40.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын нэрэмжит ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын “Сүхбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын аварга шалгаруулах тэмцээнийг дүүргийн Засаг даргын 2024 оны А/51 захирамжаар 39,780,000 төгрөгийн санхүүжилтээр 2024 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулж, нийт 25 сургуулийн 1400 сурагч оролцсон.<br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн илгээлт болон Монгол Улсад орчин цагийн спорт, нийтийн биеийн тамир үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтаж дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд “Мөрөөдлийн гоол 2024” хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг дүүргийн Засаг даргын 2024 оны А/138 дугаар захирамжаар, 15,140,000 төгрөгийн санхүүжилтээр 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулж шилдгүүдээ тодруулллаа. Тэмцээнд эрэгтэй, эмэгтэй нийт 23 багийн 550 гаруй сурагчид оролцож, 1-р байрт 6-р сургууль 2-р байрт 71-р сургууль 3-р байрт 2-р сургууль шалгарсан. Тэмцээний насны ангилал тус бүрээс эхний I, II дугаар байрт шалгарсан багууд нийслэлийн шигшээ тэмцээнд дүүргээ төлөөлөн амжилт гарган оролцсон.<br>Нийт 2 удаагийн тэмцээнд 1950 сурагчид оролцож, 54,920,000 төгрөг зарцууллаа. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | | | Улаанбаатар лиг волейбол, сагсан бөмбөгийн тэмцээн | Тоо, чанар | 812 | 850 | 40.0 | Дүүргийн төсөв | НХХ | Сүхбаатар лиг тэмцээнд нийт 1400 сурагч оролцож, тэмцээний насны ангилал тус бүрд эхний 1,2 байрт шалгарсан багууд нийслэлийн “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын аварга шалгаруулах тэмцээнд дүүргээ төлөөлөн оролцож, сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний бага насны охидын төрөлд 16-р сургуулийн баг тамирчид Мөнгөн медаль, дунд насны охидын төрөлд 31-р сургуулийн баг тамирчид мөнгөн медалийн эздээр шалгарсан. Мөн ахлах насны төрөлд тусгай байрт 1-р сургуулийн охидын баг, Монгол, Оросын хамтарсан сургуулийн хөвгүүдийн баг тамирчид тус тус шалгарсан. | 100% |
| 27 | НХТЖҮЧ-2.5.3 НЗДҮАХ-2.2.1 ДЗДҮАХ-2.3.3 | 2.3.3 Иргэд, зорилтот бүлгүүдийн дунд бүх ард түмний, хүүхдийн, үндэсний, оюутны спортын их наадмуудыг зохион байгуулж, дүүргийн баг тамирчдыг оролцуулна. | Монголын оюутны спортын VI наадам зохион байгуулна. | Тоо, чанар | 404 | 460 | 55.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/114 захирамжаар 71,680,000 төгрөг шийдвэрлэж, 2024 оны 04 дүгээр сарын 11-нээс 05 дугаар сарын 12-ны өдрийн хооронд оюутан, залуучуудын спортын наадмыг 18-42 насны насны залуучуудын дунд зохион байгуулж, 1-20 дугаар хорооны 93 багийн 910 иргэн оролцлоо.<br>-Дартсын тэмцээний эрэгтэй багийн төрөлд I байрт 11-р хорооны баг, II байрт 19-р хорооны баг, III байрт 14-р хорооны баг, Эмэгтэй багийн төрөлд I байрт 10-р хорооны баг, II байрт 19-р хорооны баг, III байрт 6-р хорооны баг,<br>-3x3 сагсан бөмбөгийн тэмцээний Эрэгтэй багийн төрөлд I-р байрт 11-р хорооны баг, II-р байрт 10-р хорооны баг, III-р байрт 19-р хорооны баг, Эмэгтэй багийн төрөлд I-р байрт 11-р хорооны баг, II-р байрт 6-р хорооны баг, III-р байрт 10-р хорооны баг<br>-Волейболын тэмцээний Эрэгтэй багийн төрөлд I байр 14 -р хорооны баг, II байр 11 -р хорооны баг, III байр 13 -р хорооны баг, Эмэгтэй багийн төрөлд I байр 11 -р хорооны баг, II байр 18 -р хорооны баг, III байр 9 -р хорооны баг,<br>-Хөлбөмбөгийн тэмцээний 1-р байрт 14-р хорооны баг, 2-р байрт 6-р хорооны баг, 3-р байрт 5-р хорооны баг тамирчид,<br>-Сагсан бөмбөгийн тэмцээний Эрэгтэй багийн төрөлд I байрт 10-р хорооны баг, II байрт 11-р хорооны баг, III байрт 7-р хорооны баг, Эмэгтэй багийн төрөлд I байрт 9-р хорооны баг, II байрт 11-р хорооны баг, III байрт 10-р хорооны баг тус тус шалгарлаа. | 100% |
| 28 | | | Иргэдийн спортын XII наадам зохион байгуулна. | Тоо, чанар | 1590 | 1600 | 75.0 | Дүүргийн төсөв | НХХ | Засаг даргын 2024 оны А/411 захирамжаар Иргэдийн спортын XII наадмын анхан шатны тэмцээнийг спортын 9 төрлөөр (Спорт явган аялал, ширээний шагайн наадгай, Слс таталт, Софт волейбол, Дартс, Хийн дасгал, Аэробик, Волейбол, Сагсан бөмбөг) 2024 оны 08 сарын 24–нөөс 09 сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, 1-18 хорооны 122 багийн 1750 иргэд ур чадвараа сорин өрсөлдөж шилдгүүдээ тодруулсан. Нийлбэр дүнгээр 1-р байрт 16-р хорооны баг тамирчид, 2-р байрт 10-р хорооны баг тамирчид, 3-р байрт 18-р хорооны баг тамирчид тус тус шалгарлаа. Дүүргийн “Иргэдийн спортын XII наадам”-аас тэргүүн байрт шалгарсан баг тамирчид Нийслэлийн шигшээ тэмцээнд дүүргээ төлөөлөн амжилттай оролцлоо. Тус наадамд 108,530,000 төгрөг зарцуулсан. | 90% |
| 29 | НХТЖҮЧ-2.5.3 НЗДҮАХ-2.2.1 ДЗДҮАХ-2.3.4 | 2.3.4 Иргэдэд амьдралын зөв дадал хэвшил олгох, “Зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн” аян, бие бялдрын чийрэгжилтийн төвшин тогтоох сорил хөтөлбөрийг өрнүүлнэ. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-д иргэдийг хамруулна. | Тоо, чанар | 12851 | 13000 | | | НХХ | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 1 сарын хугацаатай зохион байгуулж, нийт 17 байгууллагын 715, 6 ерөнхий боловсролын сургууль, 12 цэцэрлэгийн 6836, нийт 7551 хүнээс сорил авч ажилласан. Сорилд хамрагдсан иргэдээс А үнэлгээ - 1210, В үнэлгээ – 1475, С үнэлгээ – 2352, D үнэлгээ – 528, F үнэлгээ - 186 иргэн авч, байгууллагуудын мэдээллийг нэгдсэн программд шивж оруулсан. Эрүүл мэндийн шалтгаантай 2000 иргэний мэдээллийг мэдээллийн нэгдсэн программд оруулаагүй болно. | 100% |
| 30 | НХТЖҮЧ-2.5.2 НЗДҮАХ-2.2.3 ДЗДҮАХ-2.3.5 | 2.3.5 “Спорт цогцолбор”-ын барилгын ажлын явцыг эрчимжүүлж, ашиглалтад оруулна. | Цэцэрлэгт хүрээлэн бүхий спорт цогцолборын барилгын ажлыг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Газар чөлөөлөлтийн ажил хийгдсэн, загвар зурагдаж байгаа. | Шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттай шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. | 6,000.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Сүхбаатар дүүргийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 13-р хорооны Ногоон талбайн 2, 3 гудамжинд нийт 3 га талбайд иргэдийн амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжит цэцэрлэгт хүрээлэн, дугуйн зам, спорт талбай, спортын танхимууд бүхий цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолборын төслийг хэрэгжүүлж байна. Тус ажлыг хэрэгжүүлэхээр Билгүүн монгол констракшн ХХК шалгарсан бөгөөд 2023 онд газрыг бүрэн чөлөөлж дууссан. Билгүүн монгол констракшн ХХК-н захиалгаар зураг, төсвийн ажлыг “Варм бюлдинг констракшн” ХХК зураг, төсвийн ажлыг хийж байна. Барилгын суурийн цутгалтын ажил хийгдсэн. | 30% |
| 1.4 (2.4) Сургалтын чанарыг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | ДЗДҮАХ-2.4.1 | 2.4.1 Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ. | Төрийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтэд үндэслэн зураг, төсөв боловсруулж дахин төлөвлөх, өргөтгөх, шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлнэ. | Хэрэгжилт хувиар | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 159-р сургууль, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 17 цэцэрлэгийг ашиглалтад оруулж, 960 суудал, 240 орны хүчин чадлаар нэмэгдүүлсэн. | Шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэж, барилгын болон засварын ажлыг хэрэгжүүлнэ. | 22,268.2 | Улс, нийслэл, дүүрэг | ТГУХ | Дүүргийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 2-р цэцэрлэгийн өргөтгөл барихаар 4.2 тэрбум төгрөг батлагдаж гүйцэтгэгчээр ТОТАЛ ИДЕАЛ ХХК, 75, 248-р цэцэрлэгийн өргөтгөл 4.8 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд Ванхүү ХХК барилгын ажлыг гүйцэтгэж байна. 248-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил 90%, 2-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил 30%, 75-р цэцэрлэгийн барилгын ажил эхлээгүй байна. | 40% |
| 32 | МУХТ-2.3.8 НХТЖҮЧ-2.1.1 НЗДҮАХ-2.3.1 НХТ-2.38 ДЗДҮАХ-2.4.3 | 2.4.3 Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна. | Шилдэг багш, ажилтнуудын ажлын үр дүнг тооцох, дэмжих үйл ажиллагаа зохион байгуулна. | Шалгарсан багш, ажилтны тоо | 193 | 220 | 238.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Шилдэг багш, ажилтнуудын ажлын үр дүнг тооцох, дэмжих ажлыг зохион байгуулах тухай А/476 дугаар захирамжийг төсөв, ажлын хэсэг, удирдамжийн хамт боловсруулж гаргасан. Энэхүү ажлын хүрээнд шилдэг менежменттэй сургууль, цэцэрлэг 2, шилдэг захирал 3, эрхлэгч 3, сургалтын менежер 9, цэцэрлэгийн арга зүйч 3, нийгмийн ажилтан 3, сэтгэл зүйч 3, элсэлтийн ерөнхий шалгалтаар сурагчаа 800 оноонд амжилт гаргахад дэмжлэг үзүүлсэн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 13 багш, цэцэрлэг, сургуулийн шилдэг багш, багшийн туслах 63, орон байрны нөхцөл сайжруулах 3 багшийг тус тус шалгуурын дагуу шалгаруулж, урамшуулах ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Энэхүү ажлыг зохион байгуулахад мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 250,090,000 төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн. | 100% |
| 33 | МУХТ-2.3.9 НХТЖҮЧ-2.3.2 НЗДҮАХ-2.3.2 НХТ-2.26 ДЗДҮАХ-2.4.4 | 2.4.4 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж, сурлагын чанарт хяналт тавина. | Төгсөх ангийн сурагчдын дунд Амжилтын гараа уралдааныг цахимаар зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ. | Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо | 525 | 530 | 40.0 | Дүүргийн төсөв | НХХ | -Боловсролын үнэлгээний төвтэй хамтран элсэлтийн ерөнхий шалгалтад бүртгүүлэх, мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалтыг танхим болон цахим хэлбэрээр төрийн өмчийн 26, төрийн бус өмчийн 20 сургуулийн 12 дугаар ангийн 2150 сурагчид зохион байгуулсан. -Математикийн сорил авах ажлыг төрийн өмчийн 25 сургуулийн 9 дүгээр ангийн 2950 сурагчдын дунд зохион байгуулсан. 2023-2024 оны хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтыг 2024 оны 07 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулахад төрийн болон төрийн бус өмчийн 40 сургуулийн 12 дугаар ангийн 2383 сурагч 10 судлагдахуунаар давхардсан тоогоор 11467 хүүхэд шалгагдсан. Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо 535, өнгөрсөн хичээлийн жилийн дундаж оноо 525 байна. | 100% |
| 34 | | | Ерөнхий боловсролын 159 дүгээр сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Хөгжмийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүний тоо, хүүхдийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааны үр дүн | - | Хөгжмийн иж бүрэн зэмсгээр хангаж, хамтлагтай болно. | 120.0 | Дүүргийн төсөв | НХХ | 159-р сургуулийг түшиглэн мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх төвийг дүүргийн Засаг даргын А/442 дугаар захирамжаар 19.000.000 төгрөгийн санхүүжилтээр шинээр байгуулж тохижуулсан. Тус төвийн нээлтийн үйл ажиллагаар 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж 35, 58, 71, 159 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөө өгсөн. | 100% |
| 35 | МУХЖТ-1.1.6, НХТЖҮЧ 2.4 НХТЖҮЧ-6.4.1 НЗДҮАХ-5.1.2 ХАХТ-5.1.2.3 НЗДҮАХ-2.3.3 ХАХТ-2.3.3.1 ДЗДҮАХ-2.5.1 | 2.5.1 Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн засвар, тохижилт, хөрөнгө оруулалтын ажлыг эрэмбэлэх цахим мэдээллийн сан бүрдүүлж, сургалтын орчныг сайжруулна. | Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт засвар үйлчилгээ, тохижилт, бусад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлнэ. | Төсөл арга хэмжээний тоо | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 31, 58, 131, 159-р сургууль, 42, 51, 143, 171, 248 дугаар цэцэрлэгүүдэд нийт 2.6 тэрбум төгрөгийн дээвэр, фасад, цахилгаан, эрчим хүчний засвар, шинэчлэл, гадна шугам шинээр хийх, гадна тохижилт хийх 12 төсөл, арга хэмжээг 100% бүрэн хэрэгжүүлж, 4 сургууль, 5 | ЕБС, СӨББ-ын барилгын шаардлагатай засвар, тохижилтын ажлыг хэрэгжүүлнэ. | 4,714.7 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 2-р цэцэрлэгийн барилгын засвар, 116-р сургуулийн сантехникийн засвар, 186-р тусгай цэцэрлэгийн дулааны узелийн засвар, 1-р сургуулийн сантехникийн засвар, 1-р сургуулийн цахилгааны засвар, 205-р цэцэрлэгийн барилгын засвар, Сургууль, цэцэрлэгийн цонхны засвар зэрэг 7 төсөл арга хэмжээг 3 тэрбум төгрөөр хэрэгжүүлж байна. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цэцэрлэгт хүүхдийн суралцах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн. | | | | | | |
| 36 | | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлаар мэдээллийн сан үүсгэж баяжуулна. | Тоо хэмжээ, талбайн хэмжээ | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 173 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбайн мэдээллийн санг үүсгэсэн. 1-20 дугаар хорооны 2320 ААНБ-аар Хог хаягдлын нэгдсэн мэдээллийн санг үүсгэсэн. | Нийт тохижилтын ажлыг мэдээллийн санд 100 хувь оруулна | 60.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 173 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийн төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбайн мэдээллийн санг үүсгэсэн. 1-20 дугаар хорооны 2320 ААНБ-аар Хог хаягдлын нэгдсэн мэдээллийн санг үүсгэсэн. | 100% |
| 37 | МУХТ-2.3.9 НХТЖҮЧ-2.1.1 НЗДҮАХ-2.3.7 НХТ-2.31 ДЗДҮАХ-2.5.2 | 2.5.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ, автобусны үйлчилгээ, туршлагыг нэвтрүүлэн “ГЭРТЭЭ ХАРИХ ГЭРЭЛТЭЙ ЗАМ” арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй орчин бүрдүүлнэ. | Сургуулийн хүүхдийн автобусны үйлчилгээг хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагаан ы хэрэгжилт хувиар | 5 | 7 | 366.7 | Дүүргийн төсөв | НХХ | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын өмчид 2023 онд шилжүүлсэн ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн 7 автобусыг хүлээн авч үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. Тус үйлчилгээг Өвөрсогоот-Эрдмийн хөтөч, Тоосгоны эцэс-Эрдмийн хөтөч, Тоосгоны эцэс 71-р сургууль-Сэлбэ, Баянхошуу-29-р сургууль, Зайсан-МОХС чиглэлд ажиллуулж 2024 онд давхацсан тоогоор нийт 7800 хүүхдийг аюулгүй тээвэрлэсэн. Дээрх 7 автобусыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын өмчид шилжүүлэн авч дулаан зогсоол, засвар үйлчилгээ, шатахуун, цалинд 196,9 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэн хүүхдийн аюулгүй орчин бүрдүүлэн ажилласан. Эхний хагас жилд нийт 5 автобусны үйлчилгээний зардалд 2 удаагийн тушаалаар 196,981,173 төгрөгийн зардлыг шийдвэрлэж ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарны 12-ны удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн “Сургуулийн автобус”-ны аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, сургуулийн автобусыг мэргэжлийн чиг үүргийн байгууллага болох автобус баазад шилжүүлж, засвар арчлалтыг хийлгэх үүрэг даалгаврын дагуу тус 7 автобусыг Нийслэлийн нийтийн тээврийн газрын 5 дугаар баазад 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр актаар хүлээлгэн өгөх ажлыг хийсэн. | 100% |
| 38 | НХТЖҮЧ - 2.4.3 НЗДҮАХ-2.3.7 ХАХТ-2.3.7.2 ДЗДҮАХ-2.5.3 | 2.5.3 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчинд аюулгүй байдлыг хангасан, стандартын шаардлагад нийцсэн хогийн сав, гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж, хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлнэ. | Сандал, хогийн сав байршуулна. | Тоо хэмжээ | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 256 ширхэг сандал 150ш хогийн сав байршуулсан. | Нийтийн эзэмшлийн талбайд 420 сандал, 420 хогийн сав байршуулсан байна. | 400.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Хороодоос ирүүлсэн саналын дагуу дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулах 150 ширхэг сандал, 150 ширхэг хогын савыг батлагдсан төсөв хөрөнгөд багтаан худалдан авалт хийж хүүхдийн тоглоомын талбай болон төв гудамж талбайд байршуулсан болно. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | ДЗДҮАХ-2.5.4 | 2.5.4 Хүүхэд, залуучуудын номын сангийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагаар сайжруулна. | Номын сангийн үйлчилгээг цахим үйлчилгээнд хэвшүүлэх талаар иргэдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулж, үйл ажиллагаа эхлүүлнэ. | Тоо, чанар | 850 | 2000 | 10.0 | Дүүргийн төсөв | НХХ | Үндэсний Номын сан ашиглалтад орж, дүүргийн 2150 хүүхэд, залуучуудад номын сангийн үйл ажиллагаа нээлттэйгээр танилцуулах аялыг зохион байгуулсан. Тус номын сантай хамтран цахим номын сангийн үйлчилгээг иргэдэд хэрхэн ашиглах талаарх ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор, номын сантай 5 хорооны нийгмийн ажилтан болон ахмадын хорооны 7 ажилтанд мэдээлэл өгч, номын сангийн үйл ажиллагаатай танилцуулах, ном хандивлах үйл ажиллагаа зохион байгуулсан. Мөн хороодын номын сангийн фондыг нэмэгдүүлэх зорилгоор зохиолч Ц.Ядамсүрэнгийн Анир үг номыг 30 ширхэгийг олголоо. Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд шинээр байгуулсан номын булангийн баяжилтыг хийн ажиллаж байна. | 100% |
| 40 | ДЗДҮАХ-2.5.5 | 2.5.5 “Мэргэжил сонголтын зөвлөх үйлчилгээний төв” байгуулж, сурагчдыг ажил, мэргэжлээ зөв сонгоход зөвлөн туслах үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ. | Мэргэжил сонголтын зөвлөх үйлчилгээний төвийг 159 дүгээр сургуулийг түшиглэн байгуулж, үйл ажиллагаа дэмжин ажиллана. | Зохион байгуулсан аялын тоо, хамрагдсан хүүхдийн тоо | 2400 | 3000 | 19.0 | Дүүргийн төсөв | НХХ | 159-р сургуулийг түшиглэн мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх төвийг дүүргийн Засаг даргын А/442 дугаар захирамжаар 19.000.000 төгрөгийн санхүүжилтээр шинээр байгуулж тохижуулсан. Тус төвийн нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж 35, 58, 71, 159 дүгээр сургуулийн ахлах ангийн 120 сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөө өгч ажилласан. Тус төв нь үйл ажиллагаагаа 4 дүгээр улиралд нээсэн учраас зорилтот түвшний хүүхдийг хамруулах боломжгүй байна. | 50% |
| 41 | ДЗДҮАХ-2.5.6 | 2.5.6 Ерөнхий боловсролын сургуульд “Сэтгэл зүйн танхим”-ыг нээж, үйл ажиллагаа эхлүүлнэ. | Сургуулийн сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх, дэмжих аялыг зохион байгуулна | Мэргэшүүлсэн сэтгэл зүйчдийн тоо, зохион байгуулсан аялын тоо | 19 | 26 | 18.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/94 дүгээр захирамжаар боловсролын байгууллагын удирдлага болон сэтгэл зүйчдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, нийт 125 захирал, эрхлэгч, сэтгэл зүйчид, ажилтан, албан хаагч оролцсон. Тус сургалтаар Хувь хүний хөгжлийн институтийн захирал, сэтгэл зүйч М.Алтанцэцэг “Зөөлөн ур чадвар”, Боловсролын хэлтсийн Хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан мэргэжилтэн Б.Туяа сургуулийн сэтгэл зүйчдэд кейс хэлэлцүүлэг-практик шийдвэр, Хувь хүний хөгжлийн институтийн сэтгэл зүйч Э.Мөнх-Амгалан сэтгэл зүйчдэд тулгамдаг асуудал, шийдвэрлэх арга зам зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн. Сургалтаас гарсан зөвлөмжийг нийт сургуулиудад хүргүүлж, мөрдөн ажиллаж байна. | 100% |
| 42 | МУХТ-2.3.19 НХТЖҮЧ-2.3.3 НЗДҮАХ-2.3.6 НХТ-2.3 ДЗДҮАХ-2.5.7 | 2.5.7 Багшийн аялын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын амжилт, чанарыг ахиулах зорилгоор хүүхэд, эцэг эх, багшийн цахим хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. | Цахим хичээл явуулах боломжийг бүрдүүлсэн ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлнэ. | Цахим хичээл явуулах боломж бүрдүүлсэн сургуулийн тоо | 26 | 26 | | | НХХ | 2024 онд 5 судлагдахуунаар цахим хичээл бэлтгэн medle.mn, nbgbaga.newzenler.com санд байршуулж, 25 сургууль, 2926 цахим хичээл боловсруулан даалгаврын сан бүрдүүлсэн. Ерөнхий боловсролын 22 сургууль ухаалаг, дижитал ангитай. Сургалтын 1 цагт 20-35 сурагч хичээллэдэг. Төрийн өмчийн 26 сургууль цахим платформ ашигладаг. Нэг таблетад ногдох хүүхдийн тоо 19.6, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээнд төрийн өмчийн 25 сургууль, судлагдахуун бүрээр бүрдүүлсэн цахим даалгаврын сангийн тоо 3516 байна. | 100% |
| 43 | ДЗДҮАХ-2.5.9 | 2.5.9 Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах талаарх мэдлэгийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд сурталчлан таниулах аялыг эхлүүлж, хэрэгжүүлнэ. | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад хог хаягдлын хор уршиг, түүнийг хэрхэн бууруулах, дахин ашиглах, хогийг ангилан ялгах дадал зуршлыг бий болгох талаар сургалт, сурталчилгаа хийж, таниулах аялыг зохион байгуулна. | Сургалт, сурталчилгааны тоо | Ерөнхий боловсролын 2 сургууль 113 хүүхдэд сургалт зохион байгуулсан. | 2 удаагийн сургалтад Ерөнхий боловсролын 10 сургуулийн 500 хүүхдийг хамруулна. | | | ТНААХ | 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр 217 цэцэрлэг, 281 дүгээр цэцэрлэг, 130 дугаар цэцэрлэг, Эрдмийн хөтөч цогцолбор сургууль, 71 дүгээр сургуулийн сурагчдад нийт 506 сурагчдад сургалт сурталчилгаа явуулж шаардлагатай гарын авлагаар хангаж ажилласан. | 100% |
| 1.6 (2.6) Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн чиглүүлж, тусламж үйлчилгээг сайжруулна | | | | | | | | | | | |
| 44 | МУХТ-2.5.10, 2.5.14 НХТЖҮЧ-2.5.14 НЗДҮАХ-3.1.1 | 2.6.2 Ажил эрхлэлтгүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн иргэдэд амьжиргааны бодит туслалцаа үзүүлнэ | Зорилтот бүлгийн иргэдэд тусламж, дэмжлэг үзүүлнэ. | Хамрагдсан иргэдийн тоо | 25 | 32 | 160.0 | Дүүргийн төсөв | НХХ | Эрүүл мэндийн байдал тааруу, амьжиргааны түвшин доогуур, гадаад улс руу өндөр үнэтэй эмчилгээ хийлгэх шаардлагатай 24 иргэнд дүүргийн Засаг даргын 24 удаагийн захирамжаар нийт 122,300,000 төгрөгийн тусламж олгосон.<br>-Цагдаагийн газар, Замын цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтсийн нийт 42 албан хаагчдад 210,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж, -Амьжиргааны түвшин доогуур өрх толгойлсон, өөрийн гэсэн гэр оронгүй 28 иргэнд 180,000,000 төгрөгийн 5 ханатай иж | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ-2.6.2 | | | | | | | | | бүрэн гэр олгож, нийт 94 иргэнд 512,300,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. | |
| 45 | НХТЖҮЧ-3.1.1 НЗДҮАХ-2.4.1 ДЗДҮАХ-2.6.3 | 2.6.3 Хүмүүнлэгийн чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлнэ. | Гамшгийн үеийн хариу арга хэмжээний нөөц бүрдүүлнэ. | Нөөцийн тоо, хэмжээ, төрөл | 2 | 5 | 60.0 | Дүүргийн төсөв | НХХ | Тамгын газрын даргын 2024 оны А/16 дугаар тушаалаар ''Гамшгийн онцгой байдлын үеийн нөөц бүрдүүлэх'' ажлын хүрээнд ажлын хувцас 50, борооны цув 100, усны гутал 100 ширхэг худалдан авч нөөц бүрдүүлсэн.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/116 тоот тушаалаар Монголын Улаан Загалмайн 85 жилийн ойн хүрээнд дүүргийн хүмүүнлэгийн танхимын үйл ажиллагаанд шаардагдах анхны тусламжийн цүнх, хантааз худалдан авсан.<br>-Тамгын газрын даргын 2024 оны өдрийн А/145, А/81 дүгээр тушаалаар гамшгийн эрсдэлийн үед нэн чухалд тооцогддог 7 нэр төрлийн 360 хүнсний бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлсэн. | 100% |
| 46 | | | Анхны тусламжийн сургалт зохион байгуулж, сайн дурынхны багийг идэвхжүүлнэ. | Зохион байгуулсан сургалтын тоо | 4 | 10 | 10.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн 1-20 дугаар хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийнханд 2024 оны 03 дугаар сараас 5 сарын хугацаанд анхны тусламжийн сургалтыг 10 удаа зохион байгуулж нийт 300 иргэн хамрагдсан.<br>-Тамгын газрын даргын 2024 оны А/159 дүгээр тушаалаар Бахархал-85 Спортын тэмцээн зохион байгуулж Улаан загалмайн хороон дэргэдэх Багачуудын улаан загалмай, Өсвөрийн Улаан загалмайн гишүүдийн дунд 8 төрлийн (сагсан бөмбөг, волейбол, дартс, шатар , даам, гар зураг,зохион бичлэг, ширээний теннис, шилжин явах цом)-ын төлөөх тэмцээнийг зохион байгуулсан. | 100% |
| 47 | | | Цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх Донорын өдөрлөгийг зохион байгуулна. | Зохион байгуулсан өдөрлөгийн тоо | 12 | 24 | 12.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/12 тоот тушаалаар Хүн амын дунд сайн дурын, авлагагүй донорын хөдөлгөөнийг сурталчилж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор АШУҮИС дээр 3 удаа Цусны донорын өдөрлөг зохион байгуулж 100 хүн хамрагдаж цусаа хандивласан.<br>- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/59 тоот тушаалаар Сүхбаатар дүүргийн эрчим хүчний хэрэглэгчдэд үйлчлэх төвийн 91 ажилтан албан хаагчид цусаа хандивласан.<br>- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/80 тоот тушаалаар Хүн амын дунд сайн дурын ,авлагагүй донорын хөдөлгөөнийг сурталчилж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын 60 -н албан хаагч, ажилтан хамрагдаж цусаа хандивласан.<br>- Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/80 тоот тушаалаар хүн амын дунд сайн дурын , авлагагүй донорын хөдөлгөөнийг сурталчилж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Донорын өдөрлөгийг зохион байгуулан МУИС-ийн 98 оюутан цусаа хандивласан.<br>- ШУТИС, МУБИС, Этүгэн, Сити, Билэг, Санхүү эдийн засаг, Биеийн тамирын дээд сургууль зэрэг сургуулиудад 17 удаа 1350 багш, ажилчид, оюутнуудад сурталчилгаа хийн, Цусны донорын өдөрлөг зохион байгуулж 1092 хүн хамрагдаж цусаа хандивласан.<br>- Нийт 21 удаа Цусны донорын өдөрлөгийг зохион байгуулж, 1441 хүн цусаа хандивласан байна. | 90% |
| 48 | НХТЖҮЧ-3.1.1 НЗДҮАХ-2.4.2 ДЗДҮАХ-2.6.4 | 2.6.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүний салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 90% | 100% | 30.0 | Дүүргийн төсөв | НХХ | Ээлтэй ертөнц ТББ-ын дэргэдэх Ханни зөөлөн тоглоомын үйлдвэрт ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүдийн орлогыг нэмэгдүүлэх, Нийгмийн даатгалын газрын нэг давхрын нойлын өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд ээлтэйгээр засварлаж, тохижуулахад зориулж дүүргийн Засаг даргын 2024 оны А/59, А/113 дугаар захирамжаар 17,104,000 төгрөгийг шийдвэрлэж, ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч хавтан, явган замын нөхөн сэргээлт засвар үйлчилгээг хийх ажлын хүрээнд дүүргийн 1-20 дугаар хороодын нутаг дэвсгэрт нийт 6573.2 м2 эвдрэлтэй явган зам, хөтөч хавтанг засварлахаар төлөвлөгдсөнөөс | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | засварын ажил 50 хувьтай буюу 3000 м2 орчим хавтан, явган замыг засварлаад байна. Мөн 3, 5, 8, 10, 12, 13, 15, 18, 19 дүгээр хорооны барилгын гадна шат довжоо, налуу замын ажлыг эргэлттэй, бариултай, амралтын тавцантай стандартын дагуу хийж дуусгасан.<br>- Нийгмийн халамжийн 21 нэр төрлийн үйлчилгээг цахимаар авах заавар бүхий цахим постер хийж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, хороодын пейж хуудаст байршуулан иргэдэд мэдээлэл өгч, ажилласан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах арга зүй сургалтад дүүргийн 1-20 дугаар хороодын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарыг хамруулсан.<br>-Дэлхийн цагаан таягтны өдрийг тохиолдуулан Монголын хараагүйчүүдийн үндэсний төвөөс зохион байгуулсан арга хэмжээнд харааны бэрхшээлтэй 141 иргэнийг оролцуулж, Засаг даргын 2024 оны А/526 дугаар захирамжаар 13.839.150 төгрөгийг шийдвэрлэж, эрүүл мэндийн багц олгосон.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын А/548 дугаар захирамжаар 6,709,800 төгрөгийг шийдвэрлэж, дүүргийн 1-20 дугаар хороодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 60 иргэнийг Сэлбэ нэгдсэн эмнэлэгт хүлээн авч, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцуулан, эрүүл мэндийн багц үзлэгт хамруулан, хүнсний багц олгосон. | |
| 1.7 (2.7) Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дэмжин ажиллана. | | | | | | | | | | | |
| 49 | НХТЖҮЧ-2.5.4<br>НЗДҮАХ-2.5.2.6<br>ДЗДҮАХ-2.7.1 | 2.7.1 Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна. | Ажил олгогчдын чуулганыг зохион байгуулж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | Оролцогчдын тоо | 50 | 60 | | | НХХ | 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран, дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 92 аж ахуйн нэгж, ажил олгогч, иргэдийн төлөөлөлд "Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, тус хуулийн 144 дүгээр заалтын хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлтийн маргаан зохицуулах өнөөгийн тогтолцоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн худалдан авах" талаарх, мэдээллийг өгч, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн дүүргийн ажил олгогчдын сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж ажилласан. | 100% |
| 50 | НХТЖҮЧ-2.5.1.1<br>НЗДҮАХ-2.5.2.3<br>ДЗДҮАХ-2.7.2 | 2.7.2 Ажилгүй, орлогогүй иргэдийг мэргэжлийн болон давтан сургалтаар мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэн чадавхжуулж, хөдөлмөр эрхлэхэд нь зуучилж ажиллана. | Залуучуудыг мэргэжлийн болон давтан сургалтад хамруулж, ажлын байранд зуучилна. | Сургалтад хамрагдсан иргэний тоо | 87 | 120 | | | НХХ | "Сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллага сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр 3 төрлийн 5 сургалтын байгууллагатай гэрээ байгуулж, худалдааны зөвлөх мэргэжлээр 15, нярав мэргэжлээр 15 эмэгтэйг богино хугацааны ур чадвар олгох сургалт зохион байгуулсан.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжил эзэмшүүлэх богино хугацааны танхимын сургалтад 17 иргэн, эрэлтэд нийцсэн ур чадвар олгох сургалтад ажил хайгч зорилтот бүлгийн нийт 33 иргэнийг хамруулж, байнгын ажлын байранд зуучилсан.<br>-"Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн шилдэг стартап санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд нийт 20 төсөл ирснээс 1-р шатны шалгаруулалтаар 7 төсөл, 2-р шатны шалгаруулалтаар 4 төсөл шалгарч, 3-р шатны сонгон шалгаруулалтаар 1 төсөл шалгарч 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.<br>-Нийслэлийн Хөдөлмөр, Халамжийн газарт мэргэжлийн болон давтан сургалтад суух 116 иргэний жагсаалтыг хүргүүлж, эрэлтэд нийцсэн ур чадвар олгох мэргэжлийн сургалтад 20 иргэнийг сургаж, ажлын байранд зуучилсан.<br>- Залуучуудыг мэргэжлийн болон давтан сургалтад хамруулах зар мэдээллийг цахим хуудас, хороодын ажлын албаар дамжуулан 350 иргэнд хүргэж 101 иргэнийг сургалтад хамруулж, ажлын байраар хангасан байна. | 90% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 51 | НЗДҮАХ-2.5.7 ДЗДҮАХ-2.7.3 | 2.7.3 Өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байр бий болгох, өрхийн үйлдвэрлэл, бизнесээ хөгжүүлэхэд нь дэмжин ажиллана. | Төсөл, хөтөлбөрт хамруулна. | Хамрагдсан иргэдийн тоо | 145 | 190 | | | НХХ | 2024 оны 04 дүгээр сард зарлагдсан Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох төсөл хөтөлбөрт 38 төсөл ирүүлснээс 19 иргэн шалгарч 184,169,000 төгрөг, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт 17 төсөл ирүүлснээс 8 иргэн шалгарч 43.000.000 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 26 иргэн төслөө ирүүлснээс 6 иргэний төсөл дэмжигдэж 52,000,000 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.<br>-2024 оны 09 дүгээр сард зарлагдсан Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох төсөлд 42 иргэн, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 13 иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлд 19 иргэн материалаа ирүүлж, ажлын хэсгийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын байртай танилцах ажлыг зохион байгуулж байна.<br>- Төсөл хөтөлбөр зарлагдсан тухай зар мэдээллийг цахим хуудаст байршуулан иргэдэд мэдээлэл хүргэн 2 удаагийн зарлагдсан төсөл хөтөлбөрөөр 155 иргэний төслийг хүлээн авч 33 иргэнд 279,169,000 төгрөгний санхүүжилт олгон, 74 иргэний төслийн ажлын байртай танилцах ажлыг зохион байгуулж байна. | 90% |
| 1.8 (2.8) Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ. | | | | | | | | | | | |
| 52 | НЗДҮАХ-3.5.1 НХТЖҮЧ-3.4.4 МУХТЖҮЧ-3.3.1 ДЗДҮАХ-2.8.1 НЗДҮАХ-3.5.1 ДЗДҮАХ-2.8.1, 5.2.8 | 2.8.1. Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг технологийн шийдлээр дэмжихэд анхаарч, бүтээгдэхүүнийг сурталчилна. | "Сүхбаатар дүүрэгт үйлдвэрлэв" борлуулалтын цэг болон сургалт мэдээллийн төвийн цахим хуудсаар дамжуулан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо, борлуулалтын орлого | Дүүргийн 20 үйлдвэрлэл эрхлэгчдийн барааг сурталчилж, 6.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн. | Дүүргийн үйлдвэрлэл эрхлэгч 70 иргэний бүтээгдэхүүнийг борлуулсан байна. | 5.0 | Дүүргийн төсөв | ЖДҮДТ | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн, дэмжих төвийн дэргэдэх “Сүхбаатар дүүрэгт үйлдвэрлэв” борлуулалтын цэгийг тогтмол хуваарийн дагуу ажиллуулж, 114 үйлдвэрлэл эрхлэгчдийн үндэсний болон европ загварын хувцас, өв соёл шингэсэн цар, домбо, мөнгөн эдлэл, эсгий тавчиг, арьсан гутал, цүнх, ноос ноолууран хувцас, хүүхдийн болон том хүний биеийн тамирын хувцас, бэлэг дурсгалын үнэртүүлэгч лаа, модон эдлэл зэрэг 90 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг байршуулан, сурталчлан худалдаалж, нийт 8,103,000 мян.төгрөгийн борлуулалт хийсэн. | 90% |
| 53 | | | Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэлийг шинэчилж, интернет орчны үйлчилгээ үзүүлэх "Хамтын оффис"-ын үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | Давхардсан тоогоор 200 үйлдвэрлэл эрхлэгчдэд "Хамтын оффис"-ын үйлчилгээг үзүүлсэн. | Давхардсан тоогоор 300 үйлдвэрлэл эрхлэгчдэд "Хамтын оффис"-ын үйлчилгээг үзүүлсэн байна. | 1.0 | Дүүргийн төсөв | ЖДҮДТ | Төвийн албан ёсны sbd.sme.ub.gov.mn цахим хуудас, Сүхбаатарт үйлдвэрлэв, Сүхбаатар дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв зэрэг фэйсбүүк болон пэйж хуудсаар үзэсгэлэн худалдааны мэдээллийг тухай бүрт нь түргэн шуурхай хүргэж, шинээр 3 үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний танилцуулгыг байршуулан, үйлдвэрлэл эрхлэгчдийн хийсэн арьс шир, ноос ноолуур, үндэсний хувцас болон европ хувцас, алт мөнгөн эдлэл, бэлэг дурсгал, органик гоо сайхны бараа бүтээгдэхүүнийг байршуулан зах зээлд сурталчлан ажиллаж байна.<br>Дүүргийн 1-20 дугаар хорооны 8300 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа болон ЖДҮДТөвийн 30 өрөөний 50 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэл мэдээллийг шинэчилж, Хамтын оффис цахим үйлчилгээг тогтмол ажиллуулж, 50 иргэнийг хамруулан, давхардсан тоогоор 380 гаруй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 100% |
| 54 | | | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгыг дулааны шугамд холбоно. | Хэрэгжилт хувиар | Төвлөрсөн дулаан хангамжид холбогдоогүй. | Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон байна. | 719.6 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 2024 оны төсөвт Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгыг дулааны шугамд холбох 719 сая төгрөг тусгагдсан. Тус ажлын худалдан авалтын захилгыг дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Тус ажлыг КАЛДЕРАТУБО ХХК гүйцэтгэсэн байна. | 100% |
| 55 | НЗДҮАХ 2.4.1.2 ДЗДҮАХ 2.8.3 | 2.8.3. Зорилтот бүлгийн болон үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байрны хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ, бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулна. | Зорилтот бүлгийн болон үйлдвэрлэл эрхлэгчдэд ажлын байрны болон тусгай төрлийн тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ үзүүлнэ. | Үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | ЖДҮ эрхлэгч-58, зорилтот бүлгийн 2 иргэнийг ажлын байраар хангаж, 20 иргэн, ААН-д тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ үзүүлсэн. | 55 иргэнийг ажлын байраар хангаж, 25 иргэн, ААН-д тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ үзүүлсэн байна. | | | ЖДҮДТ | Зорилтот бүлгийн болон үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байрны хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ, бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулан, 30 үйлдвэрлэл эрхлэгчидтэй хөнгөлөлттэй нөхцөлөөр ажлын байрны түрээсийн гэрээ байгуулж, давхардсан тоогоор 50 гаруй үйлдвэрлэгчдийг ажлын байраар ханган ажиллаж байна. Үүнээс 3 өрөөг зорилтот бүлгийн иргэдэд түрээслүүлж, Итгэлийн оч гал дөл ТББ, Дэлхийн зөн ОУБ-ын Хамтдаа даван туулъя, Гал голомт зэрэг төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 2 ээжийг оёдлын чиглэлээр сургаж, бээлий, тор зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, тусгай төрлийн тоног төхөөрөмж /хатгамлын машин, канза/-ийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлж, нийт 47 үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдээллийг хүргүүлж, 1 иргэнийг ажлын байраар ханган оператораар ажиллуулж, 3,905,000 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | төгрөгийн борлуулалт хийж, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин ажилласан. | |
| 56 | НЗДҮАХ-3.5.3.1, 2.5.2.1 ДЗДҮАХ-2.8.4 | 2.8.4. Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх мэдээллийн төвд үйлдвэр эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан төрөл бүрийн сургалт, уулзалтыг зохион байгуулна. | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах танхимын болон цахим сургалт, туршлага судлах бизнес аялал, мэргэжлийн уралдаан тэмцээн зохион байгуулна. | Үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо | 19 удаагийн сургалтад 375, бусад арга хэмжээнд 259 бизнес эрхлэгчдийг хамруулсан. | Танхимын болон цахимын нийт 15 удаагийн сургалтаар-300, танилцах аялал-50, уралдаан тэмцээн-125 | 25.0 | Дүүргийн төсөв | ЖДҮДТ | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГ, ЖДҮДТ, Хөгжлийн шийдэл ТББ, УБ хотын худалдааны танхим, Хөдөлмөр хамгаалал хүний хөгжлийн төв ТББ, БНХАУ-ын Zhubaijie цахим платформ, ОУ-ын төслийн байгууллагууд, Голомт банк, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Төрийн банк, Үндэсний давхар даатгал, Хаан даатгал, Нийслэлийн Бизнес инноваци хөгжлийн газар, Япон улсын ЖДҮ эрхлэгчид, Ноос ноолуурын холбоо, Болор стайлист студи, Солонгос улсын Жижиг, дунд үйлдвэрийн газар, НЗДТГ зэрэг байгууллагуудтай хамтран нийт 19 удаагийн сургалт, 2 удаагийн форум, чуулга уулзалтад 420 бичил бизнес эрхлэгчдийг дэмжин оролцууллаа. НЖДҮҮДТ-тэй хамтран БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан бүрэн автомат оёдлын тоног төхөөрөмжтэй танилцах бизнес аялалд 1, Аргалантын ферм, Харумафүжи ферм, АПУ сүүний үйлдвэрийн 3-р кластертэй танилцаж туршлага судлах аялалд 8 үйлдвэрлэл эрхлэгчдийг тус тус хамруулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвтэй хамтран зохион байгуулсан “Бүтээлч хот” уралдаанд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулж, “Бүтээлч иргэн” номинацийн Тэргүүн байрт 7 дугаар хорооны иргэн, дүүргийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч Д.Баярхуяг шалгарсан. | 100% |
| 57 | НЗДҮАХ 3.5.4, 3.5.2 ДЗДҮАХ-2.8.5 | 2.8.5. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажиллах, гадаад, дотоодын зах зээлд таниулах, үзэсгэлэн худалдаанд хамруулна. | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, дотоод гадаадын үзэсгэлэн, яармаг худалдаанд оролцуулж, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. | Үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо, борлуулалтын орлого | Дотоод, гадаадын нийт 15 удаагийн үзэсгэлэн худалдаанд 215 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулж, 752 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. Дүүргийн төсвөөс 20,4 сая төгрөг зарцуулсан. | Дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаанд 65 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулсан байна. | 330.0 | Дүүргийн төсөв | ЖДҮДТ | Сүхбаатарт үйлдвэрлэв, Сүхбаатар дүүргийн ЖДҮДТ, Сүхбаатар дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв зэрэг фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан үзэсгэлэн худалдааны мэдээллийг тухай бүрт нь түргэн шуурхай хүргэж, үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний танилцуулгыг байршуулан, зах зээлд сурталчлан ажиллаж байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Сар шинийн баярт зориулсан өргөтгөсөн худалдааг зохион байгуулах А/39 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн Засаг даргын А/09 дүгээр захирамжаар 10,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн 2024 оны 01 дүгээр сарын 10-наас 02 дугаар сарын 07-ны өдрийн хооронд Шинэ зуун айл худалдааны төвд зохион байгуулагдсан сар шинийн баярын “Амар байна уу” үзэсгэлэн худалдаанд дүүргийн 60 гаруй ЖДҮЭ-ийг дэмжин оролцуулж, нийт 225,446,200 төгрөгийн борлуулалттай, Соёлын яам, Соёл урлагийн газар, НЖДҮҮДТ-тэй хамтран зохион байгуулсан “Монгол гэр”, “Жаргалтай инээмсэглэл” сэдэвт 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд 16 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулж, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан, нийт 49,122,000 төгрөгийн борлуулалт хийж, төрөл бүрийн оёмол бүтээгдэхүүн, мод, модон эдлэл, арьс, арьсан эдлэл, бэлэг дурсгалын зүйлс, хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж, олон нийтэд бараа бүтээгдэхүүнээ сурталчилсан.<br>Мөн Үндэсний их баяр наадмын Дээлтэй монгол арга хэмжээний үзэсгэлэн худалдаа, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн Монгол Наадам-2024 үзэсгэлэн худалдаа, Даншиг наадам–Хүрээ цам-2024 үзэсгэлэн худалдаа, Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль зэрэг нийт 4 удаагийн дотоодын үзэсгэлэн худалдаанд 42 бизнес эрхлэгчдийг дэмжин оролцуулж, 71,047,250 төгрөгийн борлуулалт хийсэн. БНХАУ-ын Эрээн хотод 2024 оны 08 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн худалдаанд Монгол дархан, оёдол, ноос | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 4 үйлдвэрлэл эрхлэгч хувийн зардлаар оролцож, 12,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. | |
| 1.9 (2.9) Соёлын үйл ажиллагааг дэмжин, түгээн дэлгэрүүлнэ. | | | | | | | | | | | |
| 58 | | | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Хүрэл тулга яруу найргийн уралдаан, Хүүхдийн найрал дууны наадам зохион байгуулна. | Хамрагдсан иргэдийн тоо | 806 | 900 | 13.0 | Дүүргийн төсөв | НХХ | “Хүрэл тулга-2024” уралдааныг дүүргийн Засаг даргын 2024 оны А/50 дугаар захирамжаар 3,006,000 төгрөгийн санхүүжилт гарган ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд хоёр насны ангиллаар зохион байгуулагдаж, нийт 95 хүүхэд оролцсон. Уралдаанаас 16 шилдэг хүүхэд шалгарч, Монголын хүүхдийн ордонд зохион байгуулагдсан нийслэлийн шатны шалгаруулалтад амжилттай оролцсон.<br>-Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах 30 дахь удаагийн уралдааны анхан шатны шалгаруулалтыг дүүргийн Засаг даргын 2024 оны А/497 захирамжаар, 8,695,000 төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, нийт 7 сургуулийн 460 сурагч, 20 гаруй багш ажилтан оролцсон. Уралдааны тэргүүн байрт Монгол, Оросын хамтарсан 3-р сургууль, дэд байрт 2 дугаар сургууль, гутгаар байрт 1-р сургууль, тусгай байрт 3,11-р сургуулийн найрал дууны хамтлаг, Шилдэг удирдаач багшаар 11 дүгээр сургуулийн багш С.Цэрэнпил тус тус шалгарсан. Дүүргийн шалгаруулалтаас шалгарсан 3 хамтлагийн 180 сурагч улсын хэмжээний шалгаруулалтад оролцож, Монгол, Оросын хамтарсан сургуулийн найрал дууны хамтлаг дэд байрт шалгарч, нийслэл хотын 385 жилийн ойн нэгдсэн гала тоглолтод 60 сурагч оролцсон.<br>Нийт 2 удаагийн уралдаанд 815 сурагчид оролцож, 11,701,000 төгрөгийг зарцууллаа. | 100% |
| 59 | НЗДҮАХ-2.6.1 ДЗДҮАХ-2.9.1 | 2.9.1 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд, залуучууд, иргэдийн авьяасыг нээн хөгжүүлэх, урлаг соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулна | Дээлтэй Монгол наадам зохион байгуулна. | Хамрагдсан иргэдийн тоо | 600 | 800 | 20.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дээлтэй монгол наадамд дүүргийн Засаг даргын 2024 оны А/305 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан, дүүргээс гэр өргөө тохижуулан, тамгын газрын албан хаагчид, 600 гаруй иргэн үндэсний дээл хувцсаар гоёж, оролцлоо. Гэр өргөөнд Дуут урлан ХХК болон Зүймэл урлал ТББ-тай хамтран монгол ахуйг харуулсан гар урлаачдын урласан үнэт эд зүйлсийг байршуулан гадаад дотоодын 400 гаруй жуулчдад сурталчилан, айраг, цагаан идээгээр үйлчилж ажилласан. Тус наадамд амжилттай оролцон Хүүхэд, залуучуудын театрын нэрэмжит шагналаар шагнуулсан. Дээрх ажилд дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 9 800 000 төгрөгийг зарцуулсан. Дээлтэй Монгол наадамд дүүрэг амжилттай оролцож, Хүүхэд, залуучуудын театрын нэрэмжит шагналаар шагнуулсан. | 100% |
| 60 | | | Соёлын өвийн олон төрлийг иргэдэд сурталчлан, соёлын биет бус өвийг өвлөн тээгчдийг дэмжин ажиллана. | Хамрагдсан иргэдийн тоо | 280 | 300 | 10.0 | Дүүргийн төсөв | НХХ | -Дүүргийн ЗДТГ-аас тэтгэвэрт гарсан ахмад настнуудад сар шинийн баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж, урлагийн тоглолт зохион байгуулан дүүргийн ахмадын хорооны дэргэдэх соёлын биет бус өвийг өвлөн тээгч 10 ардын авьяастан оролцлоо.<br>-Нийслэлийн соёл урлагийн газарт дүүргийн Соёлын биет бус өвийг өвлөн тээгч 312, бүртгэл хариуцсан 12 хүний судалгааг өгс ажилласан.<br>-Дүүргийн соёлын биет бус өв тээгч 20 ахмад настан МҮОНТ-ийн "Дөрвөн бэрх" нэвтрүүлэгт оролцсон.<br>-Нийслэлийн соёл урлагийн газар, Соёлын өвийн төвөөс хамтран соёлын биет бус өвийг өвлөн тээгчдийн зөвлөгөөн зохион байгуулж, дүүргийн 110 өв тээгчийг оролцуулсан.<br>-Даншиг наадам-Хүрээ цам шашин соёлын арга хэмжээнд дүүргийн ЗДТГ-аас гэр өргөө тохижуулан, ахмадын хороотой хамтран соёлын биет бус өв тээгч, ардын авьяастан 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. “Даншиг” наадамд амжилттай оролцон, Дархад ардын дуугаар уран сайханч Д.Мягмаржав, Морин хуурч Б.Шинэбаяр, Хотгойд ардын дуу, Ойрд биелгээгээр оролцсон Д.Алтанцэцэг нар шалгарч “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцож, тус бүр 500,000 төгрөгөөр шагнуулсан.<br>-Монгол Угсаатан хэл хуурчдын холбооноос зохион байгуулсан Хөгт аялгуу наадамд дүүргийн 15 өв тээгч оролцож, өргөмжлөлөөр шагнуулсан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | -Зууны манлай уртын дуучин Ж.Дорждагвын мэндэлсний 120 жилийн ойн хүрээнд Сүхбаатарын талбайд уртын дуучдын Уухайн түрлэг өргөх үйл ажиллагаа зохион байгуулагдаж, дүүргийн 92 уртын дуучин оролцлоо.<br>-Олон улсын Ахмадын өдрийг угтан Ахмадын хороотой хамтран “Ардын урлаг, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх” өдөрлөгт 1-20 дугаар хорооны соёлын биет болон биет бус өв тээгч, өвлөн уламжлагч 100 гаруй ахмад оролцсон. | |
| 61 | ДЗДҮАХ-2.9.2 | 2.9.2 Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна. | Хүүхэд, залуучуудад электрон тамхи, цахим донтолт, хорт зуршлын уршгийг таниулах нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | Хамрагдсан иргэдийн тоо | 2274 | 4000 | 16.0 | Дүүргийн төсөв | НХХ | “Эерэгээр нөлөөлье-3” аяны хүрээнд цахим орчны соёлтой хэрэглээг төлөвшүүлэх, цахим орчинд үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах, электрон тамхинаас татгалзах, хорт зуршлаас салах, хорт зуршлаас хүүхэд насаа хамгаалъя зэрэг нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулан ажилсан.<br>-Нийслэлийн Засаг даргын 2023 оны Электрон тамхи худалдан авагчдад насны хязгаар тогтоох тухай А/1467 дугаар захирамжийг дүүргийн нутаг дэвсгэрийн 147 байгууллагад танилцуулж, мэдээллийн самбарт “Электрон тамхины хор хөнөөл” постер байршуулан өсвөр насны хүүхдийн электрон тамхины хэрэглээг бууруулах, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг таниулах арга хэмжээ зохион байгуулсан. Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төвтэй хамтран “Электрон тамхи, цахим донтолт, хорт зуршлын уршгийг таниулах, бүх төрлийн цахим мэдээллийн халдлагаас урьдчилан сэргийлэх” сургалтыг ерөнхий боловсролын 5 сургуулийн сурагчдад зохион байгуулж 1939 хүүхэд хамрагдсан.<br>-Ү-peer ТББ-тай хамтран үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршил, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэлзүйн зөвлөгөө мэдээллийг нэмэгдүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 1014 сурагчдад зохион байгуулав.<br>-Соёлтой иргэн-Соёлтой дүүрэг нөлөөллийн аяныг зохион байгуулж, иргэд, оюутан, залуучуудад нийт 11000 ширхэг халаасны үнсний сав, 10000 ширхэг амны цаас тарааж ажилласан. .<br>-Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Боловсролын сургалтын байгууллагуудын орчинд электрон тамхи хэрэглэхийг хориглох тухай А/140 дүгээр тушаалыг сурталчлан таниулах зорилгоор “Хамтдаа хамгаалъя” нөлөөллийн ажлыг 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд ерөнхий боловсролын сургуулийн 7000 гаруй сурагчдын дунд зохион байгуулав. Энэхүү ажлын хүрээнд Хүүхэд хамгааллын тухай хууль, электрон тамхины хор хөнөөл, анхны тусламжийн талаар сургалт мэдээлэл өгч, гарын авлага тарааж, өгөгдсөн мэдээллийн хүрээнд АХА тэмцээн зохион байгуулав. | 100% |
| 62 | НЗДҮАХ-2.6.3 ДЗДҮАХ-2.9.3 | 2.9.3 Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө, баримал, түүх соёлын дурсгалт газрын арчлалт хамгаалалтыг сайжруулан, хяналт тавьж холбогдох газруудтай хамтран ажиллана. | Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө, баримал, түүх соёлын дурсгалт газрын арчлалт хамгаалалтад хяналт тавьж, холбогдох газруудтай хамтран ажиллана. | Тоо, чанар | 53 | 53 | 8.0 | Дүүргийн төсөв | НХХ | Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн хөшөөнд 2024 оны 03 сарын 19-ний өдөр цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэх ажлыг дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгууллаа. -Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-тай хамтран 28 хөшөөг 4 удаагийн давтамжтайгаар цэвэрлэсэн. -Дүүргийн Засаг даргын А/369 захирамжаар 4,8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Б.Цэрэндоржийн хөшөө, Битлзийн хөшөө, Ж.Лхагвасүрэн жанжны хөшөөний суурь, орчин тойрны тохижилтын ажлыг хийлээ. Тус ажилд 11,631,000 төгрөг зарцуулсан.<br>-Дүүргийн Засаг даргын 2024 оны А/93 захирамжаар хороодын Засаг дарга, нийгмийн ажилтнуудад соёлын биет болон биет бус өвийн талаар ойлголт, мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулж, 32 хүн хамрагдлаа. | 100% |
| 63 | ДЗДҮАХ-2.9.4 | 2.9.4 Хотын соёлыг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх, амьдралын зөв дадал, сайн чанар, эх оронч үзлийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад амьдралын зөв дадал, эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна. | Хамрагдсан иргэдийн тоо | 2754 | 6165 | | | НХХ | Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд зан суртахууны төлөвшил, уламжлалт аж төрөх ёс, үндэсний өв соёл, бахархлаа дээдэлж, түүнээс суралцах хэрэгцээ сонирхлыг бий болгох зорилготой “Би Монгол хүүхэд” ёс заншлын наадмыг зохион байгуулж, 14 сургуулийн бага ангийн 140 сурагч, 28 багшийн хамт оролцож, монгол ёс заншил, ардын уламжлалт тоглоом наадгайгаар оюун ухаан, авьяас чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. Багийн нийлбэр дүнгээр 1-р байрыг 35 дугаар сургууль, 2-р байрыг 2 дугаар сургууль, 3-р байрыг 4 дүгээр сургуулийн багш, сурагчид тус | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | тус эзэлсэн. Ерөнхий шүүгчээр Монгол Улсын Консерваторийн сургалт хариуцсан менежер Г.Оюунтуяа, шүүгчээр МУБИС-ийн ЕБС-ийн нийгмийн ажилтан Б.Мөнхзандан, 116-р сургуулийн сургалтын менежер С.Мөнгөн-Үзэг нар ажилласан. | |
| 1.10 (2.10) Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжин гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж ажиллана. | | | | | | | | | | | |
| 64 | МУХТ-2.12.1, 2.13.1 НЗДҮАХ-2.7.1 НХТ-2.7.1.3 ДЗДҮАХ-2.10.1 | 2.10.1 Жендерт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Түр хамгаалах байрны аюулгүй тохитой байдлыг хангаж, үйл ажиллагааг сайжруулж, хамгааллын үйлчилгээ үзүүлнэ. | Төлөвлөгөөний хэрэгжилтээр | 139 | 139 | 116.9 | Дүүргийн төсөв | НХХ | Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардалд Тамгын газрын даргын А/109, А/513, А/122, А/150 дугаар тушаалаар 124,926,788 төгрөгийг шийдвэрлэн байр ашиглалт, хангамж, бараа материал, урсгал засварын зардал, цалин хөлсний зардалд зарцуулсан. Тус төв нь 98 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн. 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад хүчирхийлэлд өртөгсөддийн тоо буурсан. | 100% |
| 65 | | | Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжилтээр | 80% | 90% | 20.0 | Дүүргийн төсөв | НХХ | Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын үндсэн чиглэл, Хүйс ба жендэр, Жендэрийн эрх тэгш байдал, зэрэг сэдвээр сургалтад дүүргийн ЗДТГ, дэргэдэх хэлтсийн төлөөлөл нийт 65 албан хаагч хамрагдсан.<br>-Жендэрийн үндэсний хорооноос 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ "2024-2027" төлөвлөгөө"-г танилцуулах уулзалтыг ЗДТГ, дэргэдэх хэлтэс, албадын удирдлагууд нийт 72 албан хаагчдад зохион байгуулсан.<br>-Дүүргийн ЗДТГ-ын 123 албан хаагчийн нас, хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг нэгтгэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>-Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Жендэрийн Үндэсний хорооноос зохион байгуулсан Улс төрийн намын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээний маягт танилцуулах сургалт, Азийн сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан "Технологи ашиглан үйлдэж буй жендэрт суурилсан нөхцөл байдал, салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь" хэлэлцүүлэгт тус тус хамрагдан мэдлэгээ нэмэгдүүлсэн. | 100% |
| 66 | ДЗДҮАХ-2.10.2 | 2.10.2.Хүүхэд, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна. | Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон нийтэд хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна | Тоо | 150 | 250 | 20.0 | Дүүргийн төсөв | НХХ | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран байгууллагын дэргэдэх эцэг эхийн 50 зөвлөлд арга зүйн дэмжлэг үзүүлэн хүүхэд хамгааллын бодлогыг 945 иргэнд хүргэн ажилласан. Дүүргийн 24, 50, 51, 143, 281 дүгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын 58 дугаар сургуулийн нийт 1127 эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхэд хүмүүжлийн эерэг аргын сургалт зохион байгуулан, хүүхдийн насны онцлогийн талаар мэдээлэл хүргэсэн. | 100% |
| 67 | | | Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрлөг зохион байгуулна | Хүүхдийн тоо | 48978 | 53875 | 40.0 | Дүүргийн төсөв | НХХ | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд "Хамтын хүчээр аз жаргал өөдөө" арга хэмжээний Итгэл сэтгэл аянд хамрагдаж буй зорилтот өрхийн 22 хүүхдэд баяр хүргэн, бэлэг хүргүүлсэн.<br>-1-20 дугаар хорооны Засаг даргын ажлын алба зорилтот бүлгийн хүүхдүүдээ хүлээн авч, баяр хүргэн, бэлэг гардуулсан. Энэхүү өдөрлөг, арга хэмжээнд нийт 2017 хүүхэд хамрагдсан. ЗДТГ, дэргэдэх хэлтэс, алба, 1-20 дугаар хорооны ажлын алба, төриийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс зохион байгуулсан хүүхдийн баярын үйл ажиллагаанд дүүргийн хэмжээний 53900 гаруй хүүхэд хамрагдсан. | 100% |
| 68 | | | Оны шилдэг хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдийг алдаршуулна. | Тоо | 7726 | 7879 | 900.0 | Дүүргийн төсөв | НХХ | "Их хотын бүсгүйчүүд" нийслэлийн нэгдсэн арга хэмжээний "Алдарт эх" номинацид 1 иргэн шалгарсан.<br>-Олон улсын хүүхдийг эрхийг хамгаалах өдөрт зориулсан "Монгол хүүхдүүд" баярын нэгдсэн үйл ажиллагаанд авьяаслаг хүүхдүүдийн видео, контент бэлтгэн танилцуулах ажлын хүрээнд 58 шилдэг хүүхдийн холбогдох мэдээллийг Нийслэлийн соёл урлагийн газарт хүргүүлсэн.<br>-Дүүргийн Засаг даргын 2024 оны Оны шилдэг хүүхэд шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай А/553 дугар захирамжаар төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн 95 шилдэг хүүхдийг шалгаруулж, Шилдэг хүүхэд медаль, ном худалдан авах эрхийн бичгээр шагнаж урамшуулахад 9,832,500 (Есөн сая найман зуун гучин хоёр таван зуун) төгрөгийг, Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гаргаж олгож шагнах ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулав. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Тус онд алдарт эхийн 1, 2 дугаар опонг 7920 иргэн авсан. | |
| 69 | ДЗДҮАХ-2.10.3 | 2.10.3. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, бүх төрлийн цахим мэдээллийн халдлагаас урьдчилан сэргийлэх ажлыг өрнүүлнэ. | Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр ажилладаг зөвлөлүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Хүүхэд, залуучуудын тоо | 7000 | 20000 | 10.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн Хүүхдийн Зөвлөлтэй хамтран 17 удаагийн сургалт, уулзалт, үйл ажиллагааг зохион байгуулан танхимаар 935, цахимаар 35,388 нийт 36,323 хүүхдэд хүрч ажилласан.<br>-Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ахуйн хүрээний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажлыг цахимаар 20 эцэг эхийг хамруулан зохион байгуулж, 5 төрлийн постерийг 1500 хүнд хүргэж ажилласан.<br>-Хүүхдийн тусламжийн утсанд ирсэн 492 дуудлага мэдээллийг харьяа хороо руу шилжүүлэн, зөвлөгөө мэдээлэл өгч, 203 дуудлага мэдээллийг шийдвэрлэж, 223 дуудлага мэдээлэлд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэн хяналт тавин ажиллаж байна.<br>-Хүүхдийн тусламжийн утсанд ирсэн 492 дуудлага мэдээллийг харьяа хороо руу шилжүүлэн, зөвлөгөө мэдээлэл өгч, 203 дуудлага мэдээллийг шийдвэрлэж, 223 дуудлага мэдээлэлд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэн хяналт тавин ажиллаж байна. | 100% |
| 70 | ДЗДҮАХ-2.10.4 | 2.10.4 Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорооны “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг сайжруулж, нэмэгдэл урамшуулал олгоно. | Хорооны Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Тоо | 20 | 20 | 20.0 | Дүүргийн төсөв | НХХ | Хамтдаа хөгжиж, харилцан суралцъя сэдэвт салбар дундын нийгмийн ажилтнуудын зөвлөгөөнийг зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн 39, дүүргийн ЭМТ, ӨЭМТ-ийн 17, хорооны 18 нийгмийн ажилтан, зохион байгуулагч нийт 89 ажилтан, албан хаагчийг оролцуулсан.<br>-Японы Хүүхдийг ивээх сангийн “Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах” хөтөлбөрт 3 хорооны нийгмийн ажилтнуудыг хамруулж, чадавхжуулсан.<br>--“Хамтарсан багийг чадавхжуулах, дэмжлэг үзүүлэх” 2 өдрийн сургалтад 1-20 дугаар хорооны хамтарсан багийн 80 гаруй гишүүд хамрагдсан.<br>-Хамтарсан баг нь нийт 301 дуудлага, мэдээлэл дээр ажиллан, 130 кейсийг хааж, шийдвэрлэсэн.<br>- Хорооны хамтарсан багшийн гишүүдийн дунд “Туршлагаа хуваалцъя ажил мэргэжлийн мэтгэлцээн зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын А/556 захирамжаар 15,360,000 төгрөг шийдвэрлэсэн. Тус мэтгэлцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр зохион байгуулж, кейстэй ажиллах, асуулт хариулт, илтгэлээр оролцоог дүгнэж, 1, 2, 3, 4-р байр, тусгай байрыг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. | 100% |
| 1.11 (2.11) Ахмад настны хөгжил, хамгааллын арга хэмжээг хөгжүүлнэ | | | | | | | | | | | |
| 71 | НХТЖҮЧ-3.1.1 НЗДҮАХ-2.4.2.1 НХТ-90 ДЗДҮАХ-2.11.1 | 2.11.1 Ахмад настан, зорилтот бүлгийн иргэдийн мэдээллийн санг бий болгож, чадамжийг дэмжих, нийгмийн амьдралд татан оролцуулах ажлыг зохион байгуулна. | Ахмад настны хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 18036 | 20000 | 2,200.0 | Дүүргийн төсөв | НХХ | Дүүргийн хэмжээнд нийт 20943 ахмадын мэдээлэл бүхий сан бүрдүүлж, akhmad.mn нэгдсэн программд, 11000 гаруй ахмадын мэдээллийг буюу 53%-ийг шивж, цахимжуулсан. Харьяалалгүй ахмад 4707, харж хандах хүнгүй ганц бие 893 байна.<br>-Хорооны Ахмадын зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж, шилдэг зөвлөлүүдийн туршлага судлуулах, мэдээлэл солилцох өдөрлөг зохион байгуулж, нийт 170 гаруй ахмад хамруулсан.<br>-Сар шинийн баярыг тохиолдуулан “Шагайн наадгай” тэмцээн зохион байгуулж, нийт 450 гаруй ахмад оролцсон.<br>-Сар шинийн баяраар нийт 2000 ахмадад хүндэтгэл үзүүлсэн.<br>-Монгол бичгийн 32 цагийн сургалтад давхардсан тоогоор 180 ахмад хамрагдлаа.<br>- Мини волейболын сургалт явуулж, 110 ахмад хамрагдав.<br>-Ахмадын хорооны удирдах ажилтнуудын дунд 100 буудалт даам, мини волейбол, цэнгээнт бүжиг, дартс, ширээний теннис, граунд гольфын тэмцээн зохион байгуулж, 120 гаруй ахмад тамирчид оролцлоо.<br>-Долоо хоног бүр ерөнхий боловсролын 35, 58 дугаар сургууль, Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн зааланд софт волейбол тоглож хэвшин, нийт 660 гаруй ахмад оролцсон.<br>-Олон улсын гэр бүлийн өдрийг угтан Гэрлэх ёслолын ордны хамт олонтой хамтран 20 ахмад гэр бүлд хүндэтгэл үзүүлэх “Хос багана” 9 эрдэнийн хуримыг зохион байгууллаа.<br>-“Эрүүл агаар-эрч хүч” хаврын явган аяллыг дүүргийн Биеийн тамир спортын хороотой хамтран зохион байгуулж 250 ахмадыг оролцуулан, бүсгүйдийн дунд 5 төрлийн тэмцээн зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | байр эзлүүлэн, шилжин явах цом мөнгөн шагналаар шагнан урамшууллаа.<br>-“Дээлтэй монгол наадам”-д 32 ахмад,Даншиг их наадамд 28 ахмад, “Нүүдэлчин” фестивалд 8 ахмад оролцсон.<br>- Монголын гимнастикийн шугаман бүжгийн холбоо Азийн шугаман бүжгийн фестивалд 12 ахмад оролцсон.<br>- Олон улсын Ахмадын өдрийг угтан “Ардын урлаг, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх” өдөрлөгийг зохион байгуулж хороодын соёлын биет болон биет бус өв тээгч, өвлөн уламжлагч, ахмад настан, ардын авьяастан, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 100 гаруй ахмад настнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. | |
| 72 | НХТЖҮЧ-3.1.1 НЗДҮАХ-2.4.2.1 НХТ-90 ДЗДҮАХ-2.11.2 | 2.11.2 Ахмад настны эрүүл мэнд, өрхийн хөгжлийг дэмжин хөтөлбөр, арга хэмжээнд хамруулна. | Ахмад настны нийгмийн хамгааллыг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 18036 | 20000 | 100.0 | Дүүргийн төсөв | НХХ | Ахмад настны нийгмийн хамгааллыг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд дүүргийн 1-20 дугаар хороодын нийт 360 хэвтрийн ахмадын судалгааг гарган, 13, 14 дүгээр хорооны 10 ахмадыг сонгон, гэрээр хүрч үйлчилгээ үзүүллээ.<br>-Дүүргийн Ахмадын хороо, Геронтологийн үндэсний төвтэй хамтран 2024.04.08-12-ны өдрүүдэд эхо оношилгоо, зүрхний бичлэг, дотрын эмч, сахрын үзлэгт нийт 200 орчим ахмад хамруууллаа.<br>-“Тэр бум мод” хөтөлбөрийн хүрээнд хорооны ахмадууд мод, сөөг, жимс, хүнсний ногоо тарих ажил өрнүүлж, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, даршлах, борлуулах зэргээр өрхийн үйлдвэрлэлээ дэмжин ажиллаж байна. Энэ ажил нь уламжлал болон хийгддэг бөгөөд намар тэргүүний өрх, тэргүүний тариаланч шалгаруулна. | 100% |
| 73 | НХТЖҮЧ-3.1.1 НЗДҮАХ-2.4.2.1 НХТ-90 ДЗДҮАХ-2.11.3 | 2.11.3 Дүүргийн иргэд, ахмад настнуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх соёл урлагийг дэмжих, “Ахмадын настны хөгжил хамгааллын төв”-ийг барьж байгуулна. | Ахмадын хөгжлийн төвд Сэргээн засах, Хөдөлгөөн дэмжих, Өдөр өнжүүлэх, Соёл урлагийн танхимын үйл ажиллагааг эхлүүлж, тогтмолжуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар | 0 | 1000 | 100.0 | Дүүргийн төсөв | НХХ | Сар шинийн баярыг угтан зохион байгуулсан Үндэсний телевизийн “Дөрвөн бэрх” тэмцээнд дүүргээ төлөөлөн 20 ахмад оролцож 3 дугаар байр эзэлсэн.<br>-Шинээр ашиглалтад орсон ахмадын хөгжлийн төвийн хөдөлгөөн дэмжих танхимаар 300 гаруй ахмад гүйлтийн зам, фитнес дугуй, цана бүсэлхийн массаж, нурууны дасгалын төхөөрөмжөөр үйлчлүүлсэн байна.<br>-Сэргээн засах танхимаар 350 орчим ахмад настан массажны ор, бумба, хаш чулуун гудас, гүйфурен сандал зэрэг төхөөрөмжөөр үйлчлүүллээ. Нийт давхардсан тоогоор 600 орчим ахмадад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн.<br>-Соёл урлагийн танхимд 7 хоног бүрийн 3 өдөр шугаман бүжиг, цэнгээнт бүжгийн сургалт явуулж, Улсын аварга шалгаруулах шугаман бүжгийн тэмцээнд Талст хамтлаг оролцож эхний шатны шалгаруулалтад тэнцсэн.<br>-Түмэн шувуутын 20 жилийн ойд зориулсан шугаман бүжгийн улсын анхдугаар уралдааны 2-р шатанд оролцож, “Шинэ санаа” номинацид шалгарч, цом, нэг сая төгрөгөөр шагнуулсан.<br>-Дүүргийн 1-20 дугаар хороодын ахмад настнуудын нийгмийн оролцоог хангах, хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 277м2 талбай бүхий 2 давхар Ахмадын хөгжлийн төвийг Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан нээж, нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. | 100% |
| ХОЁР. Эдийн засгийн бодлого /Өсөлтийг өрх бүрд Сүхбаатар дүүрэг/ | | | | | | | | | | | |
| 2.1 (3.1) Дүүргийн төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж, ил тод мэдээлнэ. | | | | | | | | | | | |
| 74 | ДЗДҮАХ-3.1.1 | 3.1.1 Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд нээлттэй, ил тод тайлагнана. | Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд нээлттэй ил тод тайлагнана | shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан захирамжлалын баримт бичгийн тоогоор | shilendans.gov.mn цахим хуудсанд дээрх мэдээллийг тухай бүр мэдээлэн ажилласан. | Байгууллагаас гарч буй төсөв, санхүүтэй холбоотой шийдвэрийг shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулах | | | СТСХ | 2024 онд мэдээллийг сар бүрийн 08-ны өдрийн дотор дүүргийн Засаг даргын захирамж 251, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 146 нийт 397 захирамжлалын баримт бичгийг shilendans.gov.mn цахим хуудсанд 11 удаа хугацаанд нь байршуулсан.<br>Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагын үйл ажиллагаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, төсөв, санхүү төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Тус албаны 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит 18 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 100.0 % хангаж ажилласан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Сүхбаатар дүүргийн төрийн өмчийн 20 байгууллагын нягтлан бодогчдод байгууллагын дотоод хяналт, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөгөө өгч ажилласан.<br>2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 12 дугаар сард Сүхбаатар дүүргийн 2 сургууль, 3 цэцэрлэгт Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийгдэхээр хүлээгдэж байна. | |
| 75 | ДЗДҮАХ-3.1.2 | 3.1.2 Дүүргийн төсвийн сахилга бат, хэмнэлт, санхүү тайлан бүртгэлийн стандарт, ил тод байдлыг хангах, дүүргийн санхүүгийн ажилтн уудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, идэвхжүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна. | Дүүргийн төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт хувь хүний хөгжлийг дэмжих, харилцааны ур чадвар, стресс менежмент, ажлын бүтээмж, багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулна. | Ажлын байрны бүтээмж өсөж, хамт олны багаар ажиллах ур чадвар нэмэгдэж, гүйцэтгэл ур дүн сайжирсан байна. | Ажлын бүтээмж, багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх сэдвээр идэвхжүүлэх сургалт зохион байгуулсан. | Ажлын байрны бүтээмж өсөж, хамт олны багаар ажиллах ур чадвар нэмэгдэж, гүйцэтгэл үр дүн сайжирсан байна. | 20.0 | Дүүргийн төсөв | СТСХ | 2024 онд Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатар дүүргийн төрийн байгууллагын нийт 150 санхүүгийн ажилтан, албан хаагчдын дунд сургалт, спортын арга хэмжээг зохион байгуулсан. | 100% |
| 76 | | | Дүүргийн төсвийн байгууллагын санхүүгийн ажилтнуудад "төсөв санхүүгийн шинэчлэгдсэн хууль, дүрэм журам танилцуулах сургалт зохион байгуулж, төсвийн сахилга батыг чанд сахих" агуулгын хүрээнд сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулна. | Төсвийн сахилга бат сайжирч, тайлан бүртгэлийн стандарт ил тод байдал хангагдах боломж бүрдсэн байна. | Төсвийн байгууллагын санхүүгийн ажилтнуудад сургалт, мэдээлэл, зөвлөмж өгч гарсан алдаа зөрчлийг залруулан ажилласан. | Төсвийн сахилга бат сайжирч, тайлан бүртгэлийн стандарт ил тод байдал хангагдах боломж бүрдсэн байна. | | | СТСХ | 2024 оны 09 сарын 11-ний өдрийн А/475 тоот захирамжын дагуу Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, дүүргийн төсвийн сахилга бат, хэмнэлт, санхүү тайлан бүртгэлийн стандарт, ил тод байдлыг хангах, дүүргийн санхүүгийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, идэвхжүүлэх сургалт арга хэмжээний хүрээнд Дүүргийн төрийн байгууллагуудын нягтлан бодогч нарт 2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр сургалт зохион байгуулав. | 100% |
| 77 | ДЗДҮАХ-3.1.3 | 3.1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг цахим системээр зохион байгуулж, мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд ил тод мэдээлнэ. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг цахим системээр зохион байгуулж, мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд ил тод мэдээлнэ. | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувиар | 2023 онд Захиалагчийн 122 төсөл арга хэмжээг 100 хувь цахим системээр зохион байгуулж ажилласан. | Цахим системээр иргэд мэдээлэлтэй болсон байна. | 20.0 | Дүүргийн төсөв | ХААА | Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11/67 дугаар тогтоол, 2024 оны 11/48 дугаар тогтоолоор 2024 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 150,144,986.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 327 төсөл арга хэмжээ батлагдсан. Батлагдсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 100 хувь цахим системээр зохион байгуулан ажиллаж байгаа ба 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:<br>-Худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсан 93,123,485.6 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 208 төсөл арга хэмжээ<br>-Үнэлгээний шатанд 3,767,280.5 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 26 төсөл арга хэмжээ<br>Дахин зарласан болон тендерийн шатанд 5,176,425.7 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл арга хэмжээ<br>-Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 12,038,673.8 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 59 төсөл арга хэмжээ<br>-Ажлын даалгавар ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй 1,660,000.0 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээ<br>-Ажлын даалгавар ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдсан 34,272,515.8 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл арга хэмжээ<br>-Цуцалсан 106,605.5 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ байна.<br>Нийслэлийн ЗД-ын 2023 оны А/1489 дугаар захирамжийн дагуу эрх шилжиж ирсэн 400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12, 15, 17-р хороодод гэрэлтүүлэг хийх ажлын худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулж ажиллалаа. Мөн Нийслэлийн ЗД-ын 2024 оны А/940 дугаар захирамжийн дагуу эрх шилжиж ирсэн 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Өрхийн эмнэлгийн барилга (УБ, СБД, 16-р хороо) | 93.1% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төсөл арга хэмжээний тендерийн баримт бичиг боловсруулах шатандаа явагдаж байна.<br>Худалдан авах ажиллагааны хэрэгжилт 93.1% байна.<br>Батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, явц, үр дүнгийн талаарх мэдээ тайланг тухай бүр www.tender.gov.mn, www.shilendans.gov.mn, дүүргийн ЗДТГ-ын www.sbd.gov.mn, www.report-ubprocurement.mn цахим хуудсууд болон дүүргийн худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй хүргэн ажиллаж байгаагийн зэрэгцээ Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 тоот албан даалгаварын дагуу www.report-ubprocurement.mn цахим системд долоо хоног бүрийн мягмар, пүрэв гарагт үнэн зөв мэдээллийг дэлгэрэнгүй бүрэн хөтлөн ажиллаж байна. | |
| 78 | ДЗДҮАХ-3.1.5 | 3.1.5 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын саналыг иргэдээс нээлттэй болон цахимаар авч, иргэдийн бүлэг, олон нийтийн оролцоотойгоор гүйцэтгэж, нээлттэй ил тод болгоно. | Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу иргэдээс авах санал асуулгыг хэрхэн авах тухай сургалтыг үе шаттай зохион байгуулна. | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 152 | 152 | 20.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Сангийн яам болон Тогтвортой амьжиргаа-3 төслийн хүрээнд ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем, мобайл апп-аар 2025 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төслийн саналын жагсаалтыг 2024.03.28-ны өдөр системд шивж оруулсан. НЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хийгдэх төсөл, арга хэмжээний асуулгыг иргэд, олон нийтээс авах ажлыг зохион байгуулахтай холбоотой, хэсгийн ахлагч нарт гар утасны нэгж авах судалгаар хороодоос авч нэгтгэн хүргүүлсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг дүүргийн хороодын иргэдээс авах ажлыг зохион байгуулахад Хороодын Зохион байгуулагч нарыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системийн захидал харилцааны дэд системд груп үүсгэн шаардлагатай мэдээллийг өгч, санал асуулга зохион байгуулахад тулгарч буй асуудлыг шийдвэрлэн мэдээлэл солилцож, асуулгыг бүрэн зохион байгуулж дууссан. | 100% |
| 79 | | | Сангийн сайдын 243 дугаар тушаалын дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын саналыг хорооны иргэдээс авч, эрэмбэлэн, зөвшилцөн шийдвэрлэж, иргэдэд мэдээлнэ. | Санал өгсөн иргэдийн тоо | 49336 | 50000 | 20.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | НЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд хийгдэх төсөл, арга хэмжээний асуулгыг иргэд, олон нийтээс авах ажлыг зохион байгуулахтай холбоотой, хэсгийн ахлагч нарт гар утасны нэгж авах судалгаар хороодоос авч нэгтгэн хүргүүлсэн.<br>Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авах ажлыг НЗД-ын 2024 оны А/415 дугаар захирамжийн хүрээнд зохион байгуулж байна.<br>Сүхбаатар дүүргийн Засаг даргын орлогч М.Алтан гэрэлээр ахлуулсан "ОНХС-ийн санал асуулгыг зохион байгуулахад арга зүйн зөвлөмж өгч, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг дүүргийн Засаг даргын 2024 оны А/119 дүгээр захирамжаар байгуулж, Санал авах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар цаасан 35000, цахим 5556 санал авч нийт 40556 санал аваад байна. Хороодоос авсан цаасан суурьт саналын хуудасны нэгтгэлийг хороо бүрээр гаргуулан авч, саналын хуудсыг архивын нэгж болгон дүүргийн архивт хүлээлгэн өгсөн. | 100% |
| 80 | ДЗДҮАХ-3.1.6 | 3.1.6 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тухайн оны дүүргийн төсвийн төслийг олон нийтэд танилцуулах зорилгоор нийтийн сонсголыг зохион байгуулна. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тухайн оны дүүргийн төсвийн төслийг олон нийтэд танилцуулах зорилгоор нийтийн сонсголыг зохион байгуулна. | Төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тухайн оны дүүргийн | Төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажил болон тухайн оны дүүргийн төсвийн төсөлтэй танилцуулан ажилласан. | Төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажил болон тухайн оны дүүргийн төсвийн төсөлтэй танилцах төсвийн ил тод байдал хангагдсан байна. | | | СТСХ | Иргэдийн Төлөөлөгчдын хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн "Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай" 11/67 дугаар тогтоолоор Дүүргийн хөрөнгө оруулалтаар 102,256,194,6 мянган төгрөгийн өртөг бүхий 70 төсөл арга хэмжээ, Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1,690,843.5 төгрөгийн өртөг бүхий 7 ажил төлөвлөгдсөн. Тухайн ажлууд дээр 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/228 тоот захирамжаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй ажил хүлээн авах комисс мөн захиалагчийн хяналт тавих төслийн менежерүүд, тухайн гэрээ болон ажлын даалгаварт заасан тоо хэмжээний дагуу хяналт тавин Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнан, санхүүжилт олгогдсон гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны тухай хуульд заасан санхүүгийн ил тод байдлыг хангаж хуулийн хугацаанд цахим хуудсанд мэдээллэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төсвийн төслийн талаар олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна. | | | | | | | |
| ГУРАВ. Засаглалын бодлого /Нээлттэй, хариуцлагатай сүхбаатар дүүрэг/ | | | | | | | | | | | |
| 3.1 (4.1) Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай ил тод хүргэнэ. | | | | | | | | | | | |
| 81 | ДЗДҮАХ-4.1.1 | 4.1.1 Иргэдэд төрийн үйлчилгээг хөдөлгөөнт оффисоор үргэлжлүүлэн үзүүлнэ | Хөдөлгөөнт оффис ажиллах журмын дагуу хэлтэс, нэгжүүд иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах, тайлагнах, боломжтой асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллана. Төрийн бусад дээд шатны байгууллагуудаас зохион байгуулж буй үйл ажиллагаануудад иргэдийг оролцуулах, хамтран ажиллах | Үйл ажиллагаан ы хэрэгжилт хувиар | Засаг дарга болон Засаг даргын орлогчоор ахлуулсан 2 баг хагас жил тутам хороодод ажиллаж байна. | Тухайн хорооны иргэдэд тулгамдсан асуудлыг газар дээр нь шуурхай шийдвэрлэж, дүүрэг, холбогдох хэлтсүүд дээр биеэр ирж үйлчилгээ авах боломжгүй ахмад, настан, ХБИ, цаг зав муутай иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах, нэг дороос мэдээ, мэдээлэл авах боломж нөхцөл хангагдсан байна. | 10.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Дүүргийн хороодод Хөдөлгөөнт оффис ажиллуулах тухай А/115 дугаар захирамжийн дагуу Засаг дарга Х.Болормаа, ТЗУХ-ийн дарга В.Гомбодорж, ТГУХ-ийн дарга М.Бямбасүрэн, ТНААХ-ийн дарга Т.Эдмон, ГЗБА-ны дарга Э.Зоригоо болон Хог тээврийн байгууллагуудын удирдлагуудын бүрэлдэхүүнтэй баг 2024 оны 05 дугаар сарын 07-наас 06 дугаар сарын 07-ны өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу хороодод ажиллалаа.<br>Иргэдэд төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэх, хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа танилцуулах, сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч боломжтой асуудлыг газар дээр нь шийдвэрлэн зорилго бүхий тус уулзалтаар 2020-2024 онд дүүргийн төсвөөр хийж хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний талаарх болон хороо тус бүрийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа тохижилт, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлэл өгч, тухайн хороо, иргэдийн тулгамдсан асуудлын талаар санал хүсэлтийг хүлээн авч ажилласан.<br>Дүүргийн 1-20 дугаар хорооны нийт 1574 иргэнтэй уулзалт хийж, амаар-133, бичгээр-261 иргэний санал хүсэлтийг хүлээн авч боломжтой асуудлыг газар дээр нь шийдвэрлэн хариулт өгч, бусад санал хүсэлтийг холбогдох хэлтэс, нэгжүүдэд хуваарилан ажиллав. | 100% |
| 82 | | | Дүүргийн нийт төрийн албан хаагчид болон гэрээт ажилтнуудтай хийх уулзалтыг хагас жил тутам зохион байгуулах | Үйл ажиллагаан ы хэрэгжилт хувиар | Дүүргийн дэргэдэх хэлтсийн албан хаагч нар болон хэсгийн ахлагч, гэрээт ажилтнуудтай 1 удаагийн уулзалт хийсэн. | Нийслэл, дүүргээс хийж гүйцэтгэж байгаа бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын болон бусад ажлуудын талаар танилцуулан харилцан мэдээ, мэдээллээр хангах, тэдний санал хүсэлтийг хүлээн авч бодлого үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх | 5.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Нийслэлээс хийж гүйцэтгэж байгаа бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын болон бусад ажлуудын талаарх танилцуулга болох Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын уулзалт 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулагдаж дүүрэг хороодын 123 албан хаагч, 120 хэсгийн ахлагч оролцсон. | 100% |
| 83 | ДЗДҮАХ-4.1.2 | ДЗДҮАХ-4.1.2 Дүүрэг, хороодын иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэх, төр засгийн тогтоол шийдвэрийг тогтмол мэдээлж, иргэн төвтэй болгоно | Хороодын Иргэний танхимд тогтмол зохион байгуулагддаг үйл ажиллагаанууддад иргэд, хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | Үйл ажиллагаан ы хэрэгжилт хувиар | Хорооны үйл ажиллагаанд залуучуудын оролцоо хангалтгүй, төсөв байхгүй тул тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжгүй. | Төрөөс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанууд болон дээд шатны байгууллагаас гарсан шийдвэрийн хэрэгжүүлж, иргэд, хүүхэд, залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэн мэдлэг мэдээллээр бүрэн хангаж ажиллана. | 40.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хуваарийг гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллалаа.<br>Тайлант хугацаанд хороодын Иргэний танхимуудад тогтмол зохион байгуулагддаг ахмадуудын хийн болон эрүүл мэндийн дасгал, шугаман бүжиг, нийтийн бүжиг, монгол бичиг, англи хэл, компьютерын сургалт, АА бүлгийн уулзалт зэрэг 23 төрлийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 3700 иргэд хамрагдаад байна. Мөн төрийн болон ТББ-уудтай хамтарсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зэрэг 205 үйл ажиллагаанд давхардсан тоогоор 10000 гаруй иргэнийг хамруулж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 84 | | | Дүүрэг, хороодын Иргэний танхимуудыг сургалтын зориулалтаар тохижуулж, тоног төхөөрөмжөөр хангаж тогтмол үйл ажиллагаатай болгоно. | Үйл ажиллагаан ы хэрэгжилт хувиар | | Хороодын албан хаагчид, гэрээт ажилтнуудад зориулсан чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг, харилцан суралцах арга зүйн сайн туршлага хэрэгжүүлэх ажлуудыг бүсчилсэн байдлаар улирал тутам холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | 284.5 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Холбогдох байгууллагуудтай хамтран 5,12 дугаар хорооны иргэний танхимын засвар хийж дуусган, 17, 2 дугаар хорооны иргэний танхимын тохижилтын зураг хийгдээд байна.<br>Бусад хороодын танхимын зураг төсөл хийх ажлын санал болон төсөвийн судалгаа хийгдэж байна. | 70% |
| 85 | | | Дүүргийн Нэг цэгийн үйлчилгээний танхимыг шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж, засвар үйлчилгээ хийж иргэдийн ая тухтай үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулах | Тоо хэмжээ | | Арилжааны аль нэг банктай хамтран орлого хүлээн авдаг ATM суурилуулж, засвар үйлчилгээ хийн үйлчлүүлэгчдэд ая тухтай хүлээлгийн сандал, утас цэнэглэгч, ухаалаг дэлгэц байршуулах, цайны булан шинээр нээж ажиллуулах, | 70.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Хэрэгжих хугацаа болоогүй | |
| 86 | ДЗДҮАХ-4.1.3 | 4.1.3 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор дүүргийн дэргэдэх хэлтэс, албад, хороодын иргэний танхимыг шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | ISO стандарт хэрэгжүүлсэн Хороодын ажлын байрны дотоод тохижилтыг шинэ интерьер дизайнаар тохижуулах | Тоо хэмжээ, чанар | Дүүргийн 6,10,11 дүгээр хороодод чанарын менежментийн удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршлийн ISO 23592:2021 стандартыг нэвтрүүлэх төслийг НЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж гэрчилгээгээ авсан. | НЗДТГ-аас ирүүлсэн саналын дагуу тус хороодын тохижилтыг шинэ интерьер дизайнаар тохижуулж, иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх | 189.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Холбогдох байгууллагуудтай хамтран зураг төсөл хийх ажлын санал болон төсвийн судалгаа хийгдэж байна.<br>Дүүргийн 1-20 дугаар хороодын гадна шатыг засвар тендерээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан шинэчлэн засварлаж, 3,4,5,6,19,18 дугаар хороодын цонх бүрэн шинэчлэн сольж дулаан алдагдлыг бууруулж ажиллах нөхцөл боломжийг сайжруулж байна. | 80% |
| 87 | | | Засаг даргын Тамгын газрын, хороодын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ. | Тоо хэмжээ | | Материаллаг баазыг нэмэгдүүлсэн байна. | 257.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | | |
| 88 | ДЗДҮАХ-4.1.4 | 4.1.4 Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг жилд 2-оос доошгүй удаа олон нийтэд нээлттэй тайлагнана. | Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн сувгуудыг ашиглан иргэд, олон нийтэд тогтмол сурталчилна. | Хувиар | Дүүргийн Засаг дарга, ЗДТГ-аас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны мэдээ мэдээллийг sbd.gov.mn цахим хуудас, Засаг даргын Тамгын газар болон 1-20 дугаар хорооны нийт 23 пэйж хуудас /Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар дүүрэг, | Иргэдэд төрийн үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилт болон Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй бодлого, үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллийг шинэлэг хэлбэрээр олон | 100.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Засаг даргын “Хөгжилд хөтлөх Сүхбаатар” мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хүрээнд Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадаас хийж хэрэгжүүлж буй ажлын мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар болон албан ёсны цахим хуудас www.sbd.gov.mn, Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар, хороодын ЗДАА-ны пейжүүдээр дамжуулан олон нийтэд шуурхай хүргэн ажилласан. 2024 он Засаг даргын нэгэн бүрэн эрхийн хугацаа дууcч буй он тул салбар бүрт хийсэн хөрөнгө оруулалтыг нэгтгэн видео ажлууд, 20 хороо тус бүрт хийгдсэн хөрөнгө оруулалтаар танилцуулга бэлтгэн иргэдэд хүргэлээ. Тайлант хугацаанд 201 мэдээ бэлтгэн агуулга давхардсан тоогоор 10000 гаруй удаа олон нийтэд сурталчлав. Мөн дүүргийн пейжүүдээр захидлаар /чат/ хандсан 51 иргэний хүсэлтэд хариулт өглөө. Иргэдээс ирүүлсэн асуултыг агуулгаар нь ангилбал: Төрийн | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сүхбаатар дүүргийн-Шуурхай штаб/, ТВ2 телевизээр тус тус иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. | нийтэд хүргэж ажиллана. | | | | байгууллагуудын хаяг байршил, цагийн хуваарь, шагнал, хүүхдийн мөнгө, халамжийн үйлчилгээ, газрын албатай холбоотой асуудлуудаар түлхүү ханджээ. | |
| 89 | ДЗДҮАХ-4.1.6 | 4.1.6 Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор урамшууллын тогтолцоог сайжруулна | Албан хаагчдыг ажлын бүтээмж, гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | Арга хэмжээний тоо | 2 арга хэмжээ зохион байгуулж, 95 албан хаагч хамрагдсан | 2-с доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 100-гаас дээш албан хаагчийг хамруулсан байна. | 20.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Төрийн албан хаагчийг сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд Төрийн албаны тухай хуулийн танилцуулга, асуудал шийдвэрлэх арга зам сэдэвт сургалтыг зохион байгуулж, 50 албан хаагчийг хамруулсан. | 50% |
| 90 | ДЗДҮАХ-4.1.7 | 4.1.7 Шүүхийн шийдвэрийг биелүүлж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Эрх зүйн маргаантай асуудлаар хуулийн дагуу дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрыг төлөөлөх ажлыг зохион байгуулна. | Шүүх болон бусад байгууллагад төлөөлсөн, холбогдох баримтыг бүрдүүлсэн тоон үзүүлэлтээр | Захиргааны 37 хэрэг, иргэний 4 хэрэг маргаан бүрэн шийдвэрлэгдсэнээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 27 хэрэг, нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан 11 хэрэг, нэхэмжлэлийн шаардлагыг хэсэгчлэн хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгосон 3 хэрэг, шүүхийн шийдвэр биелүүлэх шатанд 8 хэрэг маргаан байна. | Байгууллагыг төлөөлөх ажлыг хуульд нийцүүлэн зохион байгуулсан байна. | | | ХЭЗХ | 2024 онд нийт 47 хэрэг маргаан шүүхэд хянагдаж, 24 хэрэг хаагдаж, 23 хэрэг хяналтад байна. Үүнээс:<br>Захиргааны 42 хэрэгт дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдож, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 15 хэрэг, Давж заалдах шатны шүүхэд 4 хэргийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 2 хэрэгт шинээр захиргааны акт гаргах хүртэл тодорхой хугацаагаар захиргааны актыг түдгэлзүүлж шийдвэрлэгдсэн.<br>Иргэний 3 хэрэгт Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж, 2 хэрэгт нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэгдсэн<br>Эрүүгийн 2 хэрэгт хохирогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон 1 хэргийг шүүхээр гэм буруутай тооцуулж шийдвэрлүүлсэн. | 100% |
| 91 | | | Холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагааг хууль журмын дагуу биелүүлнэ. | Биелүүлсэн шүүхийн шийдвэрийн тоогоор | Алтан дорнын хүч ХХК-ны нэхэмжлэлтэй хэргийн хохиролд Тусгай сангаас 25,000,000 төгрөг барагдуулан ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас 38,436,425 нийт 63,436,425 төгрөг барагдуулсан. | Дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт холбоотой Захиргааны болон иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлж, хохирол барагдуулах | 532.1 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгчтэй хохирол барагдуулах тооцоо нийлж газрын маргаан бүхий 5 шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлж, 2 захиргааны хэрэгт шүүхийн шийдвэрээр захиргааны акт хүчингүй болсныг мэдээллийн санд холбосон талаар албан бичиг төлөвлөж, төлбөр төлөх үүрэг бүхий Алтан дорнын хүч ХХК-д төлөх үлдэгдэл 96,563,575 төгрөгийн хохирлыг бүрэн төлж барагдуулсан. | 100% |
| 92 | ДЗДҮАХ-4.1.8 | 4.1.8 Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хувь | Хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн | Хөтөлбөрийг 95-аас дээш хувиар хэрэгжүүлж, албан хаагчдыг 100 хувь хамруулсан байна. | 200.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөг 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулсан. НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төв болон төрийн бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 270 гаруй, Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад 7 албан хаагч хамрагдсан.<br>Архивын ерөнхий газрын Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан бэлтгэх 1 сарын мэргэшүүлэх сургалтад 2, Сонгуулийн ерөнхий хорооны Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны цахим сургалтад 87 хамрагдсан. Докторын хөтөлбөрт 1, магистрын хөтөлбөрт 2, бакалаврын 5 албан хаагч суралцаж байна.<br>Төрийн албаны зөвлөлийн 7/4/10 цахим сургалтад 4 дэх өдөр бүр бүх албан хаагчдыг бүрэн хамруулсан.<br>Дүүрэгтэй хамтын харилцаатай БНХАУ, Япон, АНУ, Солонгос улс руу туршлага судлах сургалтад 64 албан хаагч хамрагдсан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 93 | | | "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хувь | Хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн | Хөтөлбөрийг 95-аас дээш хувиар хэрэгжүүлсэн байна. Нийслэлийн зарим чиг үүрэг дүүрэгт шилжихтэй холбогдуулан бүтэц шинэчлэгдвэл 299,500,000 төгрөг нэмэгдэнэ. | 1,149.5 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөг 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан. Хөтөлбөрийн хүрээнд 56 албан хаагчид нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж 435,0 сая төгрөг, төрийн захиргааны 7 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг шинээр, 28 албан хаагчийн ахиулан олгосон. Засгийн газрын 2024 оны 123 дугаар тогтоолоор цалингийн хэмжээг шинэчлэн баталсаны дагуу 120 албан хаагчийн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр шинэчлэн баталсан. | 100% |
| 94 | | | Хороодын хэсгийн ахлагч, гэрээт ажилтнуудын чуулга уулзалт, нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Дүүргийн гэрээт ажилтнуудын нэгдсэн чуулга уулзалтыг 1 удаа зохион байгуулсан | Төр засгийн бодлого шийдвэрийг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргэх, сурталчлах, төр иргэний харилцаа холбоог бэхжүүлэх үүрэг бүхий хороодын хэсгийн ахлагчид, ОНБ гэрээт ажилтнуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, харилцан туршлага судлуулах, шинэ мэдлэг мэдээлэл олгох зорилгоор чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулах | 80.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Тайлангийн хугацаанд хороодын хэсгийн ахлагч нар нийт 5 удаагийн нэгдсэн сургалт, уулзалтанд хамрагдаж, мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн байна. Үүнд:<br>- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчидтай хийх уулзалт /120 хэсгийн ахлагч/<br>- Хамтдаа гэрэлтэх оюунлаг ирээдүй ТББ-тай хамтран зохион байгуулсан Хувь хүний хөгжлийн ур чадварыг нэмэгдүүлэх нь сургалт /165 хэсгийн ахлагч/<br>- Үе тэнгийн дээрэлхэлт, гэр бүлийн тухай хуулийн шинэчлэлт, хороо ямар үүрэгтэй оролцох тухай мэдээлэл өгөх сургалт<br>- Иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт /180 хэсгийн ахлагч/<br>- Дүүргийн ХөХҮХ-тэй хамтран зохион байгуулсан Төсөл хөтөлбөрийн танилцуулга сургалт /193 хэсгийн ахлагч/ | 100% |
| 95 | НЗДҮАХ-4.1.1 ДЗДҮАХ-4.1.9 | 4.1.9 Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлж, төрд байгаа мэдээллийн санд үндэслэн иргэндээ үйлчилнэ. | Төрийн үйлчилгээний мэдээллийг төвлөрсөн удирдлагатай Онлайн бизнес төвийн ulaanbaatar.mn платформоор дамжуулан худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ. | Онлайн бизнес төвийн ulaanbaatar.mn системээр үйлчлүүлсэн ААНБ-ын тоо | Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний 1000 ААНБ | 200-гаар нэмэгдүүлнэ. | | | ХХҮХ | НЗД-ын 2021 оны "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/987 дугаар захирамжийн хүрээнд "Онлайн бизнес төв" платформын Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлж, 1905 ААНБ, иргэн худалдаа, үйлчилгээ эрхлэхээр хүсэлт илгээснээс 950 хүсэлтийг шийдвэрлэж, 809 хүсэлтийг буцааж, 146 хүсэлт хяналтын шатандаа явж байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/219 дүгээр захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, магадлан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай А/90 дүгээр захирамж гарч, ажлын хэсэг 16 удаа хуралдаж, дүүргийн Засаг даргын А/125, А/169, А/174, А/225, А/260, А/282, А/303, А/331, А/355, А/393, А/434, А/472, А/504, А/523, А/537, А/571 дугаар захирамжуудаар худалдааны 141, хоол үйлдвэрлэлийн 146, нийт 287 ААН-д тусгай зөвшөөрөл олгосон.<br>Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор баталсан Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэлжүүлэх журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/75 дугаар захирамжаар Мөнгөн зээлийн үйлчилгээг бүртгэлжүүлэх ажлын хэсэг байгуулагдаж,<br>Санхүүгийн зохицуулах хорооны License.frc.mn бүртгэлийн сайтаар ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хүлээн авч, нягтлан шалгаж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, 73 ААН хүсэлт ирүүлснээс 50 ААН, 2 иргэнд дүүргийн Засаг даргын А/154, А/223, А/329, А/439, А/529, А/572 дугаар 5 удаагийн захирамжаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээг олгон, License.frc.mn байршуулаад байна. | 90% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 96 | ДЗДҮАХ-4.1.10 | 4.1.10 Төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээр үзүүлэх хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор байрыг шинээр барина. | Хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор барилгыг шинээр барих болон засварлах ажлыг хэрэгжүүлнэ. | Хэрэгжилт хувиар | 17-р хорооны барилгын ажлын явц 35%-тай байна. | 2, 17-р хорооны барилгыг ашиглалтад оруулна. | 805.9 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 1.5 тэрбум төгрөг 17-р хорооны барилга шинээр барих ажлыг хийж байна. Тус ажлын нэмэлт санхүүжилт 655.9 сая төгрөгийг 2024 оны төсөвт тусгагдаж ДУУТЫН НУРУУ ХХК хийж дууслаа. | 100% |
| 97 | | | Хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор барилгуудыг засварлах, шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлнэ. | Хэрэгжилт хувиар | Засвар шаардлагатай хороодод | Шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттай шийдвэрлэнэ. | 1,016.7 | Дүүргийн төсөв | ТГУХ | Хороо, ӨЭМТ-н барилгын гадна шат довжоо, налуу зам хийх шинэчлэх, засварлах /3, 5, 8, 10, 12, 13, 15, 18, 19 дүгээр хороо/ 506.3 сая төгрөгийг дүүргийн 2024 оны төсөвт тусгаж худалдан авалтын захилгыг НОР ВҮ ИНЖ ХХК гүйцэтгэж байна.<br>2-р хорооны Хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор барилгын нэмэлт санхүүжилтийн барилгын ажил дээр ЭНХ ДОРМОН ХХК шалгарч барилгын ажлыг хийж байна. | 90% |
| 3.2 (4.2) Архив, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн аюулгүй байдлыг хангана. | | | | | | | | | | | |
| 98 | ДЗДҮАХ-4.2.1 | 4.2.1 Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж, түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана. | Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, нэгжүүдийн өргөдөл, гомдлын нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах, чадавхыг нэмэгдүүлэн, шийдвэрлэлтийн мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж, удирдлагуудад танилцуулна. | Зөрчлийн тоо | 2023 оны 10 дугаар сарын байдлаар өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон холбогдох файл хавсаргаагүй нийт 1818 зөрчил бүртгэгдсэн байна. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа болон хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо буурсан байна. | | | ТЗУХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар нийт 1210 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 1165, судлагдаж байгаа 37, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 8 өргөдөл байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 96,00 хувьтай байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 22 цаг 35 минут байна.<br>Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй гэх мэт 303 зөрчил бүртгэгдсэн байна.Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч бүрт өдөр тутамд мэдээлэл хүргэн ажиллаж байна. | 96% |
| 99 | ДЗДҮАХ-4.2.3 | 4.2.3 Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын хариуцлага бүтээмжийг нэмэгдүүлж, чадавхжуулна | Дүүргийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сургалт, арга зүйн ажлын төлөвлөгөө гарган, мэргэшүүлэх сургалтад хамруулж, ном гарын авлагаар хангана. | Арга хэмжээний тоо | 7 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 461 байгууллагын 546 албан хаагч хамрагдсан байна. | 3-с доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | 10.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ний өдөр хүртэл 4 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 228 байгууллагын 232 албан хаагч хамрагдсан байна. Архивын Ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 тушаалаар батлагдсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-ыг ном болгон харьяа байгууллага болон Засаг даргын Тамгын газрын хэлтэс, хороодод 110 ширхэгийг тараасан. 4, 58 дугаар сургууль, 13 дугаар хорооны архивын хадгаламжийн сангийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан архивын өрөөг стандартын дагуу засварлан, стандартын шаардлага хангасан нягтруулсан шүүгээ, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. | 100% |
| 3.3 (4.3) Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 100 | ДЗДҮАХ-4.3.1 | 4.3.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, ил тод байдлыг хангаж ажиллана | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна. | Хувь | 93,1 хувьтай хэрэгжсэн. | Хэрэгжилт 95-аас дээш хувьд хүрсэн байна. | 20.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Авлигатай тэмцэх газрын саналын дагуу Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Авлигын эсрэг 2024 оны үйл ажиллагааны 13 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталж, холбогдох хэлтэс нэгжүүдэд хүргүүлсэн. Батлагдсан төлөвлөгөөний дагуу авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 8 видео контентийг бүтээж, олон нийтэд хүргэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн танилцуулга, асуудал шийдвэрлэх арга зам сэдэвт сургалтыг 4 удаа зохион байгуулж, 100 албан хаагч, Нийтлэг гарч буй авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой цахим сургалтад 20 хорооны 196 хэсгийн ахлагчийг хамруулсан. Авилгатай тэмцэх газраас гаргасан видео шторк, зурагт хуудсуудыг ЗДТГ-аас хөтөлдөг 5, хороодын 20 нийт 25 пейж, 1 вэб сайтад нийтдээ 60 удаагийн давталттай олон нийтэд хүрсэн. Авлигын эсрэг 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн хяналт-шинжилгээ хийлгэж khutulbur.iaac.mn цахим системд байршуулсан. Жилийн эцсийн биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор нэгтгэн холбогдох дээд байгууллагад хүргүүлнэ. | 92% |
| 101 | | | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн зарим үйлчилгээг | Хувь | 90 хувьтай хэрэгжсэн. | Хэрэгжилт 90-ээс дээш хувьд хүрсэн байна. | 6.0 | Дүүргийн төсөв | ТЗУХ | Хэрэгжих хугацаа болоогүй | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цахимжуулах, нэгдсэн дуудлага хүлээн авах калл центр системийг ажиллагаанд оруулах ажлыг зохион байгуулна. | | | | | | | | |
| 102 | НЗДҮАХ-4.2.2, НХТ-3.2.6, ДЗДҮАХ-4.3.2 | 4.3.2 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна. | Төрийн албан хаагчдад авлига, албан тушаалын гэмт хэрэгт өртөх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор туршлага солилцох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх аян өрнүүлнэ. | Зохион байгуулсан нөлөөллийн ажил, тэдгээрт оролцсон албан хаагчдын тоогоор | Төрийн захиргааны болон үйлчилгээний 200 гаруй албан хаагчид Ёс зүйн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. | Албан хаагчдын эрх зүйн мэдлэг сайжирсан байна. | 30.0 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаа болон Прокурорын газар, хороодын Засаг даргын ажлын албатай хамтран Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тухай, Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад төрийн байгууллагуудын оролцоо хамтын ажиллагаа, анхаарах асуудал, Хамтарсан багийн үйл ажиллагаанд хорооны Засаг дарга болон хэсгийн байцаагчийн оролцоо, Хөршийн хяналтын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хэрэгцээ, шаардлага зэрэг сэдвүүдээр 70 албан хаагчдад хэлэлцүүлэг, сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа. 6,404,000 төгрөгийн төсөв зарцуулсан.<br>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчид Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн танилцуулга, асуудал шийдвэрлэх арга зам сэдвийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Байгууллагын ёс зүйн хорооны эрх үүргийн талаар мэдээлэл өгч, албан хаагчдад тулгарч буй асуудлыг хуулийн дагуу хэрхэн шийдвэрлэх талаар кейс ажиллалаа.<br>Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны А/450 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг дүүрэг дэх 5 сургууль, 12 цэцэрлэгт Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцсэн эсэх, төрийн албан хаагч гэмт хэрэг үйлдэх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалтыг 2024 оны 09 дүгээр сарын 02-13-ны өдрүүдэд хийлээ. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг хангах үүрэг даалгавар өглөө.<br>Нийслэлийн Ерөнхий боловсролын 2, 6 дугаар сургуулийн 153 гаруй багш, ажилчдад шинээр батлагдсан Боловсролын багц хууль, тогтоомж, Төрийн албан хаагчдын ёс зүйн хуулийн талаар танилцуулга, мэдээлэл хийлээ.<br>Сүхбаатар дүүрэг дэх төрийн 20 байгууллагын 700 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар 2 удаагийн танилцуулга, мэдээллийг 2024 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооноос зохион байгууллаа. | 100% |
| 103 | | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Олон нийтийн байцаагч нарыг холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр ажиллуулна. | Ажилсан олон нийтийн байцаагчийн тоогоор | 2023 онд 100 Олон нийтийн байцаагчдыг ажиллуулсан. | Гэмт хэрэг зөрчил буурсан байна. | 792.0 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Олон нийтийн байцаагч томилон ажиллуулах тухай Б/05 дугаар захирамжаар 01-20 дугаар хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий 100 олон нийтийн байцаагч томилогдсон.<br>Дүүргийн Засаг даргын захирамжаар 27 олон нийтийн байцаагчийг чөлөөлсөн, 30 олон нийтийн байцаагчтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан.<br>Дүүргийн 20 хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий 100 олон нийтийн байцаагчдад Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Улсын хэмжээнд мөрдөгдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сард 660,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосны дагуу 2024 онд нийт **756,773,916** төгрөгийн урамшуулал олгосон. | 100% |
| 104 | | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Олон нийтийн байцаагч нарт ажлын хувцас хийлгэх | Ажилласан олон нийтийн байцаагчийн тоогоор | 2022 оноос хойш ажлын хувцас хийлгээгүй | Ажлын хувцсаар хангагдсан байна. | 8.7 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/23 дугаар тушаалаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Олон нийтийн 96 байцаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажлын хувцас хантааз болон бичгийн хэрэгслээр хангав. 8,700,000 төгрөгийн төсөв зарцуулсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 105 | | | Жагсаал, цуглаан, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах мэдэгдлийг бүртгэх ажлыг зохион байгуулж нийтийн хэв журам аюулгүй байдлыг хангана. | Байгууллагад ирсэн мэдэгдлийн тоо, тэдгээрийг шийдвэрлэсэн тоогоор | 73 мэдэгдэл ирснээс 28 мэдэгдлийг бүртгэн авч, 2 мэдэгдлийг буцаасан, 43 мэдэгдэлд Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай хуульд заасан үндэслэлээр татгалзсан. | Жагсаал, цуглаан хийх мэдэгдэл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | - | - | ХЭЗХ | Тайлант хугацаанд дүүргийн Засаг даргад хандан жагсаал, цуглаан зохион байгуулах 59 мэдэгдэл ирснээс 33 мэдэгдлийг бүртгэн авч, 2 мэдэгдлийг буцаасан, 24 мэдэгдэлд Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай хуульд заасан үндэслэлээр татгалзсан. | 100% |
| 106 | | | Эрх зүйн боловсролыг дээшлүүлж, сургуулийн орчинд үйлдэгдэж буй хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Хамтдаа сэргийлье", гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг, эх асран хамгаалагчдын дунд "Та ч хүүхэд байсан" аяныг тус тус зохион байгуулна. | Зохион байгуулсан аян, сургалтын тоо, тэдгээрт оролцсон байгууллага, ААН, иргэдийн тоогоор | Тус хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 9 удаагийн сургалт, хийж, давхардсан тоогоор 900 орчим хүн хамрагдсан. | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах чиглэлээр үе шаттай ажил хийсэн байна. | 20.0 | Дүүргийн төсөв | ХЭЗХ | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Авлигатай тэмцэх газар, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тухай, Авлигын шалтгаан нөхцөл, гарах хор уршиг, гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл, стрессийг удирдахуй, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, шүүх хуралдаанд оролцохын ач холбогдол, тэдгээрийн идэвхийг нэмэгдүүлэх нь сэдвээр 3 удаагийн сургалтыг 20 хорооны 300 гаруй иргэдэд, хэв журмын 96 олон нийтийн байцаагч нарт зохион байгууллаа.<br>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Ерөнхий боловсролын 20 сургууль, 46 цэцэрлэгийн удирдлагуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиудын холбогдох заалтыг таниулах чиглэлээр эрх зүйн сургалтыг зохион байгууллаа.<br>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Прокурорын газар, "Төгөлдөр удирдагч" ТББ-тай хамтран "Эргээд нөлөөлье-3" аяны хүрээнд:<br>- Ерөнхий боловсролын 24 сургуулийн дунд, ахлах бүлгийн 1800 сурагчдад Цахим гадуурхалт сэдэвт 22 удаагий сургалтыг дүүргийн Прокурорын газраас,<br>- Ерөнхий боловсролын 6 сургуулийн дунд бүлгийн 600 гаруй сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдад нийт 6 удаагийн сургалтыг "Төгөлдөр удирдагч ТББ-ын Удирдахуй ухаан менежментийн академиас 2024 оны 04 дүгээр сарын 1-31-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан.<br>"Эргээд нөлөөлье-3" аяныг үргэлжлүүлэн 16 сургуулийн дунд бүлгийн 1600 гаруй сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдад 16 удаагийн Удирдахуй ухаан менежментийн академиас 2024 оны 10 дугаар сарын 16-наас 11 дүгээр сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулсан. | 100% |
| 107 | ДЗДҮАХ-4.3.3 | 4.3.3 Нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж, нэгтгэн тайлагнана | Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн тайлагнана. | Хяналтад авсан зүйл заалт, хэрэгжилтийн хувиар | 2023 онд 42 тогтоол, шийдвэрийн 61 заалтыг бүртгэж авч холбогдох хэлтэс, албадад танилцуулж, биелэлтийг хагас жилээр нэгтгэн ТГУХ-т мониторинг хийлгэн ажилласан. | 2023 онд шинээр батлагдсан болон өмнө нь хяналтад авсан дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн удирдлагад танилцуулна | | | ХЭЗХ | Нийслэлийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 3 тогтоол шийдвэрийн 5 заалтын биелэлтийг хүргүүлж,11 тогтоол, шийдвэрийн 19 заалтыг холбогдох хэлтэст танилцуулж хяналтад авсан.<br>Дээд газрын 45 тогтоол шийдвэрийн, 75 заалтын биелэлтийн мэдээллийг холбогдох хэлтэс, албадаас тайлант хугацаанд нэгтгэн авч дүүргийн Хяналт–шинжилгээний, үнэлгээний хэлтэст мониторинг хийлгэж ажилласан.Үүнд:<br>-Монгол Улсын хууль 3, хэрэгжилт 68,0%;<br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг 3, хэрэгжилт 60,0%;<br>-Засгийн газрын тогтоол 9 , хэрэгжилт 80,0 хувь;<br>-Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 5 , хэрэгжилт 75,0%;<br>-Ерөнхий Сайдын албан даалгавар 2, хэрэгжилт 85,0%;<br>-Нийслэлийн ИТХ-ын 2 тогтоол хэрэгжилт 95,0%<br>-Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл 1, хэрэгжилт 100%<br>-Нийслэлийн Засаг даргын албан даалгавар, хэрэгжилт 100%<br>-Нийслэлийн Засаг даргын 17 захирамж, хэрэгжилт 94,0%<br>-Дүүргийн ИТХ-ын тогтоол 2 хэрэгжилт 100% | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 108 | | | Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан албан хаагчдад хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйн талаар сургалт зохион байгуулна. | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 29 | 30 | 20.0 | Дүүргийн төсөв | ТГУХ ХШҮХ | | |
| 109 | ДЗДҮАХ-4.3.4 | 4.3.4 Татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар хураалтыг нэмэгдүүлнэ. | Хэлтсийн материаллаг баазыг нэмэгдүүлэх тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах | ширхэг | 90.0% | 100% | 254.1 | Дүүргийн төсөв | ТХ | Хэлтсийн шинээр баригдаж буй байр ашиглалтад орохтой холбогдуулан тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын саналыг дүүргийн Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэст хүргүүлснээр Худалдан авах ажиллагааны алба нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар зохион байгуулж нийт 35 нэр төрлийн 185 ширхэг 254,100,000.0 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж худалдан авсан. | 100% |
| 110 | | | Улс болон орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, Татварын ерөнхий хуульд заасан өр барагдуулах шат дараалсан ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана. | Хувиар | 90% | 100% | 70.0 | Дүүргийн төсөв | ТХ | Улсын төсөв: Төлөвлөгөө - 133,785,702 Гүйцэтгэл - 174,968,359<br>Хувь - 131%<br>Дүүргийн төсөв: Төлөвлөгөө - 457,647,842 Гүйцэтгэл - 430,427,856<br>Хувь - 94%<br>Нийслэлийн төсөв: Төлөвлөгөө - 13,024,697 Гүйцэтгэл - 14,719,104<br>Хувь – 113%<br>Нийлбэр дүнгээр Төлөвлөгөө - 604,458,241 Гүйцэтгэл - 620,115,318<br>Хувь – 103% байна.<br>Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр ханган биелүүлэхээр Татварын ерөнхий хуульд заасан шат дараалсан ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 111 | | | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар болон галт зэвсгийн албан татварыг төсөвт төвлөрүүлэх, Бүртгэлтэй хөрөнгийг татварт бүрэн хамруулах, өр барагдуулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар | 80% | 100% | 5.0 | Дүүргийн төсөв | ТХ | Тайлант жилд үл хөдлөх болон хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төрлөөр 31,533,941.97 мянган төгрөгийн татварын орлого төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 25,815,419.47 мянган төгрөгийг орлогыг төсөвт төвлөрүүлэн 81.87 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Үл хөдлөх эд хөрөнгийн төрлөөр 2024.05.31-ны өдрийн байдлаар дүүргийн төсөвт өссөнөөр 1,921,892,710 төгрөг төвлөрүүлэхээс 06 сарын 04-ны өдрийн барагдуулалтаар 1,738,541,292 төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 90,45 хувьтай байна. 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзоригийн “Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэж тоолох, татварт хамрагдалтыг сайжруулах, төсвийн орлогын нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэх ажлын удирдамж”-ийн дагуу хэлтсийн даргын А/17 тоот тушааалаар ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хүрээнд Татварын ерөнхий газрын Эрсдлийн удирдлагын газраас Татварын удирдлгын нэгдсэн системд бүртгэлгүй 1700 хөрөнгийн жагсаалт ирүүлсэн. 1700 хөрөнгөнөөс давхардсан 352, бүртгэлтэй 558, бүртгүүлбэл зохих 748 хөрөнгийн жагсаалтыг ялгаж гаргасан. Үүнээс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүртгүүлсэн 170 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэж 206,566.80 мянган төгрөгийн татвар ногдуулж, 65,297.2 мянган төгрөгийн барагдуулалттай байна. Мөн хэлтсийн даргын 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн “Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэж тоолох, татварт хамрагдалтыг сайжруулах, төсвийн орлогын нэмэлт эх үүсвэр бүрдүүүлэх” ажлын удирдамжийн дагуу 102 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэж 199,340.5 мянган төгрөгийн татвар ногдуулан 19,493.7 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн байна. Дээрх ажлын хүрээнд 2024 онд нийт 272 хөрөнгө бүртгэж, 147 хөрөнгө хасаж хөрөнгийн өөрчлөлт оруулсан. Үл хөдлөх эд хөрөнгөө бүртгүүлэх масс мессежийг 346 татвар төлөгчид хүргүүлэн ажилласан. Галт зэвсгийн төрлөөр 2024.10.31-ний өдрийн байдлаар дүүргийн төсөвт өссөнөөр 57,247.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 40,402.0 мянган төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 71 хувьтай байна. Шинэчилсэн бүртгэлээр 41 иргэн, 13 аж ахуйн нэгжийг шинээр бүртгэж ажилласан. ТУНС-д давхар буюу илүү бүртгэлтэй нэг төрлийн галт зэвсгийн нэршлийн хувьд өөр өөр байдлаар бүртгэгдсэн 66 галт зэвсгийн мэдээллийг засварласан. Татварын алба хооронд шилжүүлэх ажлын хүрээнд 21 татвар | 81% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | төлөгчийн 29 галт зэвсгийн татварын өрийг төлүүлэн шилжүүлсэн. Татварын удирдлагын нэгдсэн системийн хөрөнгийн бүртгэлийг тулгахад мэдээлэл дутуу, зөрүүдтэй бүртгэгдсэн, бүртгэл, ногдол давхардсан 71 галт зэвсгийг татварын удирдлагын нэгдсэн системээс хасалт хийж ажиллаж байна. | |
| 112 | | | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг барагдуулах ажлыг зохион байгуулна. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100% | 3.0 | Дүүргийн төсөв | ТХ | Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 2,760,116,001.00 төгрөгийн төлөвлөгөөнөөс 3,339,638,374.21 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. | 100% |
| | | | | | | | | | | байр", "Шалгалт-1,2", Дотуур байр" тусгай арга хэмжээ 6, Хүүхэд таныг хамгаалъя", "Та татгалз-2", "Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт", "Шалгалт", "Тэнэмэл", "Хичээл эхэллээ", "Хүүхэд хамгаалал" зэрэг 19 ерөнхий арга хэмжээ, 24 тусгай арга хэмжээнд идэвхтэй оролцсон.<br>Тухайлбал Хүүхэд хамгаалал арга хэмжээг улирал бүр зохион явуулж хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх чиглэлээр дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран орон сууцны 41 орц хонгил, 52 ресторан паб, 21 цахим тоглоомын газар, 15 зах, томоохон худалдааны төв, 16 авто угаалгын газар, 34 төвлөрсөн хогийн цэг, 8 дулааны худаг, 62 автобусны буудал зэрэг хүүхэд хоног төөрүүлж, орогнож болзошгүй бусад 167 цэгт 3 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан. Хүүхэд хамгаалагч нар хариуцсан 1-20 дугаар хороодын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд давхардсан тоогоор 642 удаа 2568 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн. | |
| 161 | | | Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдийн амьдралын хэв маяг, сэтгэл зүйд нөлөөлөх зорилтот арга хэмжээг зохион байгуулах | Зохион байгуулах арга хэмжээний тоо, хамрагдах иргэдийн тоо | 33 удаагийн нэгдсэн арга хэмжээнд 12052 иргэн хамруулж, тухайн чиглэлээр 400 өврийн дэвтэр, 1312 зурагт хуудас, 10 контент, 8 видео шторт хийж, 19600 орчим иргэдийн хандалт авч, 22,177,500 төгрөгийг ГХУСАЗСЗ-оос зарцуулсан | 34 удаагийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, 15,000 иргэн хамруулж, 10-аас доошгүй видео шторт, контент хийж иргэдэд хүргэнэ | 44.0 | Дүүргийн төсөв | ЦГ | Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, согтууруулах ундааны зүй зохистой хэрэглээ, архины хорт хөнөөлийг бууруулах зорилгоор дүүргийн Гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын хэлтэс, "Сэлбэ" бизнес инкубатор төв, "Зөв дадал" төрийн бус байгууллагатай хамтран "Бид зөв ирээдүйг бэлэглэнэ" арга хэмжээг зохион байгуулж 10-20 дугаар хороодод оршин суух хаягтай, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэл 3 ба түүнээс дээш давтамжтай ирүүлж, судалгаанд авагдсан 168 иргэнийг 7 хоног бүрийн баасан гарагт гар урлалын сургалтад хамруулан 5 иргэнийг ажлын байранд зуучилж, архины хамааралтай 41 иргэнийг зан үйл засах хувь хүний хөгжлийн сургалт, дэмжих бүлгийн уулзалтад хамруулснаар 10 гэр бүлийн 19 иргэн согтууруулах ундаанаас бүрэн татгалзсан зэрэг үр дүн үзүүлсэн. Уг төслийг иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор 2 удаагийн зорилтод нэвтрүүлэг хийж цагдаагийн газрын цахим хуудсанд байршуулсан. Ингэснээр 2024 оны эхний 10 дугаар сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үеэс 43 хувиар буурсан зэрэг үзүүлэлттэй байна. | 100% |
| 162 | ДЗДҮАХ-4.5.4 | 4.5.4 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон тусгай арга хэмжээг тогтмол зохион байгуулна | Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Ногоон гэрэл, цагаан шугам", "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнүүдийг зохион байгуулах | Оролцогчдын тоо | 2 удаагийн тэмцээнийг зохион байгуулж, ерөнхий боловсролын 24 сургуулийн 8500 сурагч, 12 цэцэрлэгийн 1270 хүүхдийг хамруулсан. | тэмцээн 2 удаа зохион байгуулж ерөнхий боловсролын 30 сургуулийн 9500 сурагч, 15 цэцэрлэгийн 1500 хүүхдийг хамруулсан байна. | 36.0 | Дүүргийн төсөв | ЗЦХ | Сүхбаатар дүүргийн засаг даргын 2024 оны "Замын хөдөлгөөний цагаан толгой тэмцээн зохион байгуулах тухай" А/136 дугаартай тушаалын хүрээнд тус дүүргийн Засаг даргын тамгын газар, Замын цагдаагийн хэлтэс, Улаан загалмайн хороо, Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс хамтран сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг эхчүүдэд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох дадлыг бага насны хүүхдүүдэд эзэмшүүлэх, зам тээврийн осол хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнийг энэ оны 04 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Дээрх арга хэмжээг зохион байгуулагдахад шаардагдах 19,986,000 /арван есөн сая есөн зуун наян зургаан мянга/ төгрөгийг Сүхбаатар дүүргийн засаг даргын 2024 оны "Замын хөдөлгөөний цагаан толгой тэмцээн зохион байгуулах тухай" А/136 дугаартай тушаалаар шийдвэрлүүлэн тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. "Замын хөдөлгөөний цагаан толгой 2024" тэмцээний шилдгүүдээр: Нэгдүгээр байранд 24 дүгээр цэцэрлэг, дэд байранд 243 дугаар цэцэрлэг, гутгаар байранд 25 дугаар цэцэрлэг, тусгай байранд 248, 109 дүгээр цэцэрлэг тус тус шалгарч, тэмцээнд оролцсон хүүхэд багачуудад гарын бэлэг гардуулж урамшуулсан болохыг танилцуулж байна. | 100% |
| 163 | НХТЖҮЧ-7.2.2, НЗДҮАХ-4.3.4, ХАХТ-4.3.4.2, ДЗДҮАХ-4.5.7 | 4.5.7 Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай техник тусгай хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна. | Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах шаардлагатай техник, тусгай хэрэгслээр хангана. | Тоног төхөөрөмжийн тоо | Шинээр | Өндөр хүчин чадал бүхий 1 ширхэг ус сорох төхөөрөмжийн насос, 1 зөөврийн гэрэлтүүлэг самбар. | 1,280.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Онцгой байдлын хэлтэст гамшгийн эрсдэлийг бууруулах материаллаг бааз бэхжүүлэхээр Мотопомп 3ш, Гэрэл үүсгүүр 1ш, Дизель генератор 1 ширхгийг худалдан авахаар 1.2 тэрбум төгрөг дүүргийн 2024 оны төсөвт тусгаж ЮНИТРА ХХК тендерт шалгарч бараа нийлүүлж ажилласан. | 100% |
| 164 | ДЗДҮАХ-4.5.9 | 4.5.9 Сууц өмчлөгчдийн холбоодын | Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах, | Сургалт, сурталчилгааны тоо | 2023 онд 100 сууц өмчлөгдийн холбоонд сургалт | 2 удаагийн давтамжаар 100-аас доошгүй сууц | | | ТНААХ | Хууль зүйн яамтай хамтран "Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай" хуулийн хэлэлцүүлгийг 2024 оны 04 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | хууль сурталчлах сургалт зохион байгуулна. | | зохион байгуулж, шинээр байгуулагдсан 20 СӨХ-нд холбогдох хууль дүрмийн талаар зөвлөгөө өгсөн. | өмчлөгчдийн холбооны удирдах ажилтанд сургалт зохион байгуулна. | | | | дүгээр сарын 04-ны өдөр зохион байгуулж дүүргийн 1-11 дүгээр хорооны 65 СӨХ, 89 иргэн оролцлоо. Нийслэлийн онцгой байдлын ерөнхий газартай хамтран үерийн уснаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийн сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн зохион байгуулж 35 СӨХ хамрагдлаа. | |
| 165 | | | Сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна. | Шалгалтад хамрагдсан сууц өмчлөгчдийн холбооны тоо | Дүүргийн нутаг дэвсгэрт 231 СӨХ үйл ажиллагаа явуулж байна. | 231 сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | 65.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлттэй хамтран 2024 оны 09 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд 235 сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. | 100% |
| 3.6 (4.6)Хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллана. | | | | | | | | | | | |
| 166 | НЗДҮАХ-3.4.3 ДЗДҮАХ-4.6.1 | 4.6.1 Аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний байгууллагуудын соёл, чанарыг сайжруулж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд хүргэж, үйлчилгээний байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | Аялал жуулчлал, худалдаа, хүнсний болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын соёл, чанарыг сайжруулж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд хүргэж, үйлчилгээний байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, дэмжиж ажиллана. | Зохион байгуулах арга хэмжээ, ААНБ-ын тоо | 15 удаагийн сургалтаар 1400 ААН, иргэнийг хамруулж, үйлчилгээний салбарын 15 ажиллагсдыг шагнаж урамшуулсан. | Танхимын 4, цахимаар 2, нийт 6 сургалт, хэлэлцүүлэгт 800 ААНБ, иргэнийг хамруулна. | 10.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Худалдаа, үйлчилгээний байгууллагуудад холбогдох хууль тогтоомж, стандартыг сурталчлах зорилгоор нийт 6 удаагийн цахим болон танхимын сургалт зохион байгуулж, нийт 250 гаруй ААН, иргэдийг хамруулсан. Үүнд: НЗД-ын 2024 оны А/367 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газар, 4 дүгээр хорооны Засаг даргын ажлын албатай хамтран, Цэрэндоржийн гудамж дахь ААНБ-дад Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага, Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага, Худалдаа үйлчилгээний газрын нэр, үйлчилгээний мэдээлэл, гадна зар сурталчилгаа тавигдах шаардлага, стандартуудыг танилцуулж, хүн амын хүнсний аюулгүй байдал, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрхэн хангаж ажиллах чиглэлээр 50 гаруй ААН-дэд сургалт явуулж, мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажилласан.<br>Дүүргийн ЭМТ-тэй хамтран “БЗДХ-ын эрсдэлийг бууруулахад зочид буудлын эзэд, үүд баригч нарын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулж, зочид буудал, дэн буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 45 ААН-ийг хамруулсан.<br>НЗД-ын “Улаанбаатар марафон-2024” олон улсын гүйлтийг зохион байгуулах талаар авах арга хэмжээний тухай А/574 дүгээр захирамж, Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай А/613 дугаар захирамж, УБ хотын Ерөнхий менежерийн Үндэсний их баяр наадмын үеэр худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих тухай А/120 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд олон улсын марафон болон хүүхдийн баяр, Үндэсний их баяр наадмын худалдаа, үйлчилгээг УБЗАА, НХХААГ, НЭМГ, ЦХ, ОБХ, НХХ-тэй хамтран Д.Сүхбаатарын талбай, Амарын гудамж, Сөүлийн гудамж, Хүй 7 худагт зохион байгуулж, нийт 140 гаруй ААНБ, иргэнд зөвшөөрөл олгон, гарын авлага материалаар хангаж, заавар зөвлөгөө өгч, хүнсний чанар аюулгүй байдал, ариун цэвэр эрүүл ахуй, галын аюулгүй байдлыг хангуулж, зөвшөөрөлгүй гар дээрх худалдааг зогсоох арга хэмжээ авч ажилласан. | 100% |
| 167 | НЗДҮАХ-3.3.2 ДЗДҮАХ-4.6.2 | 4.6.2. Мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна. | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ. | Вакцинд хамрагдах амьтны тоо | ДЗД-ын А/203 дугаар захирамжаар 3899 нохойд вакцинжуулалт, туулгалт, халдваргүйтгэлд 9,780,000 төгрөг зарцуулсан. | НМЭГ-аас баталсан тоогоор | 15.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | ХХААХҮЯамны Сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, сэг зэм устгах тухай" 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 07-ний өдрийн “Дархлаажуулалтын төлөвлөгөө батлах тухай” А/68 дугаар тушаал, 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах ажлын удирдамж”-ийн дагуу дүүргийн Мал эмнэлгийн нэгж Овоот гол ХХК, хороодын ажлын албадтай хамтран мал, амьтны сэг зэмийн устгалд 22 мал, 154 (нохой 135, муур 14, шувуу 5) амьтан, нийт 176 мал, амьтныг оруулж, устгалын цэгийн 3364 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, үйлчилгээний байгууллагуудын түүхий эд бүтээгдэхүүн хадгалах 98 цэгийн 5216 м2, бэлчээр, гуу жалганы 3204 м2, нийт 11784 м2 талбайд халдваргүйжүүлэлт хийсэн.<br>Мал, амьтны эмчилгээ, үйлчилгээг 34 мал, 319 нохой, 57 муур, нийт 410 мал, амьтанд үзүүлж, халдварт болон гоц халдварт | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Мал эмнэлгийн үйлчилгээ хэрэгжүүлэх тухай А/287 дугаар захирамжийн хүрээнд галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуултад 1204 өрхийн 2198 нохой, шимэгчтэх хорхойн туулгалтад 915 өрхийн 1485 нохойг хамруулсан. Нохойн байр, үүр, уяаны эргэн тойрны 8950 м2 талбайд халдваргүйжүүлэлт хийсэн.<br>Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээнд 11,7 тн мах, махан бүтээгдэхүүн 3,3 тн сүү, сүүн бүтээгдэхүүнийг оруулж, мал эмнэлгийн цахимд бүртгэж, баталгаажуулсан. Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг нийт 20734 м2 талбайд хийсэн байна. | |
| 168 | | | Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн малыг гаргах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана | Хориглосон бүсээс гаргасан малын тоо | ДЗД-ын А/29 дүгээр захирамжаар мал гаргах хяналт шалгалтад 900,000 төгрөг зарцуулж, 2032 мал гаргасан. | Хориглосон бүс рүү орж ирсэн малын тоогоор | 40.0 | Дүүргийн төсөв | XXYX | НЗД-ын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/07, 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн Журмын хэрэгжилтийг хангуулах тухай А/1024, ДЗД-ын 2024 оны Үйл ажиллагааны зардал батлах тухай А/08, А/95 дугаар захирамжуудын хүрээнд УБ хотын ЕМ-ийн 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр баталсан “Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах хуваарь”-ийн дагуу дүүргийн дэд ажлын хэсэг хяналт шалгалтыг тогтмол явуулж, хориглосон бүсээс 2079 толгой малыг гаргаж, суурин малтай 18 өрхөд Мэдэгдэл, шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 9 иргэнд 9,250,000 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 9 иргэнд зөрчлийн хэрэг нээж, хяналт шалгалтад давхарсан тоогоор 1614 албан хаагч ажиллаж, дүүргийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар 29,748,150 төгрөг гаргаж, мал туухад оролцсон албан хаагчдын хоол, тээврийн хэрэгслийн бензины болон бусад зардлын асуудлыг шийдвэрлэсэн.<br>НИТХ-ын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам"-ын 2.1 дэх заалтын дагуу хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах хашаа барих газрын байршлын санал, кадастрын зургийг НХХААГ-т 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 2/575 дугаар албан бичгээр хүргүүлж, дүүргийн 19 дүгээр хороо, Хандгайтын зуслангийн хүүхдийн Янзага амралтын газраас дээш замын баруун доод хэсэгт 3004,0 кв2 талбайд барих малын хашаа, харуулын байрны зардал болох 50,672,000 төгрөгийг ДЗД-ын 2024 оны А/573 дугаар захирамжаар шийдвэрлэж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 3/1685 дугаар албан бичгээр дүүргийн ЗДТГ-ын нэр дээр газрын гэрчилгээ гаргаж, баталгаажуулж өгөх хүсэлтийг илгээж, Ажлын хэсгийн шийдвэрээр Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-т орон тоо гаргаж, мал туух чиглэлээр 2 гэрээт ажилтан авч ажиллуулснаар 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 193 удаагийн туултаар 1530 малыг хориглосон бүсээс гаргасан. | 90% |
| 169 | | | Худалдаа, үйлчилгээний газруудад стандартын шаардлагыг хангуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт явуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. | Шалгалтад хамрагдсан ААНБ-ын тоо | 5 удаагийн хяналт шалгалтаар худалдаа-400, хоол үйлдвэрлэлийн 40, аялал жуулчлал-90, авто засвар-25, нийт 555 ААН | Худалдаа, үйлчилгээний салбарын чиглэлүүдээр нийт 600 ААНБ | 4.0 | Дүүргийн төсөв | XXYX | Худалдаа, үйлчилгээний байгууллагуудад холбогдох хууль тогтоомж, стандартыг хангуулах зорилгоор нийт 25 удаагийн хяналт, шалгалтаар 500 гаруй ААНБ, иргэдийг хамруулсан. Үүнд:<br>• ННТГ-тай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 03-05-ны өдрүүдэд Авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 26 иргэн, ААН-ийн үйл ажиллагаанд;<br>• НЗД-ын 2024 оны А/367 дугаар захирамжийн дагуу хяналт шалгалт явуулах ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 12-17-ны өдрүүдэд худалдаа, үйлчилгээний газруудад холбогдох хууль тогтоомж, норм, стандартын хэрэгжилтийг худалдаа, үйлчилгээний 8 иргэн, 25 ААН-ийн үйл ажиллагаанд;<br>• Мөнгөн зээлийн үйлчилгээний цахим бүртгэлийн систем, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг хангуулах чиглэлээр дүүргийн Засаг даргын 2024 оны А/43 дугаар захирамжийн дагуу нийт 30 ААН-ийн үйл ажиллагаанд;<br>• ХХААХҮСайдын 2023 оны “Хяналтын хуудас батлах тухай” А/540 дугаар тушаал, НЗД-ын 2023 оны А/1116, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2024 оны Согтууруулах ундаа худалдах, түгээх үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, магадлан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай А/90 дүгээр захирамжуудын хүрээнд согтууруулах ундаа худалдах, түгээх | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн 555 ААН-ийн 350 гаруй ажлын байранд гүйцэтгэлийн хяналт хийж, тусгай зөвшөөрөл олгох саналыг Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.<br>• УБ хотын ЕМ-ийн 2024 оны 01/1320 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг чиглэл, 2024 оны А/35, А/180 дугаар тушаалуудаар баталсан удирдамжийн дагуу 7 буудлын эцэст зөвшөөрөлгүй гар дээрээс худалдаа эрхэлж байгаа 22 иргэний, 32 алжаал тайлах төв, баар/тайчих клуб, хими цэвэрлэгээ, угаалга, хатаалгын 13, нийтийн халуун усны 10 газрудын үйл ажиллагаанд УБЗАА, Цагдаагийн хэлтэс, НХХААГ, НМЭГ, ХөХҮХ, НБОГ-тай хамтран хяналт шалгалт явуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | |
| 170 | | | Түргэн үйлчилгээний цэгт холбогдох журмын хэрэгжилтийг хангуулна. | Нүүлгэсэн ТҮЦ-ийн тоо | 2023 онд 37 ТҮЦ нүүлгэсэн. | ХУЗЗ-ийн хурлаар шийдвэрээр нүүлгэх ТҮЦ-д шаардагдах санхүүжилтээр /60ш/ | 60.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны Түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж, нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлөх тухай А/212 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 7 дугаар хорооны 8, 9 дүгээр байрны дундах 1, 8 дугаар хорооны МУИС-ийн Бизнесийн их сургуулийн урд талаас 1, Хангай хотхон Номин супермаркетийн баруун урд талаас 2, Сөүл эмнэлгийн зүүн талаас 5, Нийслэлийн Авто замын газраас хийж буй явган болон дугуйн замын тохижилтын ажлын хүрээнд 3-р сургуулийн урд байрлаж буй 8 ТҮЦ-ийг дүүргийн ГЗА-тай хамтран, иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу Цэрэндоржийн гудамжид зөвшөөрөлгүй байрлуулсан зуны үйлчилгээний 4, Урчуудын эвлэлийн төв байрны араас 2 явуулын хоолны үйлчилгээг албадан нүүлгэж, нийт 23 ТҮЦ-ийг албадан нүүлгэж, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлсөн.<br>Мөн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр иргэдээс удаа дараа гомдол ирүүлж буй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд хүнсний бүтээгдэхүүн худалдаалсан, орчны цэвэрлэгээг хангалтгүй хийдэг нэн тэргүүнд нүүлгэх шаардлагатай ТҮЦ-үүдийн судалгааг хороодын Ажлын албатай хамтран гаргаж байна. | 100% |
| 171 | | | Дүүргийн Худалдаа үйлчилгээг зохицуулах Зөвлөл болон Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйлийг устгах, улсын орлого болгох Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Зөвлөлийн хурлын тоо | ХУЗЗ-ийн хурал-6 удаа, ЭЗХУОБЗ-ийн хурал 6 удаа | Тухайн цаг үеийн асуудлаар зохион байгуулах хурлын тоогоор | 5.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Дүүргийн Засаг даргын дэргэдэх Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйлийг устгах, улсын орлого болгох Зөвлөл нийт 20 удаа хуралдаж, 37 нэр төрлийн 404 ш согтууруулах ундаа, 21 нэр төрлийн 2177 хайрцаг тамхийг улсын орлого болгох Зөвлөлийн шийдвэрийн дагуу Үнэлгээний комиссоос тогтоосон үнээр гэрээт хүнсний дэлгүүрээр дамжуулан худалдан борлуулж, нийт 13,081,470 төгрөг, зөрчлийн улмаас бэлнээр хураагдсан 10,000 төгрөгийг Төрийн сан банкны 100200600910 тоот дансанд тус тус төвлөрүүлсэн.<br>Зөрчлийн улмаас хураагдсан 17 нэр төрлийн 931 ш согтууруулах ундаа, 8 нэр төрлийн 1 бүтэн хайрцаг, 75 ш задгай тамхийг Устгалын комисс холбогдох журмын дагуу устгаж, зөрчлийн улмаас хураагдсан 1ш цахилгаан бороохойг дүүргийн Цагдаагийн газрын тусгай хэрэгцээнд шилжүүлсэн.<br>Улсын Ерөнхий прокурорын баталсан удирдамжийн дагуу дүүргийн Прокурорын газраас явуулсан хяналт шалгалтад хамрагдаж, Зөвлөлийн эхний 9 сарын ажлыг тайлагнаж, Сайн үнэлгээ авсан.<br>Дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2 удаагийн хуралдаанаар Ulaanbaatar.mn цахим сайтын Онлайн бизнес төвөөр дамжуулан Зуны түр худалдаа үйлчилгээ эрхлэхээр ирүүлсэн 175 иргэн, ААН-ийн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, худалдааны 24, явуулын хоолны 42 цэгийн байршлыг батлан, зөвшөөрөл олгон, зуны үйлчилгээний явц байдал, хүнсний чанар аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажилласан.<br>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16.3 дахь хэсгийг үндэслэн спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх түр зөвшөөрөл хүссэн 9 ААН-ийн саналыг хэлэлцэн, шаардлага хангасан 6 ААН-д түр зөвшөөрөл олгон, дүүргийн Цагдаагийн газартай хамтран тухай бүр хяналт тавин ажилласан.<br>Мөн бараа бүтээгдэхүүний танилцуулга, тусгай хөтөлбөр бүхий өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулахаар Зөвлөлд ирүүлсэн 13 ААН, иргэний хүсэлтийг авч хэлэлцэн, холбогдох зөвшөөрлийг Драмын талбай, Битлзийн талбайд тус тус олгосон. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 172 | | | Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт хангуулан ажиллана. | Аж ахуйн нэгжийн тоогоор | 2023 онд ДЗД-ын 6 удаагийн захирамжаар 27 ААН, иргэнд тамхи худалдах зөвшөөрөл олгосон. | 2021 онд зөвшөөрөл олгосон 45 ААН-ийн зөвшөөрлийг сунгана. | | | ХХҮХ | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь хэсгийг тус тус үндэслэн 2024 оны байдлаар дүүргийн Засаг даргын А/47, А/74, А/116, А/177, А/274, А/289, А/392, А/451, А/574 дугаартай 9 удаагийн захирамжаар нийт-23 аж ахуйн нэгж, иргэнд тамхи худалдах зөвшөөрөл олгон, захирамжийг дүүргийн sbd.gov.mn, license.mn цахим хуудаст байршуулан, ил тод мэдээлэн ажиллаж байна.<br>Нийслэлийн Засаг даргын Электрон тамхи худалдан авагчдад насны хязгаар тогтоох 2023 оны 12 дугаар сарын 22 ны өдрийн А/1467 захирамжаар Электрон тамхи худалдан авагчдад насны хязгаар тогтоох, эрүүл аюулгүй аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс 18 нас хүрээгүй хүүхдэд электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох ажлын хүрээнд 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ явуулдаг 800 гаруй хүнсний дэлгүүр 16 зах худалдааны төвөөр захирамжийг танилцуулан зарахыг хориглосон зурагт хуудсыг байршуулан гарын үсэг зуруулж, ерөнхийн боловсролын 7 сургуулийн 300 гаруй сурагчдад Электрон тамхины хор хөнөөл сэдэвт сургалтыг зохион байгуулан ажилласан.<br>Дүүргийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны А/51 дүгээр захирамжаар 275 мянган төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэн дүүргийн нутаг дэвсгэрт Электрон тамхи худалдан борлуулдаг 800 гаруй хүнсний дэлгүүр, худалдааны төв болон ТҮЦ-үүдэд Электрон тамхийг насанд хүрээгүй хүүхдэд зарахгүй байх зурагт хуудсыг байршуулан ажилласан. | 100% |
| 173 | НЗДҮАХ-1.1.2, 3.3.1.4, 3.3.3, ДЗДҮАХ-4.6.3 | 4.6.3 Дүүргийн иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр тогтвортой хангах, бодлого баримталж ажиллана. | Хүнсний зохистой хэрэглээ, аюулгүй, баталгаат хүнс сонгох талаар хэрэглэгчийн боловсролыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна. | Арга хэмжээний тоо | 4 удаагийн сургалтад 480 ААН, иргэн | 2 удаагийн арга хэмжээгээр 250 ААНБ, иргэн | 3.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, соён гэгээрүүлэх, иргэдийн хүнсний боловсролыг сайжруулах зорилтын хүрээнд дүүргийн Тамгын газраас хүнсний бараа бүтээгдэхүүний шошгын мэдээллийг хэрхэн зөв уншиж, хүнсээ зөв сонгох, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын талаарх олон нийтэд зориулсан зөвлөмжийн зурагт хуудас болон Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн С/77 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Жижиглэн, худалдааны газар, түүний үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS 5021-1:2024 стандартыг СБД-ийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс пейж хуудас, СБД хоол үйлдвэрлэл, үйлчилгээ фэйсбүүк групп, СБД-Худалдаа, СБД-Зах, худалдааны төвүүд, СБД-үйлдвэрүүд, SBD food чат групп, ХХҮХ-Хороод бүлэг, СБД-ийн 1-10 дугаар хороо, Хойд хороод 11-20 дугаар хороодын мессенжерийн бүлэг чат зэрэг мэдээллийн сүлжээгээр дамжуулан сурталчлан ажиллаж байна.<br>Хүн амын хүнсний боловсролын нэмэгдүүлэх зорилтын хүрээнд худалдаа, үйлчилгээний байгууллагуудад "Хүнсний салбарын өнөөгийн чиг хандлага сургалтыг НХХААГ, НХХ, ХөХҮХ-тэй хамтран зохион байгуулж, хүнсний чанар аюулгүй байдал, мөрдөгдөж буй стандартууд, жижиглэн худалдааны стандарт, Ulaanbaatar.mn цахим үйлчилгээний талаарх цогц мэдээлэл өгч, 100 гаруй ААНБ-ыг оролцуулж, хүнсний зө хэрэглээний зөвлөмж, гарын аьлага материалаар хангаН ажиллалаа. | 100% |
| 174 | | | Хүн амын махны хэрэглээг нэмэгдүүлэх, үнэ тогтворжуулах зорилгоор нөөцийн махны жижиглэнгийн болон бөөний өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. | Борлуулалтын цэг болон өргөтгөсөн худалдааны тоо, махны хэмжээ, тн | Жижиглэнгээр-46 дэлгүүр, 14 удаагийн өргөтгөсөн худалдаагаар, нийт 197,0 тн | Дэлгүүрийн тоог 5-аар нэмэгдүүлнэ. Борлуулалтын дүнгээр | 0.5 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны Журам батлах тухай А/344 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1147 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны Хүн амын стратегийн хүнсний нөөцийг тогтвортой, тэнцвэртэй байлгах зорилтын хүрээнд авах зарим арга хэмжээний тухай А/233 дугаар тушаалын дагуу дүүргийн хэмжээнд нөөцийн мах худалдах 30 дэлгүүртэй гэрээ байгуулж, махны худалдааг 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлж, хүнсний дэлгүүрийн жижиглэнгийн худалдаагаар хонь-37,291.9 тн, үхэр-40,636 тн, нийт 77,906.8 тн мах, өргөтгөсөн худалдаагаар 8 байршлын 33 явуулын цэгээр нийт 328,6 тн мах худалдаалагдсан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Нөөцийн махны борлуулалтын дүн мэдээг УБЗАА-аас баталсан хүснэгтийн дагуу 7 хоног тутамд гаргаж, цахимаар хүргүүлэн ажилласан.<br><br>Нөөцийн махны чанар аюулгүй байдал, хүрэлцээ хангамж, татварын и-баримт олголт, эрүүл ахуй, халдвар хамгаалал зэрэг асуудлаар сургалт, уулзалтуудыг 3 удаа зохион байгуулж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан удирдамжийн дагуу нөөцийн мах худалдаалж буй 30 дэлгүүрийн үйл ажиллагаанд УБЗАА-ны ХХҮХ, НХХААГ-ын Хяналтын хэлтэс, НМЭГ-ын Хяналтын хэлтэс, дүүргийн Татварын хэлтэстэй хамтран шалгалтыг 4 удаа явуулж, байнгын хяналт тавин ажилласан. | |
| 175 | | | Дүүргийн иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, өрхийн тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулна. | Борлуулалтын цэгийн тоо, ургацын хэмжээ тн | ДЗД-ын А/390, А/409 дүгээр 2 удаагийн захирамжаар өргөтгөсөн худалдаанд 17,600,000 төгрөг зарцуулж, өргөтгөсөн худалдааны 5 байршилд нийт 23 нэр төрлийн 128,1 тн хүнсний ногооны 386,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Өрхийн тариаланч 184 өрхөд үр авахад дэмжлэг үзүүлж, ДЗД-ын А/214 дүгээр захирамжаар 888,157 төгрөг зарцуулсан. | Өрхийн тариалан эрхлэгч 200 иргэнд ногооны үр худалдан авахад дэмжлэг үзүүлэх, байнгын ногооны борлуулалтын цэгийн засвар үйлчилгээ, Худалдааны цэгийн байршил, борлуулалтын хэмжээгээр | 25.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжиж, ДЗД-ын А/178 дугаар захирамжаар ХХААХҮЯ-аас 80%-ийн хөнгөлөлттэй үнээр олгож буй 8 нэр төрлийн 44,1 кг хүнсний ногооны үр худалдан авах зардлыг шийдвэрлэн, 12-20 дугаар хороодын 180 гаруй өрхийн тариалан эрхлэгчдэд олгож, төмс хүнсний ногоо тариалах хялбаршуулсан зөвлөмж, гарын авлага материалаар хангасан.<br>Дүүргийн хэмжээнд 2024 онд 148 өрхийн тариалан эрхлэгчид 0,26 га-аас 2,89тн төмс, 0,41 га-аас 4,073 тн хүнсний ногоо, 0,273 га хамгаалагдсан хөрс буюу хүлэмжээс 7,33 тн хүнсний ногоо хураан авч, хүнсний хэрэгцээгээ хангасан байна.<br>Өрхийн тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, 12 дугаар хороо, 32-ын тойрууугийн зам дагуу хүлэмжид модны үрсэлгээ, мандлын цэцэг, хүнсний ногооны үрсэлгээ, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн худалдаа эрхлэх хүсэлттэй 12 иргэнийг дүүргийн ЗДТГ-ын ХХҮХ, хорооны Ажлын алба, НБОГ-ын Ойн хэлтэстэй хамтран уулзалт зохион байгуулж, газар тариалангийн нэгдсэн мэдээллийн сан болон мэргэжлийн хяналтын мэдээллийн нэгдсэн санд хэрхэн бүртгүүлэх талаар заавар зөвлөгөө өгч, орчны 50м хүртэлх талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, хог хаягдал, хүнсний чанар аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, өргөтгөсөн худалдаагаар 20 нэр төрлийн 3767 ш модны үрсэлгээ худалдаалж, 37,956,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.<br>Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд шинэ ургацын хүнсний ногооны “Алтан намар-2024” өргөтгөсөн худалдааг 2024 оны 09 дүгээр сарын 05-11-ний өдрүүдэд Хичээнгүй сайд Б.Цэрэндоржийн гудамжид зохион байгуулж, дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдээс гадна Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Ховд аймгийн 20 гаруй тариаланчдыг оролцуулж, эх орны хөрсөнд ургасан 3,2 тн төмс, 13,8 тн хүнсний ногоо, 1,2 тн жимс, жимсгэнэ зэргийг худалдаалж, амин дэмээр баялаг, эрүүл хүнсийг нийслэлчүүдийн хэрэгцээнд нийлүүлсэн.<br>Хүнсний ногооны намрын өргөтгөсөн худалдаагаар 23 нэр төрлийн 152,6 тн төмс, хүнсний ногоо, 1,2 тн жимс, жимсгэнэ худалдаалж, 469,599,300 төгрөгийн борлуулалт хийж, иргэдийн хэрэгцээнд нийлүүлсэн. | 100% |
| 176 | | | Хүн амын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоог шинэчилж, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн, мэдээ тайланг тогтмол гаргана. | Гэрээт газруудын тоо, хүнсний хангамжийн мэдээлэл тоогоор | Дүүргийн жишсэн хүн амын 116572 тоогоор хүнсний тооцоолол хийж, худалдаа-9, хоол үйлдвэрлэл-10, хүнсний үйлдвэр-2, нийт 21 ААН-тэй гэрээ байгуулсан. | Дүүргийн 2023 оны хүн амын тоонд суурилж, хүнсний хэрэгцээг тооцоолж, гэрээт газруудаас мэдээ авна. | | | ХХҮХ | Дүүргийн 2023 оны хүн амын статистик тоогоор жишсэн хүн ам /117092,1/-ын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоо судалгааг шинэчилж, хүнсний зах, худалдааны төв, дэлгүүрээдээс гол нэрийн барааны нөөцийн мэдээг авч нэгтгэн, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 7 хоног тутамд хүргүүлэн ажиллаж байна.<br>Нийслэлийн Онцгой комиссын Хүнсээр хангах албанаас өгсөн чиглэл, батлагдсан загварын дагуу дүүргийн Гамшгаас хамгаалах санхүү, нөөц, хангалтын албаны хүнсний хангалтын бүлгийн төлөвлөгөөнд тодотгол хийж, худалдаа 8, хоол 10, үйлдвэр 2, нийт 20 газартай гэрээ байгуулан, гамшиг эрсдэлийн үед хүнсээр хангах бэлэн байдлыг ханган ажиллаж байна.<br>Гэрээний хугацаа дууссан худалдааны 7, хоол үйлдвэрлэлийн 8, хүнсний үйлдвэрийн 1 ААН-ийн хамтран ажиллах гэрээг сунгуулж, мэргэжлийн ангиудад заавар зөвлөгөө өгсөн.<br>Сэлбэ гол дагуу халиа дошин үүсч, шар усны үерийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан дүүргийн Онцгой комиссоос 7, 14, 15, 16, 18, 19, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт гамшгийн “Шар | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | түвшин” тогтоож, иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийг гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор эрсдэлтэй бүсэд амьдарч байгаа айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд эрсдэлийн бүсэд ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний хоол, хүнсний зардал болон гамшигт нэрвэгдсэн хүн амын хүнсний хэрэгцээг батлагдсан нормативын дагуу гаргаж, зах зээлийн үнэлгээгээр хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авах зардлын тооцоог гаргаж, ДОК-ын шийдвэрийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/290 дүгээр захирамжийн дагуу эрсдлийн үед ажилласан бие бүрэлдэхүүний болон ДОК-ийн Штабын хоол хүнсийг гэрээт Хаан бууз, Омега ХХК-уудаас татан авч, зардалд 3,662,700 төгрөг зарцуулсан.<br>Мөн үерийн гамшиг эрсдлээс урьдчилан сэргийлэх эргүүлийн ажиллагаанд дайчлагдсан дүүргийн Онцгой комиссын бие бүрэлдэхүүний хоол хүнсийг гэрээт Баталгаат хүнс ХХК-иас нийлүүлж, дүүргийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/304 дүгээр захирамжийн дагуу зардалд нийт 1,105,500 төгрөгийг зарцуулсан. | |
| 177 | НЗДҮАХ-3.3.3 ДЗДҮАХ-4.6.4 | 4.6.4. Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар сурталчлан таниулна. | Үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийн тоо | Хүнсний үйлдвэрлэл-3, худалдаа-130, хоол үйлдвэрлэл-150 | Хүнсний үйлдвэрлэл-3, худалдаа-150, хоол үйлдвэрлэл-200 | 3.0 | Дүүргийн төсөв | ХХҮХ | Монголын Ресторан Зоогийн Газрын холбоо (МРЗГХ), Баар Эрхлэгчдийн Холбоо "БЭХ"-той хамтран НЗДТГ, НАЖГ, УБЗАА-ны ХХҮГ-ын дэмжлэгтэйгээр Монголд зочлох жил-2024 онд жуулчинд олон улс, үндэстний зоогоор үйлчлэх газруудын хоолны цэсийг баялаг болгох, мэргэжлийн тогоочдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Олон үндэстний хоолны тогооч бэлтгэх" богино хугацааны сургалтад 20 гаруй аж ахуйн нэгжийг хамруулсан.<br>Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн С/77 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Жижиглэн, худалдааны газар, түүний үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS 5021-1:2024 стандартын шаардлагын дагуу GS-25 сүлжээ дэлгүүрийн 51 салбар тохирлын гэрчилгээ авч, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.<br>Хүнсний чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр улирлын чанартай түр худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд НХХААГ-ын Хяналтын хэлтэс, хороодын Ажлын албатай хамтран хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, Драмын театрын талбайн 10 явуулын хоол үйлдвэрлэлийн болон кофе шоп, зайрмагны худалдаа эрхлэгчидтэй 4 удаагийн уулзалт, хяналт шалгалт зохион байгуулж, үйлчилгээнд тавигдах шаардлага, орчны цэвэрлэгээ үйлчилгээ, хог хаягдлаа хэрхэн хаяж, иргэдэд таатай үйлчилгээ үзүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажилласан.<br>НЗД-ын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн Замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах зорилгоор богино хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай А/988 захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа томоохон зах худалдааны төвүүдийг хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан замын хөдөлгөөний оргил бус цагаар буюу 22:00-06:00 цаг, жижиг хүнсний дэлгүүрүүдийг 14:00-18:00 цагийн хооронд бараа бүтээгдэхүүнийг татан авалтыг хийж, замын хөдөлгөөний ачааллыг бууруулан хамтран ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. | 100% |
| Дөрөв.Ногоон хөгжлийн бодлого /Амьдрахад таатай сүхбаатар дүүрэг/ | | | | | | | | | | | |
| 4.1 (5.1) Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг бий болгоно. | | | | | | | | | | | |
| 178 | МУХЖТ-5.1.6, НХТЖҮЧ-6.4.1, 6.4.2 НЗДҮАХ-5.1.2 ХАХТ-5.1.2.1 ДЗДҮАХ-5.1.1 | 5.1.1 Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулна. | Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулна. | Төсөл арга хэмжээний тоо | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4, 7, 8, 16, 17-р хороодод 4 байршил нийт 1622.98м2 талбайд тохижилт хийх 421.6 сая төгрөгийн төсөвтэй 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. | Нийтийн эзэмшлийн талбайд тохижилтын ажлын төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 3,579.8 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн 3-р хороо, Орон сууцны 35, 37-р байрны гадна талбайн тохижилт 75.4 сая төгрөгөөр АРВИН ӨРГӨӨ КОНСТРАКШН ХХК, 4-р хороо, 77-р байрны тохижилт 85.7 сая төгрөгөөр АРВИН ӨРГӨӨ КОНСТРАКШН ХХК, 5-р хороо, 17-р хороо, 44-р гудамжид тохижилтыг 206.7 сая төгрөгөөр БАТЛЮКС ХХК тус бүр гүйцэтгэж дууссан. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 179 | | | 6-р сургуулийн хөл бөмбөгийн талбайн тохижилт | Талбайн хэмжээ м2 | | 1518м2 | 386.3 | Дүүргийн төсөв | ТГУХ | Тендерийн шатандаа явж байна. | 0% |
| 180 | НХТЖҮЧ-6.4.1 НЗДҮАХ-5.1.1 НХТЖҮЧ-6.4.2 НЗДҮАХ-5.1.3 ХАХТ 5.1.3.1 ХАХТ-5.1.1.1 ДЗДҮАХ-5.1.2 | 5.1.2 Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн нэмж байгуулна. | Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, тохижилт, цэцэрлэгт хүрээлэн байгуулна. | Хэрэгжилт хувиар | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төслийг боловсруулж байна. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлнэ. | 3,000.0 | Дүүргийн төсөв | ТГУХ | Сүхбаатар дүүргийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 13-р хорооны Ногоон талбайн 2, 3 гудамжинд нийт 3 га талбайд иргэдийн амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжит цэцэрлэгт хүрээлэн, дугуйн зам, спорт талбай, спортын танхимууд бүхий цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолборын төслийг хэрэгжүүлж байна. Тус ажлыг хэрэгжүүлэхээр Билгүүн монгол констракшн ХХК шалгарсан бөгөөд 2023 онд газрыг бүрэн чөлөөлж дууссан. Билгүүн монгол констракшн ХХК-н захиалгаар зураг, төсвийн ажлыг "Варм бюлдинг констракшн" ХХК зураг, төсвийн ажлыг хийж байна. Барилгын суурийн цутгалтын ажил хийгдсэн. | 100% |
| 4.2 (5.2) Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 181 | НЗДҮАХ-6.3.30 ХАХТ-6.3.30.1 ДЗДҮАХ-5.2.1 | 5.2.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, камержуулах хяналтын цогц шийдлийг нэмэгдүүлнэ. | Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд гэрэлтүүлэг хийнэ. | Хэрэгжилт хувиар | Дүүргийн 11 дүгээр хороонд 17 ширхэг гэрэлтүүлгийг 58.9 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. | Дүүргийн 11-20 дугаар хороодод шаардлагатай гэрэлтүүлгийг хийнэ. | 4,862.5 | Дүүргийн төсөв | ТГУХ | Нийслэлийн 2024 оны ОНХС-н хөрөнгө оруулалт, Дүүргийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 11, 13, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороонд 1253 ширхэг гэрэлтүүлэг хийхээр 5.1 тэрбум төгрөг батлагдсан. 15-р хороо, 1-23-р гудамжид гэрэлтүүлэг хийх ажлыг ПОВЕРТҮҮЛ ХХК, 18-р хороонд гэрэлтүүлэг хийх ажлыг ТЭНГЭР ЦЭГЦРЭЭ ХХК, 11, 13, 17, 19, 20-р хороодод гэрэлтүүлэг хийх ажлыг ИРВЭСТ ШҮТЭЭН ХХК тус тус шалгарч ажлыг гүйцэтгэсэн. | 100% |
| 182 | | | Камерын арчлалт, хамгаалалтыг сайжруулан иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Камерын асалтын хувиар | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийт 1016 ширхэг камер байна. | Камерын асалтыг сайжруулна. | 1,500.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Камерын ашиглалт хариуцсан байгууллага сонгон шалгаруулахаар бэлтгэл ажил хангаж байгаа болно. | |
| 183 | | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | Гэрэлтүүлгийн асалтын хувиар | Нийтийн эзэмшлийн гудамж талбайд 7450 гэрлийн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. | Гэрэлтүүлгийн асалтыг 99.2 хувиас дээш байлгана. | 2,378.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 7450 ширхэг гэрэлтүүлэг, төв авто зам дагуух 4437 ширхэг гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалтыг Гэрэлтүүлэг чимэглэл ХХК, Спейшл тим ап ХХК, БМЖЛ ХХК-иуд хариуцан ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт, арчлалт хамгаалалтын ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан нөхцлийн дагуу сард 3 аас доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу засвар үйлчилгээг тогтмол хийж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн асалт 99,4%-тай байна. | 100% |
| 184 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.2.2 | 5.2.2 Иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран Сэлбэ цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. | Орон сууцны хороолол доторх авто зам, гэр хорооллын хатуу хучилттай замыг нөхөж иргэдийн эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | Талбайн хэмжээ, м2 | 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1389м2 асфальтан замын нөхөөс хийгдсэн байна. | Нийтийн эзэмшлийн авто замын 10,000м2 асфальтан зам нөхсөн байна. | 500.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Орон сууцны хороолол дундах 1-11 дүгээр хорооны 2838м2 асфалтан замын нөхөөсийг Ерөөлт зам ХХК гүйцэтгэн гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. | 100% |
| 185 | | | Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон замыг засварлаж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Талбайн хэмжээ, м2 | Гэр хорооллын намгархаг, ус тогтдог сул шороон хөрс бүхий иргэд зорчиход хүндрэлтэй байдал үүссэн засварлах шаардлагатай 24728 метр зам байна. | Дүүргийн 11-20 дугаар хороонд 20.000 метр замыг засварлана. | 1,500.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн гэр хороодын бороо, шар усны үерийн улмаас эвдэрсэн гудамжны замын засварын ажил 2024.05.04-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж байна. 06 сарын 10-ны өдрийн байдлаар 15, 16, 18, 20-р хороодын нутаг дэвсгэрт нийт 52 км, 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 2024 оны 09 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл Дүүргийн 11, 12, 13, 15,17,19 дүгээр хороодод нийт 157 байршилд 80,2 км нийт 132,2км зам зассан. | 100% |
| 186 | НЗДҮАХ-5.1.2, ДЗДҮАХ-5.2.3 | 5.2.3 Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон зам, орон сууцны хороолол доторх авто замыг засварлах, | Гэр хороолold тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж хайрга, дайрган хучилт, хатуу хучилтыг шинээр хийнэ. | Хэрэгжилт хувиар | Дүүргийн 12, 13, 14, 15, 16, 18, 19, 20 дугаар хороодод 10.8 км талбайд гэр хорооллын тоосжилтыг | Шаардлагатай хөрөнгө оруултыг шийдвэрлэж хэрэгжүүлнэ. | 3,699.4 | Дүүргийн төсөв | ТГУХ | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар 20-р хороо, Сэлбэ 1-р гудамж түмэн шувуут хүртэлх тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж, хайрган хучилт хийх ажлыг РЭД КОПС ХХК, 20-р хороо, Цуурайтын аманд тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгах хайрга, дайрган хучилт хийх ажлыг НАНО ЭКОЛОГИ ХХК, 20-р хороо, Цээнэ 2-р гудамжаас | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хатуу хучилттай болгож, тоосжилтыг бууруулна. | | | бууруулж, шавар шалбааг арилгаж, хайрга дайрган хучилт хийх 1,761.8 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. | | | | | Даваатын ам хүртэлх тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгах хайрга, дайрган хучилт хийх ажлыг СИЛК ТРАСС ХХК тус тус гүйцэтгэж дууссан. Дүүргийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 13-р хорооны Рашааны 1 гудамжинд, Рашааны 2, 3 гудамжинд, Рашааны 4 гудамжинд 110.4 сая төгрөгөөр СИЛК ТРАСС ХХК, 17-р хороо, Дамбадаржаагийн 78, 79-р гудамж тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж хайрган хучилт хийх ажлыг 64.9 сая төгрөгөөр, 18-р хороо, Бэлхийн 36 гудамжны /нарийн гудамж/ тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж хайрган хучилт хийх ажлыг 62.6 сая төгрөгөөр ЭМ ЭМ РОҮД БРИДЖ ХХК, 15-р хороо, дамбадаржаа 1-7 гудамжны тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж дайрган хучилт хийх ажлыг 256.5 сая төгрөгөөр НАНО ЭКОЛОГИ ХХК, 18-р хороо, Бэлхийн 36 гудамж /ариун шүтээн дэлгүүрийн ар тал руу/ тоосжилтыг бууруулж, шавар шалбааг арилгаж хайрган хучилт хийх 52.8 сая КИОТО ХАЙВЭЙ ХХК, 18-р хороо, Бэлхийн 36 гудамжинд дайрган хучилт хийх ажлыг 126.7 сая төгрөгөөр, 20-р хороо, Сэлбийн 1 гудамжнаас сэлбийн эцэс хүртэл дайрган хучилт хийх ажлыг 230.3 сая төгрөгөөр СИЛК ТРАСС ХХК хийж гүйцэтгэсэн байна. | |
| 187 | | | Нийтийн эзэмшлийн явган замын нөхөн сэргээлтийн ажил, батлагдсан стандартын дагуу болгон өөрчлөн, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. | Талбайн хэмжээ, м2 | Дүүргийн 1-20 дугаар хороонд нийт 125,290.8 м2 талбай явган зам байна. | Дүүргийн 1-20 дугаар хороонд 10.000 м2 явган замыг засварлана. | 500.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн 6572,8м2 явган замын засвар үйлчилгээг Хансесан ХХК гүйцэтгэн гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. | 100% |
| 188 | | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн усан оргилуурын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Дүүргийн хөрөнгөд бүртгэлтэй нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 12 усан оргилуур байна. | 12 усан оргилуурын засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг хариуцан байнгын ажиллагаатай болгосон байна. | 500.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ нь 4-р хороо 69-р байрны усан оргилуур, 5-р хороо 39-р байрны усан оргилуур, 6-р хороо 12/1 байрны усан оргилуур, 7-р хороо 4, 6 байрны дундах усан оргилуурын засвар үйлчилгээг 2024.05.28-ны өдөр хийж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Хонхтой цэцэрлэгт хүрээлэн, Цэрэндоржийн гудамж, Монгол-Туркийн цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуурыг нийслэлийн Хот тохижилтын газар ОНӨААТҮГ хариуцан ажиллуулж байна. 2 байршлын усан оригдуурыг иргэдийн хүсэлтийг дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тохижилтын ажил хийхээр буулгасан, 2 усан оргилуулыг цэцгийн мандал болгон ашиглаж байна. | 100% |
| 189 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1, ДЗДҮАХ-5.2.4 | 5.2.4 Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | Хуучирч эвдэрсэн хүүхдийн тоглоом,чийрэгжүүлэлтийн төхөөрөмжийг шинээр сольж хүүхэд тоглох нөхцөлийг бүрдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | Шинээр солих шаардлагатай 10 байршилд хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн төхөөрөмж байна. | Шинээр солих шаардлагатай 20 байршилд хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн төхөөрөмж шинэчилэнэ. | 400.0 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн нутаг дэвсгэрт 14 хорооны 16 байршилд Ургамлын далай ХХК 2, 3, 10, 11, 15, 18 , 19, 20 -р хороонд хүүхдийн гулсуур бүхий 3 үйлдэлт тоглоом, 1, 4, 5, 6, 7, 8, 10, 11-р хороонд 5-6 үйлдэлтэй хүүхдийн чийрэгжүүлэлтийн төхөөрөмжийг байршуулсан. | 100% |
| 190 | | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | Тоо хэмжээ, м2 | 1-20 дугаар хорооны 186 байршлын 123254.34м2 талбайн сүүдрэвч, 4505м2 хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайн тохижилт бүтээн байгуулалтын ажлын засвар, цэвэрлэгээ үйлчилгээг хийж байна. | 1-20 дугаар хорооны 186 байршлын 123254.34м2 талбайн сүүдрэвч, 4505м2 хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайд засвар, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулна. | 1,905.3 | Дүүргийн төсөв | ТНААХ | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 186 байршлын 123254,34м2 талбайн 153 ширхэг сүүдрэвч 4405 м2хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайн засвар үйлчилгээг хийлгэхээр 12 бүс болгон аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 7 хоногт 3-4 удаагийн давтамжтайгаар цэвэрлэгээ, үйлчилгээг хийлгэн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
